

MONGOLIAN ECONOMY

Амьдрал ямар байна вэ?

“Газрын ховор элемент уул
уурхайн бизнес биш”

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл

2012. 01 сар. №002 (012)

www.mongolianeconomy.mn




Оюу Толгой
цатгана!

Таван Толгой
хөлжүүлнэ!

Улс
хөгжинэ!

Өлсөөд
байна аа!

Нэн ядуугийн
ангал руу нийтээрээ
гулсах вий



Naran Motors Co.,Ltd



Sheer
Driving Pleasure

www.bmw.mn



PRINCIPLES OF LEADERSHIP.

BMW 7 Series. Inspired by the core principles that take leaders from success to success.



NIPPON PAINT



Япон улсын 130 жилийн түүхтэй
алдартай NIPPON PAINT
барилгын брэнд будаг
Монголд албан ёсоор
орж ирлээ.

DEREN[®]
COLOR

Tel: 5525-4867
9908-7412
www.deren.mn



Beijing National Stadium



CCTV Building-Beijing



Sanzai Villa-Ulaanbaatar



Shanghai World Financial Center

Агуулга

Нэн ядуугийн ангал руу нийтээрээ гулсах вий



Хэсгийн ахлагч Д.Алтантуяагийн хэлснээр эзэнгүй айлын эзэд нь бүгд л хоногийн хоолоо олох гэж хаа нэгтээ яваа байж таарах нь... 8

Буйдхан гэртээ багтамгүй гэгээлэг мөрөөдлийн эзэд



Жавар хайрсан жихүүн өдрүүдэд нуруухүйт дааж, хацар хайрагдах хэдий ч бөхөшгүй сэтгэлийн гал, няцашгүй зүтгэлийн урам Зоригтын гэр бүлийг дааруулах нь үгүй... 14

Үндэсний мөрөөдөл



Т.Намжим “Засгийн газрын тогтоол гарсан. Төр, хувийн хэшлийн оролцоотойгоор үйлдвэрийн барилгын ажлыг энэ хавар эхэлнэ” хэмээн чихэнд чимэгтэй шинэ мэдээлэл дуулгалаа... 17

Эдийн засаг

- 6 Амьдрал ямар байна вэ
- 8 Нэн ядуугийн ангал руу нийтээрээ гулсах вий
- 12 Хүнсээ цуглуулна аа
- 14 Буйдхан гэртээ багтамгүй гэгээлэг мөрөөдлийн эзэд
- 17 Үндэсний мөрөөдөл
- 19 Нефть импортлогчдыг өмгөөлөх нь бас үгүйсгэх нь
- 22 Монголын төр хаанаас эхэлдэг вэ

Санхүүгийн зах зээл

- 24 “Хар хун”-гийн сүрэг айлчлах уу?
- 26 Төвбанкны валютын нөөцөлд ханшийн тэгшитгэл хийх нь зөв үү?

Уул уурхай

- 27 “Газрын ховор элемент уул уурхайн бизнес биш”
- 30 Эдийн засагт мандаж буй нар

Ногоон эдийн засаг

- 32 “Өнөөдөр би ажилдаа нийтийн тээврээр ирсэн”
- 34 Тогтвортой хөгжье
- 36 Утааны голомтод УИХ-ын гишүүдтэй хамт
- 38 Хамгийн ойрын тэргүүн туршлага өмнө нь байхад яагаад...
- 40 2011 оны хамгийн ирээдүйтэй ногоон технологийн үйл явц, шийдлүүд

“Газрын ховор элемент уул уурхайн бизнес биш”



...Үс нь халзарч, шүд нь унасан, үр тариа нь хорчойж хатсан, хорт хавдраар нас барагсад ихэссэн гэхчилэн олон тооны гомдол санал манай урд хөршид тасардаггүй байна. ...27


“Өнөөдөр би ажилдаа нийтийн тээврээр ирсэн”



“Ногоон эдийн засгийн өсөлт” ТББ-ын тэргүүн “Эко-Ази” дээд сургуулийн захирал Ц.Адъяасүрэнтэй ногоон эдийн засгийн талаар ярилцлаа... 32

Бизнес

- 41 Эрэлт ба нийлүүлэлтийн тавцан
- 43 Ажлын багийг хэрхэн зөв бүрдүүлэх вэ?
- 44 Таны амьдрал, үзэл бодолд өөрчлөлт авчирсан номоо нэрлэнэ үү?



Онцлох сэдэв

Амьдрал ямар байна вэ?

И.Отгонжаргал

Саяхан бензиний үнэ нэмэгдэх үеэр бөөн л дуулиан шуугиан болсон. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр ямар ч их бичив дээ. Бүр залхмаар их хөндлөө. Шатахууны үнийг нэг литр тутамд нь 270 гаруй төгрөгөөр огцом нэмсэн болоод ч тэр үү, одоо хэрнээ шуугиан бүрэн намжаагүй л байна. Засгийн газраас шийдвэр гаргаж, дээрх үнийг 50 төгрөгөөр бууруулчихаад байхад шүү. Гэхдээ бид мэргэжлийн түвшний тэр тусмаа эдийн засгийн сэтгүүл эрхлэн гаргагчдын хувьд тэрхүү шатахууны “үнийн дайнтай” холбоотой мэдээлэлд бусад хэвлэл шиг яаран дааран орохыг хүссэнгүй. Нэгдүгээрт, сэтгүүлийн маань шинэ дугаар гарсан байж таарсан. Хоёрдугаарт, үнийн өсөлт хийгээд үйл явдлыг хэт улстөржүүлсэн учраас байдлыг харснаж энэ удаагийн дугаартаа асуудлыг өөр өнцгөөс илүү бодитоор харж бичихээр шийдсэн хэрэг.

Бензиний үнэ зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойших өнөөдрийг хүртэлх хугацаанд түүхэнд байгаагүйгээр огцом хөдөлсөнтэйгээ адилхан төр, засгийнхны үнийн өсөлтийн эсрэг авч хэрэгжүүлсэн шийдвэр ч огцом, омогтой байв. Холбогдох газар, агентлагийн тус бүр хоёр, нийт дөрвөн удирдлагыг ажлаас нь шууд халж, хатуухан хариуцлага тооцлоо.

Харин үнэхээр зөв юм боллоо гэж алга ташин хүлээн авсан хүн хэр олон байсан юм бол оо гэдэг л байна. Асуудал нь өөрөө улс төрийн шийдлийн эгзэгтэй эргэлзээтэй үед үүссэн учраас замбараагүй улстөржилт явагдав. Яг энэ моментыг овжин ашигласан нь нефтийн бүтээгдэхүүн импортлогчдын тактик ч байж болох талтай. Дөрвөн удирдах ажилтны халаа сэлгээний хажуугаар хэргийн эзэн хэнгэргийн дохиур ЭБЭХ-ний дэд сайд Б.Ариунсан мөнөөсөө мөн. Ам.долларын

ханшийг барьж чадаагүй бензиний үнийг огцом өсгөх нөхцөл байдалд хүргэсэн Монголбанкны ерөнхийлөгч Л.Пүрэвдоржийг суудлаас нь авъя гэсэн улс төрийн шинжтэй үйл явдал хөвөрсөн учраас Засгийн газрын зүгээс алдаа гаргасан хүмүүстэй хэдийгээр өмнө нь байгаагүйгээр хатуу зоримог харицлага тооцсон ч олон түмэнд үнэлэгдэх ир нь хурц биш байсан гэж хэлж болох юм.

Мөн хэвлэлийнхэн бүгд нефтийн бүтээгдэхүүн импортлогчид руу үзэг, микрофон, дуу хураагч гээд байдаг бүх зэвсгээ чиглүүлээд ч үнийг олигтой бууруулж дийлсэнгүй. Тэдний бичиж нийтэлсэн зүйл бензиний үнийн өсөлтийг далимдуулан өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ эрхлэгчид үнийн хөөс үүсгэхэд нэрмээс болсон уу гэхээс нэмэр болж чадаагүй болов уу. Уг нь бол сэтгүүлчид маань үнийн өсөлттэй холбоотой эдийн засаг, нийгмийн эмзэг асуудалд аль болох зөв өнцгөөс бодит мэдээлэлтэй хандах аваас худалдаа наймаа эрхлэгчид, ченжүүд өнөөдрийнх шиг “Бурхангүй газрын бумба галзуурна” гэгчээр дуун дээр үнэ өсгөж дураараа аашилж чадахгүй юм. Гэтэл хэвлэлийн бид аливаа үйл явдлыг хэт сенсаацлаг байлгах талаас нь хардаг гэмтэй учраас ялангуяа үнийн өсөлт мэтийн асуудалд нийгэм, эдийн засагт гарах сөрөг үр дагаврыг нь өчүүхэн ч бодолцохгүй байгаа нь эргээд иргэдийн нуруун дээрх ачааг хөнгөлөх биш, улам бүр дааж даважгүйгээр хүндрүүлээд буй.

Сонгууль ойртчихсон болохоор УИХ-ын 76 гишүүн маань үнийн өсөлтөд санаа зовж, шийдэхээсээ илүүтэй яаж улстөржүүлж, сонирхолтой болгох вэ гэдэг үүднээс л “шохоорхож” байгаа нь сая тодорхой харагдлаа шүү дээ. Ийм үед ямагт үнэний дуу хоолой болох учиртай сэтгүүлч бид л ажлаа сайн хиймээрсэн. Муу төр, засагтай байж дээр нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийнхэн муу ажилласан учраас сүүлийн жилүүдэд Монголд баян, хоосны ялгаа улам бүр гаарч, иргэдийн амьдрал тартагтаа тулж байгааг “Mongolian Economy” сэтгүүл харуулахыг хичээлээ.

Үнийн өсөлт иргэдийн нуруун дээр ямар том бул хар чулуу болон буусныг манай сэтгүүлийн “Амьдрал” булангийн сурвалжлагаас сонирхоорой. Хувьдаа хөл дүүжлэх унаатай, ажил гэр хоёрынхоо хооронд хааяа яарч даарсан үедээ такси барьчихдаг нийгмийн дундаж амьдралаас дөнгөн данган зүүгдэж байгаа иргэд яах вэ. Ийн болгож яваа хүмүүсийн олонх нь хувийн болон хөлсний дулаан байр орон сууцанд тухтай амьдраад болж байгаа.


Гэтэл нийслэлийн нийт иргэдийн талаас илүү хувь нь оршин суудаг гэр хорооллын айл өрхүүдийн дийлэнхийнх нь амьдрал ямар хүнд, зовлонтой байгааг манай нэг бус сурвалжлага, нийтлэлээс харах болно. Машинаар явж байхад сардаа нэг удаа банкны үүдэнд бөөн унаа тэрэг зогсоохихсон уртаас урт дараалал үүсгэн

зогсоо тэр борог амьдралтай иргэдийн ард ямар их өвчин эмгэг, өлсгөлөн байна вэ. Манай сэтгүүл хоёр дахь дугаартаа яг энэ чиглэлээр монголчуудын амьдралын түвшин өдрөөс өдөрт доошилж, ядуурч байгаа тухай сурвалжлагыг нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооноос хийж байсан. Бараг бүтэн нэг жилийн дараа дахин ядуурал ямар байгааг сурвалжилсан нь энэ. Төр, засаг, албан ажилтай хүмүүсийн түвшинд л эдийн засгийн их өсөлт, хүн бүрийн 536 ширхэг хувьцаа, хөрөнгийн биржийн хөгжил цэцэглэлт гэж яриад хөөрөөд байгаа болохоос бодит байдал дээр ажилгүйдэл, ядуурал, архидалт, өвчин эмгэг бүр л их газар авч байгаа нь илт. Бид энэ сэдвийг цаашид байнга бичиж, авч явах болно.

Түүнчлэн УИХ, Засгийн газар, холбогдох төрийн байгууллагынхны анхаарлыг бодит амьдрал руу хандуулахыг хичээн ажиллана. Ялангуяа хууль тогтоогч, бодлого тодорхойлж, шийдвэр гаргагчид ард түмний амьдралыг мэдэж байх учиртай. Тэгж байж улсын бодлого, хөгжил зөв явах ёстой болов уу. Тиймээс манай сэтгүүл ирэх сарын эхний дугаарыг тогтвортой хөгжилд чиглүүлнэ. Ингэхийн тулд тогтвортой хөгжлийн үндсэн гол асуудлуудын нэг болох цэвэр агаар, ая тухтай амьдрах орчин хаана байна вэ гэдгийг төр, засгийнхантайгаа хамтдаа хайцгаана. Тэгэхийн тулд ойрын хугацаанд төр, засаг, холбогдох албаны хүмүүсийг Улаанбаатар хотын утааны голомтод хамтдаа очиж, иргэд маань ямар агаараар амьсгалж, ямар орчинд амьдарч байна вэ гэдгийг биеэр мэдрээсэй гэсэн уриалга гаргаж буйгаа дуулгая.

“Mongolian Economy” сэтгүүл, “Ногоон эдийн засгийн өсөлт” төрийн бус байгууллагын зүгээс зохион байгуулах уг арга хэмжээний хүрээнд зөөлөн буйдан, жийп машины суудлаас төдийлэн хөндийрдэггүй Ерөнхийлөгчийн Тамгын газар, УИХ, Засгийн газар, холбогдох агентлаг, газрынхан, Улаанбаатар хотын дарга нарыг нэг орой нийтийн тээврийн унаагаар зорчиж, гэр хорооллын нүүгэлтсэн хар утаатай агаараар хэсэгхэн хугацаанд амьсгалж үзээсэй гэж хүсэж буй юм. Зайсан, Их тэнгэрийн ам зэрэг харьцангуй цэвэр агаартай газарт амьдардаг нь тэдний буруу биш. Эрүүл мэндээ бодох нь хэн бүхний л анхаарах асуудал. Тэд бас төрийн их ажил гээд тун завгүй явдаг хүмүүс. Түшээдийг гэртээ ирээд зурагтаа үзэхэд нь ард түмний амьдрал ямар байгаа, ядуурал яаж нэмэгдэж байгаа, Улаанбаатарын утаа багасах биш, улам ихсэж байгааг бодитоор харуулж, “Хүүе энэ чинь ийм байгаа юм уу” гэж мэдэж авах мэдээ мэдээлэл дутмаг байгаа учраас тэд амьдралаас тасархай байгаа хэрэг.

Тийм болохоор манай “Mongolian Economy” сэтгүүл, “Economy” телевизийн студи, www.mongolianeconomy.mn цахим хуудас, “Ногоон эдийн засгийн өсөлт” төрийн бус байгууллагын зориглон барьж авч, хийх ажил энэ байх юмаа. ■



Амьдрал

Нэн ядуугийн ангал руу нийтээрээ гулсах вий

Э.Зоригт

Монгол Улсын ядуурлын түвшин буурах биш, өнгөрсөн оны сүүлчээр өсч 40 орчим хувьд хүрсэн тухай Үндэсний статистикийн хорооноос гаргасан билээ. Дээрээс нь хэдхэн хоногийн өмнө бензиний үнэтэй холбоотойгоор бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ өссөн. Мөн Монголбанкнаас гаргасан сүүлийн судалгаагаар инфляцийн түвшин Улаанбаатар хотод 11 хувьтай гарсан. Манай сэтгүүл удаагийн “Амьдрал” буландаа өнөөдөр нийслэлчүүдийн амьдрал тэр дундаа гэр хорооллын иргэдийн амьдрал ямар байгааг сурвалжлан хүргэж байна.

Гэр хорооллын гудамж эзэнгүй мэт эл хуль. Хаа сайгүй золбин ноход хоол хайн шогшиж, дуу өгөн боргох аж. Хар хэрээ жалгын хогон дээр суучихаад өвлийн хүйтэнд вааглах нь айдас хүргэх шиг. Утаа үнэртэж, ханхай оргисон гудамжаар уулын орой дээр шахуу барьсан хар гэр рүү ганцаараа бол хэзээ ч явж зүрхлэхгүй байсан биз. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 12 дугаар хороо буюу “Дэнжийн мянга”-ын 11 дүгээр хэсгийн ахлагч Д.Алтантуяагаар газарчлуулж явах үеэр

гэр хорооллын иргэдийн амьдрал үнэхээр хүнд байгаа талаар хүүрнэх түүний ярианд миний бие нүдээр үзэхээс нааш итгэхэд бэрхтэй санагдана. Зорьсон айлынхаа гадна ирж, хашааных нь хаалгыг цохилоо, харуу алга аа. Дахиад цохилоо бас л аниргүй. Уг нь энд Нарая гэх олон хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэй амьдардаг гэнэ. Гэхдээ хэсгийн ахлагчийн хэлснээс үзэхэд тэрбээр хоногийн хоолоо залгуулахаар гарсан бололтой. Хэдийгээр зүдрүүхэн амьдардаг боловч гурван хүүхдээ сургуульд сургаад байдаг талаар хэсгийн ахлагч нь урамшингүй ярих. Уулын бэл, жалгын аман дээр барьсан олон хар гэрийн хашааны үүдэнд хэсгийн ахлагчийг дагуулан очсон боловч бүгд эзэнгүй байх аж. Ганц, хоёр айл эзэнтэй мэт боловч хаалгаа тайлж өгсөнгүй. Хэсгийн ахлагч Д.Алтантуяагийн хэлснээр эзэнгүй айлын эзэд нь бүгд л хоногийн хоолоо олох гэж хаа нэгтээ яваа байж таарах нь. Амьжиргааны түвшин доогуур иргэд ямар ч байсан зүгээр сууддаггүй аж. Бид хоёр “Дэнжийн 1000”-ын дундаж түвшний айлуудын нэгэнд нь орохоор боллоо.

Өвөл, баяр хоёр

Халуун сүүтэй цай аягалж, найрсаг зангаар угтсан настай эрийг М.Бөмбөг гэдэг. Арваад жилийн өмнө яг одоо амьдарч байгаа 11 дүгээр хэсгийн 1007 тоотод суурьшжээ. Гэхдээ “Дэнжийн 1000”-тай амьдралаа холбосон нь 30 гаруй жилийн түүхийг агуулах гэнэ. Бөмбөг гуай өдгөө 70 нас хүрч яваа. Эхнэр, дөрвөн ач, хоёр охиныхоо хамт амьдардаг. Олон жаахан хүүхэдтэй гэхэд сүрхий цэвэр цэмцгэр айл байв. Биднийг ороход гэрийн эзэн ганцаараа галаа түлэхээр гээд сууж байлаа. Эхнэрийнх нь бие муудаад дүүргийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа аж. Ач нар нь сургуульдаа явжээ. Охид нь мөн ажил төрөлдөө эртээ гэгч гарч. Том охин нь хонуутаар ажилласан гэнэ. “Гэхдээ авдаг цалин нь 200 мянган төгрөг. Өөрт нь ч хүрэхтэй, үгүйтэй байдаг. Хоол, унааны мөнгөндөө ч хүрдэггүй. Ийм цалинтай, зав чөлөө олгодоггүй ажлаасаа гарч, өөр ажил олжхий” хэмээн охиндоо хэлдэг хэмээн Бөмбөг гуай ярих. Унаа хоолны мөнгөнд өдөртөө 3000 төгрөг зарцуулахаар



тооцоход сардаа 300 мянган төгрөг арай гэж хүрэх тооцоог өвөө гаргаж амжжээ. Тиймээс заримдаа цалин нь хоол, унааны зардалд нь хүрэхгүй өр тавихад хүрдэг байна. Харин бага охин нь хорооны ажилтан бөгөөд сардаа 140 мянган төгрөгийн цалинтай. Бас

л эгчээсээ дээрдэх юмгүй. Тиймээс дөрвөн ачаа эмээ, өвөө хоёр нь тэтгэврийнхээ хэдээр болгодог байна. Энэ гэр бүлийн өмсөж зүүх, идэж уух, нүүрс, түлээ бэлдэх бүгд л хоёр хөгшний тэтгэврийн 360 гаруй мянган төгрөгт багтах учиртай. Бөмбөг гуай ▶▶

► “Манайх чинь энэ хороо хариуцсан хүүхдүүдийн хэлж байгаагаар “Дэнжийн мянга”-даа болж бүтээд байгаа дундаж түвшний айлын тоонд багтаж байгаа юм гэсэн шүү дээ, чааваас гэж. Уг нь бол наймын найман ам бүл хоёр хөгшний тэтгэврийн хэдэн бор юмаар амьдарна гэдэг ч мөн чанга шүү дээ. Гэхдээ яах вэ “Хүний хөгжил сан”-гийн 21 мянган төгрөг хүн бүрийн ойр зуурын хэрэгцээнд бас нэмэр болоод байна. Энэ хэдэн ач нар үнэгүй сургуульд сураад байгаа мэт боловч өглөө бүр л унаа, хоолондоо хамгийн багадаа 1000 төгрөгөөс эхлээд л анги засвар, ханын сонин хийх, анги цэвэрлэгээ гээд авах татаас нь дийлдэхгүй. Намайг одоо мөнгөний машин гэж бодоод байх шиг байгаа юм. Ямар ээжийнх нь олсон мөнгө хүүхдүүддээ нэмэр болох биш” гэв.

Эхнэрийнх нь бие тааруу учраас Бөмбөг өөрөө хүнсний бүтээгдэхүүнээ цуглуулахаар “Хүчит шонхор” захыг долоо хоногтоо гурван ч удаа зорьдог. Тэрбээр сүүлийн үед өргөн хэрэглээний барааны үнэ өссөнд баахан бухимдангүй сууна. 400 төгрөгөөр авдаг байсан нохойн хоол нь хүртэл 500-650 төгрөг болчихсонд гайхаш нь тасраад байгаа аж. “Хаягдал” мах түүгээд нохойн хоол болгоод зарж

байгаа хүмүүс бензинээр ажилддаггүй байлтай” хэмээн бухимдсан нь нээрээ ч оноод хэлчих шиг санагдав. Тэрбээр өмнө нь тэтгэврийн мөнгөө буухаар 15 кг будаа, хоёр шуудай гурил, 10 литр тос авчихдаг байсан бол өнөөдөр 10 кг будаа, хоёр шуудай гурил, таван литр тос авдаг болжээ. Сардаа хоёр гурван ч удаа толгой цувдай иддэг аж. Энэ талаар гэрийн эзэн “Манайхан гэртээ цувдай идэхээр муу хоол идлээ гэж боддог. Харин ч хаа нэгтээ үнэтэй ресторанд ороод таван цулын шөл уухаараа үнэтэй сайн гэж бодно. Энэ бол буруу сэтгэлгээ. Манай ач нар ч гэсэн тэгээд байдаг болж. Хэтэрхий цамаан” гэсэн юм.

За тэгээд нэг сарын гэрэл, цахилгааны төлбөр нь 60 гаруй мянган төгрөг гардаг байна. “Хүний хөгжлийн мөнгөө авах, эхнэрээ эмнэлэгт үзүүлэх, халамж үйлчилгээний газраар явж бичиг баримт бүрдүүлэх, замын түгжрэлд орох гэсэн дөрвөн том бөглөөнд амьдралын хамаг цаг үрэгдэж байна даа, хүү минь” хэмээн тэрбээр хошигнон хэлэх. Хэдийгээр хошигнол мэт санагдах авч ахмад настай, амьдралын арвин туршлагатай хүний хувьд тэрбээр өнөөгийн нийгмийн иргэдийг хамгийн их бухимдуулж, стресстүүлж буй асуудлуудыг нэгтгээд

ийн товч бөгөөд тодорхой өгүүлрүүн.

Үнэхээр эмнэлэг, халамж үйлчилгээний газраар эргүүлддэг олон хүн үүнтэй санал нийлэх байх шүү. Хүний хөгжлийн 21000 төгрөгөө аваад зарцуулах нь сайхан ч банкны үүдэнд хонон өнжин дугаарлана гэдэг хүн бүрийн хувьд хамгийн зүрхшээх зүйл болчихоод буй.

Өвлийн улирал, тэмдэглэлт баяр Бөмбөг гуайн хувьд өрхийн төсөвт нь “бөмбөг” тэслэх шиг болдог ажээ. Учир нь, ганц улирлын түлээ нүүрсний хэрэглээ нь өрхийн орлогын бараг талаас илүүг нь аваад явчихдаг байна. Тэмдэглэлт баярын тухайд бол өр тавьж л аргыг нь олдог тухайгаа нуулгүй хэлсэн. Удахгүй сар шинийн баяр болох гэж байгаа учраас тэтгэврийн зээл авах талаар бодож байгаа гэнэ.

Ийм нэгэн амьдралтай айлаас гараад Алтантуяа хэсгийн ахлагчийн зөвлөснөөр шууд 12 дугаар хорооны байранд очиж иргэдтэй уулзахаар боллоо. Тус хороо нь он гарсаар амьжиргааны түвшин доогуур иргэдэд “Эко эргүүл” гэх ажлын байр шинээр бий болгосон аж. Энэ нь орчны хог цэвэрлэх ажил бөгөөд сардаа 140 мянган төгрөгийн цалинтай юм байна. Тиймээс ажилгүй, ядруухан амьдралтай иргэд хороогоороо холжих нь их.

Ээж шигээ хүн битгий болоорой

Зургийн аппаратны маань дуран хүртэл цүнхнээс цухуйлгангуут цантаад зураг авч болохгүй хүйтэнд нүцгэн гараараа хог түүн зогсох 50 орчим насны эмэгтэйг Д.Октябрь гэдэг. Ам бүл дөрвүүлээ бөгөөд сарын орлого нь 140 мянган төгрөг. Хүний хөгжлийнхөө 63 мянган төгрөгийг нэмэх юм бол 203 мянган төгрөгт хүрэх гэнэ. Тэрбээр нөхөртэй боловч нүд муу гэх шалтгаанаар ажил хийдэггүй ажээ. Мөн иргэний үнэмлэхний 45 насны сунгалтаа хийлгээгүйн улмаас бичиг баримт хөөцөлдөхөд хүндрэлтэй тулгарч групп тогтоолгож ч чадахгүй байгаа юм байна. Иргэний үнэмлэхгүй учраас Хүний хөгжлийн 21 мянга ч авах эрхгүй суугаа аж. Заримдаа олсон жаахан мөнгөөр нь нөхөр нь бор дарс зооглочихдог байна. Ядуугийн зовлон дээр архи ууж, агсам согтуу тавих нь түүнд тун хэцүү байдаг талаар Д.Октябрь бүсгүй гунигтай ярина. Найзынх нь хэлж байгаагаар нөхөр нь архи уугаад зогсохгүй эхнэртээ гар хүрдэг аж. Инфляцийн “галзууралтай”



өнөө үед 200 мянган төгрөг гэдэг дөрвөн ам бүлийн аманд ч үгүй хамарт ч үгүй мөнгө. Октябрийн найз гэх улаан хацартай, огцомхон дуутай Урнаа гэгч эмэгтэй “Манай Октябарь манийгаа бодвол гайгүй амьдарч байгаа. Хүүхдүүд нь өсчихсөн. Нэгдүгээр гурил,

үхэр, хонины мах идэж байна шүү дээ” гэсэн юм. 200 мянган төгрөгийг яаж хүргээд байдаг нь сонин. Энэ талаар Д.Октябрь “Зээлэхдээ зээлнэ. Заримдаа ажлын хажуугаар “Хүчит шонхор” захын махны наймаачдад тусалж, шанд нь жаахан мах авна. ►

► Гурилын худалдаачдад туслах юм бол хагас килограмм гурил авах гээд л урд хормойгоороо хойд хормойгоо нөхнө ш дээ” гэв. Түүний том охин нь арваннэгдүгээр анги, бага нь долдугаар ангид сурдаг байна. Хэмнэлт гаргах үүднээс оройдоо л ганц удаа гал түлдэг ажээ. Охидууд нь хичээлдээ яваад өдөр гэр нь эзгүй байдаг учраас тэр. Харин гэр бүлээрээ амарч байгаа тохиолдолд хоногт хоёр заримдаа гурван шуудай нүүрс түлдэг. Өнөөдөр нэг шуудай нүүрс 1500 төгрөгийн үнэтэй байна билээ. Харин бөөний үнэ нь 1200-1000 төгрөг байсан. Гэхдээ тэд нүүрсээ бөөнөөр нь авах мөнгө байхгүй учраас ширхэгээр үнэтэй нүүрс авахаас өөр аргагүй байдаг

аж. Түүнчлэн хаашаа ч явсан барагтай бол нийтийн тээвэрт сууж мөнгө төлөхийг боддоггүй алхаад л явчихдаг байна. Мөн гэр бүлийн гишүүд өдөр барагтай бол цайлдаггүй. Тиймээс ч орой ганц удаа хооллохдоо хоёр хүүхдээ гайгүй зүйлээр гэдсийг нь цатгах гэдэг ээжийн өдөр бүрийн зорилго. Гэхдээ бас л хэмнэх хэрэгтэй. Нэг идэхийг хоёр болгох нь энэ гэр бүлийн гэм биш зан болжээ. Саяхан Октябрийн цалин бууж “Хүчит шонхор” зах ороод үхрийн мах авах гэтэл нэг кг нь 5000 төгрөгийн үнэтэй болсон байжээ. Тиймээс ямааны мах авч. Хөргөгчгүй учраас өдөр өдөрт нь идэх махаа бага багаар нь авдаг аж. Ер нь ганц мах ч гэлтгүй тухайн өдөр идэх, хэрэглэх

зүйлээ өдөр өдөрт нь л авдаг. Мөнгөгүй учраас маргаашийн идэх талхаа өнөөдөр авах хүсэл байвч боломж байхгүй. Өдөртөө 10000 төгрөгөөр идэж уухаа болгодог байна. 10000-аар бодоход энэ өрхийн сарын хэрэглээнд наад зах нь 300 мянган төгрөг хэрэгтэй.

Эдийн засаг өссөн, иргэн бүр Тавантолгойн 1072 хувьцаа эзэмших болсон гэдгийг сонсохоос цаашгүй ийм иргэд өнөөдөр хэдний өдөр гэдгээ ч мэдэхгүй өдрийн хоолоо олох гэж зүтгэж яваа энэ эмэгтэйн мөрөөдөл том байшинтай болох гэсэн. Хоёр охиндоо захидаг үг нь “Ээж шигээ хүн битгий болоорой” гэнэ билээ.

Баярын үеэр хааяа талх иддэг

“Дэнжийн мянга”-ын 12 дугаар хорооны иргэн Л.Баянжаргал өдгөө 60 орчим настай өрх толгойлсон эмэгтэй. Өдөр өдрийн нарыг хүүхдүүдийнхээ буянаар сайхан амьдарна гэсэн мөрөөдлөөр хардаг түүнтэй ярилцсан юм.

-Сайн байна уу Та. Амьдрал ямар байна вэ?

-Хүү минь чи харж байна шүү дээ./чигчий хуруугаа гозойлголоо/

-Танайх ам бүл хэдүүлээ вэ?

-За байз миний долоон хүүхэд. Хүргэн, бэр дөрөв. Таван ач тэгээд би гэхээр 17-уулаа амьдардаг.

-Тэгээд бүгд нэг дор байдаг юм уу?

-Тэгэлгүй дээ. Манайх түрээсийн жижиг таван ханатай гэрт амьдардаг юм. Тэгээд л бүгдээрээ оройдоо цуглаж унтаад л өглөө нь тал тал тийш гараад явна даа.

-Гэр бүлийн гишүүдийн ихэнх нь ажил хийдэг үү?

-Үгүй ээ. Эмээ нь “Эко эргүүл” хийгээд сарын 140 мянган төгрөг авдаг. Хоёр охин маань ажил хийдэг. Нэг нь хүнсний захын ойролцоо “Дамчаагийн” цайны газар ажиллаад 102 мянган төгрөг авдаг гэсэн. Харин нөгөө охин маань үсчин хийдэг юм. Хэдэн төгрөгийн цалинтай гэдгийг сайн мэдэхгүй байна. Эмээ нь мөнгө л олж өгөхөөс өөрөөр мөнгөнд нь хошуу дүрэх биш.

-Танай хамгийн том хүүхэд хэдэн настай вэ? Яагаад ажил хийдэггүй юм бол.

-Манай том хүү 36 настай. Ажил олдохгүй л юм гэнэ ш дээ. Зун бол яах вэ барилгын ажил хийгээд мөнгө



олно оо. Бусад нь бас ялгаагүй ажил олдохгүй юм гээд хоосон гуяа ганзагалаад ирдэг. Цаад байгууллага нь өнгө зүс, нуруу туруу хараад байдаг сурагтай байна билээ.

-Эмээ танайх юуны махаар хоол хийдэг вэ?

-Энэ олон хүнийг тэжээхэд мөнгө их орно ш дээ хүү минь. Одоо чинь тэгээд ч юмны үнэ нэмэгдээд хэцүү байна. Тийм болохоор манайх нэг жижиглэн иж бүрдэл мах /малын дотор махны цуглуулга/ нэг нь 350 төгрөг гэдэг юм. Тэрнээс хоёрыг авна. Бас шуудай нь 500 гээд махныхны шулсан яс авна. Тэрнээсээ хэдийг хийгээд хоёрдугаар гурилаа зуураад л гурилтай шөл хийж иднэ дээ. За даа бараг орой бүр л нэг иймэрхүү байдлаар хооллодог.

-Өдрийн талх, нүүрсний мөнгөө яаж болгож байна вэ?

-Өдөртөө барагтай бол гал түлэхгүй. Орой л гал түлнэ. Талх ямар идэх биш. Манай хэдэн ач нар талх гэж мэдэхгүй байх шүү. Баярын өдрөөр хааяа талх иддэг юм.

-Хүний хөгжил сангийн 21 мянган төгрөгөө авна биз дээ. 17 хүний мөнгө гэхээр нэлээд хэдэн төгрөг цугладаг юм байна, тийм үү?

-Хүний хэрэгцээ гэдэг чинь барагдах биш. Ихэнхдээ дор бүрнээ аваад үрчихдэг юм шиг байна билээ. Ач нарын зарим нь авахгүй. Гэхдээ яах вэ сардаа нэг нь ч гэсэн өөрийн дураар мөнгөө зарж л байг дээ. Эмээ нь бол авахгүй цуглуулж байгаад баярын үеэр гаргаж ирээд тавгийн чихэр ч болох нь ээ авдаг. Зарим хүүхэд маань бас цувуулж аваад гурил будаагаа залгуулна аа.

-Удахгүй Цагаан сар болох гэж ►

► байна. Баярыг яаж шуухан тэмдэглэж өнгөрөөдөг вэ?

-Жаахан цуглуулсан юм бий хүү минь. Тэрүүгээрээ тавгийн чихэр хэдэн бууз хийнэ дээ. Болдогсон бол энэ жилийн Цагаан сараар хонины ганц хаа ч болтугай нь чанаад тавьчих санаатай байна.

-Хүүхдүүдийн хувцас хунарт их мөнгө зарцуулагдана биз дээ?

-Өө тэгж их мөнгө зарлагдаж хувцас өмсөхгүй. Хувцас авлаа гэхэд, Солонгос комисс ороод л хямдхан юм түүчихдэг.

-Та өрх толгойлсон эмэгтэй гэсэн тийм үү?

-Тиймээ нөхөр салаад явсан/хоолой нь зангирлаа/. Уг нь манайх тийм ч ядуу зүдүү айл байгаагүй юм. Нөхөр салснаас хойш бие муудаж хэдэн хүүхэддээ анхаарал хандуулах минь цалгардаад амьдрал уруудсаар ийм л болчихсон. Эгч нь барилгын засалчин хүн л дээ. Гэхдээ хүн зовлон даадаг бололтой... гээд хоолой нь чичирч нүүрээ бурууллаа. Ярих сонирхолгүй байгаа бололтой нулимсаа хүчлэн залгаад хорооны байрнаас гарч одлоо. Хэсгийн даргын хэлснээр Л.Баянжаргал тэтгэвэр тогтоолгож чадахгүй байгаа гэсэн.

Уйлж яваа эр хүн

Д.Нямдаваа өчигдөр уйлж явсан сурагтай хэмээн 10 дугаар хэсгийн ахлагч М.Энхтуяа санаа зовнисон байртай хэн нэгнээс хариулт нэхэн зогсоно. Учир нь, Нямдаваа тус хэсгийн нэн ядуу өрх аж. Тэрбээр эхнэр гурван хүүхдийн хамт амьдардаг. Эхнэр нь бие муутай бөгөөд том охин нь ар гэрийн гачигдлаас болж сургууль завсардсан аж. Түүний уйлсан шалтгаан нь өчигдөржин "Хүчит шонхор" захын махны наймаачдад тусалж мах зөөж хэдэн кг мах хөлсөндөө авчээ. Тэгээд эргээд харахын хооронд нь гар урттай нэгэн арайхийн олсон жаахан махыг нь хулгайлаад явчихсан аж. Хэд хоног олигтой хоол идээгүй гэрийнхэндээ шинэ махаар шөл хийж өгөх гэсэн түүний баяр дээр арчаагүй нэгэн нь ус цацчихаж. Тэгээд л Нямдаваа ховорхон үзэгдэх эр хүний нулимсаа унагасан нь тэр ажээ.

Зөв явбал зөөлөн замбуулин

Золбин ноход хоол хайн шиншилж яваад Наранхүүгийн зарж байгаа нохойн хоолны дэргэд ирчихээд хулгайн нүдээр түүн рүү харна. Нийтийн

тээврийн хүнд дугуй тоормослох, Наранхүүгийн "Жов" гэж нохдыг хөөх дуун орчны анирыг эвдэх аж. Энэ бүсгүй Чингэлтэй дүүргийн 12 хорооны 10 дугаар хэсгийн нэн ядуу нэгэн ээж. Өдөртөө нохойн хоол зараад наймааны одтой байх юм бол 3000 төгрөг олох нь түүний хувьд баярлуштай зүйл. Харин Ж.Наранхүү түүний ганц охины оройн хоол 200 төгрөгөөр зардаг хонины өвчүүний шулсан яс, атга будаа. Өчигдөр оройн хүнсээ авах гээд зах ортол нөгөө 200 төгрөг байсан өвчүүний үнэ 450-500 төгрөг болоод өсчихөж. Энэ үнэ түүний маргааш өлсөх эс өлсөхийг шийдэж чадахгүй эргэлт. Тэр санаа алдаад аялах дуртай "Зөв явбал зөөлөн зөөлөн замбуулингаа" дуулаад л захаас гарлаа.

10 дугаар хэсгийн ахлагч М.Энхтуяа "Наранхүүд зовлон мундахгүй. Ганц охиноо хүний зэрэгтэй байлгахын тулд

хичээл сургуульд нь анхаарал халамж сайн тавьдаг. Гэхдээ гэрлийн мөнгөө төлж чадахгүйн улмаас цахилгаанаа таслуулчихсан байгаа. Охин нь гэрийн даалгавраа хийхэд хүндрэлтэй тулгараад байгаа гэсэн үг. Лаа авч байгаа ч 300 төгрөг тэр бүр зарлагдах нь хэцүү. Дээрээс нь Болд гэж нэг нөхөр Наранхүүгийн хашааны хаалгыг таглаад томоо гэгч хашаа барьчихсан" гэсэн юм. Энэ талаар Наранхүү хэсгийн ахлагчдаа уйлан байж мэдэгджээ. Хэсгийн ахлагч нь Болд гэгчид шаардлага тавьсан хэдий ч болох бүтэхгүй хараал хэлж, хөөгөөд гаргасан гэнэ. Дээрээс нь долоо хоногийн өмнө буух ёстой байсан Хүний хөгжлийн 21 мянган төгрөг түүнд хүлээлт үүсгээд байгаа аж. Ядуу хүний зовлон дуусахгүй юм. Гэхдээ Наранхүү бүсгүй "Зөөлөн замбуулин"-гаа дуулж, инээгээд л хорвоогийн бор өдөр, шар нарыг туулж явна.

Өнөөдөр нохойн хоол 650 төгрөг гэж байхад 350 төгрөгийн жижиглэн, хоёрдугаар гурил, шулсан ясаар өл зогоож яваа айл өрх "Дэнжийн мянгад" олон. Зарим нь бүр хоосон хонож ч байна. М.Энхтуяагийн хэлснээр түүний хариуцаж авсан хэсэгт ийм өрх айл цөөнгүй гэсэн. Олон нялх хүүхэдтэй, бичиг баримтгүй гэх шалтгаанаар Хүний хөгжлийн 21 мянга ч авч чаддаггүй олон ээж хүүгийнхээ хамт хаа нэгтээ лааз түүгээд явж байгаа гэсэн шүү.

Хүний хөгжил сангийн 21 мянган төгрөг олгох нь архины мөнгө болоод дуусдаг гэх яриа байдаг. Гэвч энэ мөнгө 10 дугаар хэсгийн 20 гаруй өрх толгойлсон эмэгтэйн амьдралд томоохон тус болдог юм билээ. Ер нь хэсэг бүрт дунджаар 20 гаруй өрх толгойлсон эмэгтэй байдаг аж. Хэсгийн ахлагч болон цагдаа А.Батзориг нарын хэлж байгаагаар "21000 төгрөг буухаар архи уудаг нэг хэсэг байхад, ууддаггүй ч нэг хэсэг бий. Тухайлбал, 12 дугаар хорооны 20 дугаар хэсгийн ихэнх иргэн 21 мянган төгрөгөө авахаараа архидах нь элбэг" гэв. Ер нь ажиглаад байхад түр оршин суугч гэх бичиг баримтгүй, харъяаллын бус иргэд архи уух, хов жив гаргах нь их байдаг талаар мөн хэлж байлаа.

Бид үнийн өсөлт иргэдэд хэрхэн дарамт болж байна, ер нь иргэдийн амьдрал ямар байна вэ гэдгийг Нийслэлийн гэр хорооллын захын хороогоор орж сурвалжлахад л ийм байна. Монгол Улс маань төр, засгийн хэмжээнд үсрэнгүй хөгжил, эдийн засгийн өндөр өсөлт яриад сайхан байж болох ч ард түмний амьдрал ямар хүнд байгааг дөнгөж сургуулиа төгссөн залуу сэтгүүлч хүний хувьд нүдээр үзээд үнэхээрийн сэтгэл зүрх шимширсэн.

Бид хамгийн хүнд амьдралтай өрхүүдтэй газрыг олъё гэж ярилцаж тохиролцоод Чингэлтэй дүүргийн 12 дугаар хороог сонгочихоогүй болохоор нийслэлд тус хорооноос ч илүү олон ядуу өрх, хүнд амьдралтай хүмүүстэй хэчнээн хороо байгаа бол оо гэж бодохоор хоол ч идэх сонирхолгүй. Чингэлтэйн 12 дугаар хороонд 13700 гаруй иргэн оршин суудаг. Тэдний 80 гаруй хувь нь амьжиргааны түвшин доогуур амьдралтай талаар хэсгийн ахлагч нарын судалгаагаар гарсан байна.

Аль л хямд төсөр идэх зүйлээр голоо зогоож яваа тэдний хувьд өдөрт гурван удаа хооллож, таксигаар зорчино гэдэг бол мөрөөдөл. Талхны үнэ 50 битгий хэл таван төгрөгөөр нэмэгдсэн ч тэдний хувьд том цохилт. Гэр хорооллын "гэрэлгүй" амьдралын талаар товчхон сурвалжлахад ийм байна. Иргэдээ нийтээр нь увайгүй ядуу болгочихгүйн тулд бидэнд бичих, бодох зүйл их байна аа, сэтгүүлчид ээ гэж мэргэжил нэгт нөхдөдөө уриалмаар санагдлаа.

Нэн ядуугийн ангал руу гулсаж буй нийгмийн нэг хэсгийн амьдралыг бодох тоолон сэтгэл, зүрх минь шимширсээр. ■

Хэтэвч

Хүнсээ цуглуулна аа

Инфляцийн түвшин 11 хувьд хүрч, бензиний үнэ огцом өсөж, төгрөгийн худалдан авах чадвар буурч буй энэ үед манай сэтгүүлч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болох 140 мянган төгрөгөөр “Хүчит шонхор” хүнсний захаас хүнс цуглуулсан юм. Ингэхдээ дундаж амьдралтай айлын хүнсний хэрэглээн дээр тулгуурласан болно. /2012.01.20-ны байдлаар/



Төмс /Монгол/-900 төг-5 кг
Лууван /Монгол/-800 төг-2 кг
Байцаа /Монгол/-1000 төг-2 кг
Сонгино /Монгол/-800 төг /-1 кг

БҮГД 9900 төг

140.000₮

Үхрийн мах нэг кг нь 5.000 төг

10 кг-50.000 төг



“Мельник” гоймон

5кг-5000 төг



“Алтан тариа” нэгдүгээр гурил

25 кг-14.500 төг



Арвайн гурил-1.200 төг

н эг кг-1200 төг



“Сакура” цагаан будаа кг нь 2000 төг

10 кг-20.000 төг



“Олейна” ургамлын тос

5 литр-12.500 төг



Элсэн чихэр

нэг кг -1600 төг



Давс /Иоджуулсан-Монгол/

350 төг



"Найман гишүүн төгөлдөр цай"

2500 төг



Кетчуп

3300 төг



Савласан сүү

Нэг литр-1650 төг



Хиам /"Мах импэкс"-Аянчин/

Нэг кг-9500 төг



Өндөг /ОХУ/ - 230 төг

10ш-2300 төг



Нийт дүн: 134.300 төгрөг

2012 оны нэгдүгээр сарын 18-ны байдлаар Улаанбаатар хотын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн барааны үнийг өнгөрсөн оны 12 дугаар сартай харьцуулахад 7.4 хувиар өссөн байна. Харин өмнөх долоо хоногийнхоос 0.2 хувиар буурсан дүн гарчээ.

		хэмжих нэгж	"Баянзүрх" зах	"Номин" Хайпер-маркет	"Хүчит шонхор" зах	"Бөмбөгөр" ХТ	"Меркури" зах	"Барс" ХТ	"Таван эрдэнэ" зах	"Хар хорин" зах	"Миний" Дэлгүүр	"Макс" Супер-маркет	
1	"Алтан тариа" задгай гурил	дээд	кг	800	919	850	800	800	850	800	929	860	
		1-р зэрэг	кг	650	799	700	600	600	700	700	744	772	
		2-р зэрэг	кг	550		500	550	480	550	550	622		
2	"Алтан тариа" савласан гурил	дээдийн дээд	кг	1000	1129	1100	1000	1300	950	1100	1000	1190	1100
		дээд	кг	850	969	850	800	1000	850	900	900	990	1000
		1-р зэрэг	кг	750	799	700	700	900	700	750	700	760	810
3	"Алейка" гурил	дээд	кг	800	969	950	750	800	950	900	1046	978	
		1-р зэрэг	кг	700		700	700	700	700	700	700		
4	Хятад дээд гурил	кг	850		900		800		850				
5	"Атар" талх	ширхэг	630	640	680	630	700		650	640	640	640	
6	Сүү	литр	1200		1200				1300				
7	Будаа	цагаан	кг	1700	1919	1600	1500	1900	1500	1600	1500	1800	1750
		шар	кг	1600	1790	1600	1400	1500	1500	1700	1500		1850
8	Цэцгийн тос, ОХУ	кг	2900		2900	3000		2900	3200	2800		2750	
9	Ургамлын тос	1 литр	2700		2600	2600	2900	2700	2800	2600		3580	
10	Элсэн чихэр	кг	1600	1890	1600	1500	1800	1500	1700	1600	1800	1980	
11	Хонины мах	ястай	кг	4500		4400	5000	5800	4800	5400	4800	5350	
		цул	кг	4800		4900			5200	5700	5000		
12	Үхрийн мах	ястай	кг	5000		5000	5800	6200	5300	5600	5200	5450	
		цул	кг	5800		5800	6500	6800	5800	6000	5800	6300	
13	Адууны мах, ястай	кг	4500		4300	4500		4400	4500	4300			
14	Ямааны мах, ястай	кг	4200		4100	4200		4200		4200			
15	Нөөцийн мах	Үхэр	кг									3700	
		Хонь	кг									3200	
		Ямаа	кг									2600	
16	Төмс	монгол	кг	1000	999	900	1000	1000	800	1100	900	930	1100
		хятад	кг	600		500	700		500	700	600		
17	Лууван	монгол	кг	1000	999	800	1000	1000	800	1000	700		1200
		хятад	кг	700		600	800		700		500	700	
18	Байцаа	кг	1000	999	900	900	1000	900	1000	800		1000	
19	Манжин	кг	1000		800	1000	1200	1000	1000	900			
20	Сонгино, хятад бооронхий	кг	1000	799	800	1000	1000	1000	1000	900	1140	1200	
21	Өндөг, ОХУ	ширхэг	280	285	230	240	280	230	260	250	275	260	

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо



Фотог Б.Бямба-Очир

Өрхийн төсөв

Буйдхан гэртээ багтамгүй гэгээлэг мөрөөдлийн эзэд

Б.Ууганбаяр

“Өвдөг сөхөрч унаснаас өндийн босож үхсэн нь дээр”

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг харсан хэн ч болов дэмий л “хөөрхий, эвий” гэж өрөвдөх харц чулууудах нь бий. Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй ч хэний ч гар харахгүй, чадлынхаа хэрээр ажиллаж хөдөлмөрлөхийн зэрэгцээ харааны бэрхшээлтэй иргэддээ ажлын байр бий болгож яваа үлгэр жишээ гэр бүлийг манайх энэ удаагийн “Өрхийн төсөв” буландаа сонголоо. Социализмын үед Хараагүйчүүдийн үйлдвэртэй цуг баригдсан хараагүй хүмүүст зориулсан Хан-Уул дүүргийн III хороонд байрлах дөрвөн давхар нийтийн байрны 43 тоотод Д.Зоригтын өнөр гэр бүл амьдардаг. Он цагийн эрхэнд дотор, гаднагүй өнгө зүсээ

алдсан уг байрны нэг айл байх ёстой гурван өрөөнд гурван өөр айл амьдардаг байна. Ойролцоогоор 10 орчим ам метр болов уу гэмээр өрөөнд Д.Зоригтынх тохиожээ. Эхнэр, нөхөр хоёр гэртэйгээ залгаа шахуу байрлах хараагүйчүүдийн үйлдвэрт анх танилцаж, ажил амьдралын гараагаа эхэлсэн түүхтэй.

Гэрийн эзэн Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт үйлдвэрлэлийн төвийн Жижиг эдлэлийн цехийг ахалж, байгууллагынхаа Үйлдвэрчний эвлэлийн хорооны даргын албыг давхар хашдаг. Харин эхнэр Б.Сундуйдэмчиг нь цаанаа л нүдэнд дулаахан, нүүр дүүрэн инээмсэглэсэн хүн байв. Тэрбээр тун ч чамбай хичээнгүй эмэгтэй бөгөөд хэдийгээр харааны бэрхшээлтэй ч өөрийгөө дайчлан

сэтгэл зүйчээр “Оргил” дээд сургууль, номын сан судлаачаар “Соёлын дээд” сургуулийг тус тус дүүргэжээ. Мэргэжлийнхээ дагуу 2004 оноос Харааны бэрхшээлтэй хүүхдүүдийн 116 дугаар сургуульд номын санчаар ажиллаж буй. Тэрбээр “Амьдралаа хүний дайтай авч явж, хоёр хүүхдээ мэдлэг боловсролтой болгохын төлөө олсон хэдэн төгрөгөө зөв зарцуулахыг л хичээж явна даа” хэмээн инээмсэглэн ярина. Тэгвэл одоо тус өрхийн төсвийг сонирхуулъя. Нөхөр нь сард 260 мянган төгрөгийн цалинтай бөгөөд эрүүл мэнд, нийгмийн даатгалаа хасаад гар дээрээ 220 орчим мянган төгрөг авдаг байна. Харин эхнэр Б.Сундуйдэмчиг нь төсвийн байгууллагад ажилладаг учраас гар дээр ирэх цалин нь нөхрийнхөөс нь арван мянган төгрөгөөр ▶▶



Д.Зоригт ажлын байрандаа



“Бест массаж-5” төв үйлчлүүлэгчээр тасардаггүй

бага. Дээр нь гэр бүлийн хоёрын хөгжлийн бэрхшээлтэй сар тутмын тэтгэмж тус бүр 105 мянган төгрөг нэмэгдэнэ. Харин том хүү Өөдөс нь бас ээж, аав хоёртойгоо адил харааны 80 орчим хувийн алдалттай тул группын мөнгө 53000 төгрөг авна. Дээр нь Хүний хөгжлийн 21 мянган төгрөгийг дөрвөн ам бүлээр тооцохоор сардаа 800 мянган төгрөгийн орлоготой аж. Гэхдээ энэ орлого дээр нэмэгдэх мөнгө бас бий. Гэр бүлийн бичил бизнес буюу хоёр жилийн өмнөөс эхнэр Б.Сундуйдэмчигийн санаачлан ажиллуулж эхэлсэн “Бест массаж-5” төвөөсөө сард дунджаар 150-200 мянган төгрөгийн орлого олдог гэсэн. Тэгэхээр эднийх сардаа нэг сая төгрөгийн орлоготой гэсэн үг. Энэ бүх мөнгө ээжийн хэтэвчинд хуримтлагдаж, түүний төлөвлөгөө, шийдвэрийн дагуу дараагийн сарын цалин хүртэл захиран зарцуулах ёстой. Харин бага охин нь ээжийнхээ туслахын үүргийг гүйцэтгэж, төсвийн тооцоо гаргах, хоол хүнсээ цуглуулж, төсвийн зарцуулалтын талаар заримдаа ээждээ хүртэл зөвлөдөг сүрхий хүүхэд.

“Хоёр хүүхэд маань голдуу сургууль дээрээ өнждөг болохоор өдөрт тус бүр 2000 төгрөг өгөхгүй бол санаа зовоод

байдаг юм” хэмээн ээж нь өгүүлэв. Харин хэрсүү нь дэндсэн хоёр хүүхэд нь ээжийнхээ өгсөн мөнгийг хоолонд зориулах биш, хичээлдээ шаардлагатай зүйлээ хувилуулах, ном авах зэрэгт зарцуулдаг. Гэхдээ хоолны мөнгөө ийн хэрэгтэй зүйлд зарцуулсныгаа ээждээ мэдэгдэхийг огтхон ч хүсдэггүй. Харин баригдвал Сундуйдэмчиг хоёр хүүхдээ “Эрүүл биед саруул ухаан оршдог” гэдэг болохоор эрүүл хоол унд ид гэсэн мөнгийг зориулалтынх нь зүйлд зарцуулах ёстой. Тэгж байж эрүүл энх, эрч хүчтэй байна шүү дээ” хэмээн зэмлэх, ухааруулахыг зэрэгцүүлж үглэх нь бий.

“Сарын хүнсээ хоёр хувааж цуглуулдаг бөгөөд хоёр хүүхдээ үйлдвэрийн талх, боорцгоор таслахыг хүсдэггүй. Манайх нэг их үнэтэй хүнс худалдаж авдаггүй ээ. Тэгэх юм бол сарын төсөв хэтрээд талийна шүү дээ. Мах, гурил, будаа, хүнсний ногоо зэргээ “Барс” захаас цуглуулдаг. Ер нь хоол хүнсэнд сардаа дор хаяж 200-300 мянган төгрөг зарцуулдаг. Тэгэхээр юмны үнэ өсөж байгаа энэ үед аль болох л хэмнэлттэй байж, гал алдчихгүй байхыг хичээж байна” гэдгээ гэрийн эзэгтэй нуусангүй. Зарим үед хүүхүүд нь утсаа хаях ч юм уу,

төлөвлөгдөөгүй баяр ёслол тэмдэглэх зэргээр гэнэтийн зардал гарч ирж төсөв захирагчийг сандаргах нь бий.

Өрхийн тэргүүнээс олж байгаа орлого нь амьдралд нь хэр зэрэг хүрэлцдэгийг сонирхоход “Одоогоос тав, зургаан жилийн өмнө бол өнөөдрийн манайх шиг орлого амьдралд хангалттай хүрэлцэх байсан байх. Өдрөөс өдөрт юмны үнэ нэмэгдэж байгаа энэ үед мэдээж тийм ч хангалттай биш. Ёстой “Хоёр идэхгүй хоосон хонохгүй” л болж байна даа” гэв. Харин оюутны 500 мянган төгрөг, Хүний хөгжил сангийн 21 мянган төгрөг тэдний амьдралд ихээхэн нэмэр болж байгааг бүгд л онцлон хэлж байсан.

Удахгүй Монгол түмний уламжлалаа дээдэлж, ах дүүстэйгээ амар мэндээ мэдэлцдэг үндэсний баяр Цагаан сар болох гэж буйтай холбоотойгоор гэрийн эзэгтэйтэй хөөрөлдлөө. Тэрбээр “Энэ сарын орлого ч бараг тэр чигээрээ Цагаан сарын хоол хүнс, идээ будаанд явах байх даа. Одоо манайх ямар ч байсан ууцаа авсан. Сүүгээ ч гэсэн хямдхан байхад нь аваад хадгалчихсан. Энэ мэтээр Цагаан сардаа зах зухаас нь бэлдэж л байна” хэмээн сонирхууллаа. Хэдийгээр харааны бэрхшээлтэй ч ▶▶

хичээнгүйлэн хөдөлмөрлөж яваа энэ гэр бүл Шинэ жил, Цагаан сар зэрэг зарлага ихтэй баярыг мөнгө төгрөг хайж сандралгүй бусдын жишгээр боломжийн тэмдэглэчихдэг нь илт.

Эрүүл саруул хүнийг бодвол хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд Монголд ажиллаж амьдрах орчин хүнд. Наад зах нь өндөр хөгжилтэй орных шиг “ярьдаг” гэрлэн дохио, зориулалтын зам байхгүй болохоор болгоомжтой байхгүй бол машинд шүргүүлэх эрсдэл өндөртэй. Түүнчлэн нийтийн тээврийнхэн буудлаа зарладаггүй тул буруу зөрүү буух тохиолдол олон гарна.

Нөгөө талаас сурч боловсрох орчин ч хангалтгүй. Баррель эсвэл том үсгээр хэвлэсэн ном, сурах бичиг байдаггүй, бор зүрхээрээ сурдаг гэдгийг ч З.Өөдөс хүү хэлж байсан.

“Мөнгөгүй хүн ядуу биш, мөрөөдөлгүй хүн ядуу”

“Нарт хорвоод мэндлээд нэгэн насыг элээх энэ амьдралаа хүний дайтай авч явахыг хичээж явна даа. Нөхөр бид хоёр хэзээ ч харааны бэрхшээлтэй гэж өөрсдийгөө гоочлон бусдаас хараат амьдрахыг хүсдэггүй. Энэ амьдралдаа сэтгэл хангалуун байдаг. Харин ч харааны бэрхшээлтэй гэдгээ бусдад аль болох мэдэгдэхгүй байхыг хичээдэг. Амьдрал надад хангай шиг түшигтэй хань, хоёр хөөрхөн алаг үр заяасан болохоор би их азтай хүн. Тиймээс хэзээ ч зовлон бэрхшээлд шантарч бууж өгдөггүй. Харин ч хоёр дахин эрс зоримог, тууштай тэмцэж, хөдөлмөрлөхийг зорьдог” хэмээн Сундуйдэмчимэг мөрөөдлөөсөө хуваалцлаа.

Буйдхан гэртээ багтамгүй гэгээлэг мөрөөдөл, хүсэл тэмүүллийг эндээс л мэдэрсэн юм. “Эзэн хичээвэл заяа хичээнэ” гэдэг зүйр үг энэ гэр бүлийн уриа нь. Цаг ямагт хөдөлмөрлөж, амьдралаа өөрийн гараар цогцлоон бүтээхийг зорьж, тэмүүлж яваа эхнэр, нөхөр хоёроор үнэхээр бахархмаар. Том хүү Өөдөс, охин Одгэрэл нь ч ээж, аавынхаа энэхүү шаргуу, хариуцлагатай зан чанарыг өвлөн авчээ.

Хүү Б.Өөдөс нь СУИС-ийн Соёл судлаач, багшийн гуравдугаар дамжаанд сурдаг, сургуулийнхаа шилдэг оюутны нэг гэдэг нь гэрийнхээ хананд өлгөсөн олон өргөмжлөлөөс харагдаж байв. Тэрбээр “Би улс орныхоо соёл урлагийн салбарыг дэлхийн хэмжээнд аваачихын төлөө оюун ухаанаа дайчлан судлах, судлаач болохыг

мөрөөддөг” хэмээн хэрсүүхэн ярилаа. Харин охин З.Одгэрэлийн хувьд Нийслэлийн 15 дугаар сургуулийн төгсөх ангийн сурагч. Одгэрэл сургуулиа төгсөөд Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж, Японы Осакагийн их сургуульд бизнесийн удирдлагын чиглэлээр бакалавр төгсөөд, цаашлаад Америкт магистр хамгаалж, дэлхийд эх орныхоо нэрийг гаргасан шилдэг эдийн засагч болохыг хүсдэг аж. Ээж нь “Залуу наснаасаа мэргэн ухаан, авьяас чадварыг л өвлөж ав, түүнээс илүү найдвартай хөрөнгө хаа ч үгүй” гэж хүүхдүүддээ хэлдэг гэнэ. Тийм ч болохоор саяхнаас охиныхоо гадаадад сурах мөрөөдлийг нь биелүүлэхийн тулд англи хэлний сургалтад явуулж эхэлжээ. Тэрбээр идэж уух, өмсөж зүүхээсээ өмнө хоёр хүүхдийнхээ оюунд л хөрөнгө оруулалт хийхийг илүүд үздэг гэдгээ хэлсэн. Харааны бэрхшээлтэй ч хичээн сурч байгаа хүүхдээ хараад аав ээж хоёр нь улам их эрч хүчийг авч, тэднийхээ төлөө хөдөлмөрлөх урам зориг ордог ажээ.

“Алаг хорвоод төрсөн минь учиртай” хэмээн нэрт яруу найрагч Б.Явуухулангийн шүлэг байдагчлан энэ хорвоод хүн болж төрснийхөө учрыг гүйцэлдүүлэхийн тулд Зоригтын гэр бүлийн гишүүн бүр шаргуу хөдөлмөрлөж, зорилго тавин, түүндээ хүрэхийн төлөө тэмцэж байна. Хоёр хүүхдээ хүний дайтай явуулж, сайн мэргэжил боловсрол эзэмшүүлж, мөрөөдөлд хүрэх гүүр болох эхнэр, нөхөр хоёрын хамгийн эрхэм зорилго. Дараагийнх нь массажийн төвөө өргөжүүлэх. Лизингийн зээл аваад ч болтугай ажлын байраа өргөжүүлж, дөрвөн ажилтан дээрээ олон хүн нэмж авч ажлын байраар хангах нь энэ гэр бүлийн удаах зорилго юм. Дээр нь Сундуйдэмчиг мэргэжлийнхээ дагуу массажийн төвийнхөө дэргэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх кабинет байгуулан ажиллах зорилгодоо ханцуй шамлан оржээ. Харин гэрийн эзэн Зоригт “Муу ханийгаа 20 жил хажуу өрөөнд амьдрууллаа. Одоо ямар ч байсан лизингийн зээл хөөцөлдөж байгаад, байр авах санаатай байна. Хүүхдүүд ч том болоод энэ буйдхан өрөөндөө багтаж, шингэхгүй хичээл номоо хийхэд нь ч төвөгтэй байх шиг санагддаг” хэмээн эр хүний уужуу сэтгэлээр тайван өгүүлэнгээ ажлаа дуусч, гэрийн зүг алхлаа.

Өвчтэй, эсвэл ирээгүй хүн байна уу?

Энд өрхийн тэргүүний ажлын байр болоод хамт олных нь талаар цухас өгүүлэхгүй өнгөрч боломгүй санагдана. Хараагүй хүмүүсийн сургалт, үйлдвэрлэлийн төв дотроо Цаасан уут, Жижиг эдлэл, Зөөлөн эдлэл, Шүүр, Цахилгаан, Сав баглаа боодол гэсэн таван тасгаас бүрддэг байна. Энд 130 орчим хүн ажиллагдийн 80 гаруй нь хараагүй. Тэдний тал хувь нь жижиг эдлэлийн цехийн дарга Д.Зоригтын командад ажилладаг. Тус төвийн ажлын голыг нь нугалдаг газар бол Жижиг эдлэлийн цех нь. Эдний цехийнхэн төвийнхөө гол брэнд бүтээгдэхүүн болох монгол гэрийн дээвэр, туурга, өрх, унины сагалдрага, оосор, бүч зэргийг үйлдвэрлэдэг.

“Өнөөдөр хэдүүлээ хоёр гэрийн эсгий хийх даалгавартай байгаа шүү. Хичээж ажиллаарай, нөхөд өө. Өвчтэй эсвэл ирээгүй хүн байна уу? хэмээн асууж, хүмүүсээ нэрсээр нь дуудаж бүртгэлээ. Энэ бол Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт, үйлдвэрлэлийн төвийн Жижиг эдлэлийн цехийн ажлын шинэ өглөө эхэлж буй дүр зураг юм.

Нарийн ажиллагаа шаардсан гэрийн эсгий эдлэлийн үйлдвэрлэлийг тэд хараатай хүн шиг л сурамгай гэгч нь шуурхайлан хийх аж. Тэднийг зүүгээ хэрхэн сүвлэх бол оо гэдэг надад тун сонин байв. Гэтэл учиг нь дуусахад, зүүгээ сүвлэхдээ торж байгаа хүн нэг ч харагдсангүй. “Ер нь хүмүүс өөр өөрсдийнхөө арга барилаар зүүгээ сүвлэдэг” хэмээн цехийн дарга Зоригт инээмсэглэн хэллээ. Түүний хувьд тус үйлдвэрт идэр залуу 20 наснаасаа эхлээд өдгөөг хүртэл ноормчноос авахуулаад тасгийн дарга, цехийн даргаар тасралтгүй ажиллаж байгаа болохоор ажилчид нь даргадаа ам сайтай байдаг юм билээ.

Хэдий энэ хорвоог тольдох гэгээн мэлмийгээр дутаж яваа ч өнөөдөртөө гомдоллож, өөрийгөө гоочлох биш, харин хэний ч өмнө нүүр бардам алхаж, байгаа бүхнээ бусдад илүүчлэн гар сунгах харамгүй сэтгэлийг өвөртөлсөн оюуны мэлмий тэдэнд бий. Жавар хайрсан жихүүн өдрүүдэд нуруу хүйт дааж, хацар хайрагдах хэдий ч бөхөшгүй сэтгэлийн гал, няцашгүй зүтгэлийн урам Зоригтын гэр бүлийг дааруулах нь үгүй. “Хаашаа явахаа мэдэж байгаа тэр хүнд л дэлхий ертөнц зам тавьж өгдөг” гэдэг дээ. Тэгвэл бидний зочилсон айлын хойморт дулаан сэтгэл, дундрашгүй мөрөөдөл бурхан адил бат бөх байр суурь эзэлжээ. Монголын өрх тусгаар бүхэнд, монгол хүний зүрх бүхэнд Зоригтын шиг хүсэл мөрөөдөл дүүрэн байг. ■



Хүнд аж үйлдвэр

Үндэсний мөрөөдөл

Б.Баяртогтох

Монголбанкнаас гаргасан өнгөрсөн оны гадаад худалдааны тоймоос үзэхэд нефтийн бүтээгдэхүүний импорт 2011 оны мөн үеэс 1.7 дахин өссөн дүнтэй гарчээ. Өөрөөр хэлбэл, нефтийн импортын биет хэмжээ 2010 оноос 21.7 хувиар, дундаж үнэ 35.2 хувиар тус тус өссөн байна. Эндээс үзэхэд нефтийн бүтээгдэхүүн манай улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн гол хөшүүрэг болчихож. Өнгөрсөн он жилүүдэд нефть импортлогчид, Монголын нийт хэрэгцээг хэл амгүй хангаад, бид ч сэтгэл амар яваад байж болдог байжээ. Гэтэл хөгжил дэвшилтэй холбоотойгоор ялангуяа нефтийн бүтээгдэхүүний импортын хувьд шинэ, шийдвэртэй бодлого хэрэгжүүлэхгүй бол тун горьгүй болсон нь саяхны бензиний үнэ огцом нэмэгдсэн үйл явдлаас тодорхой харагдсан билээ. Үүнтэй холбоотой бидэнд олон сонголт байхгүй. Харин ганцхан зам бий. Энэ нь газрын тос

боловсруулах үйлдвэртэй болох.

“Үнийн дайн” дэгдээсэн нефть импортлогчдын балагтай шийдвэртэй холбоотой олон асуудал нийгэмд өрнөсөн. Одоо ч шуугиан нь бүрэн намжаагүй л байна. Тэгсэн хэрнээ энэ үйл явдалтай холбоотой УИХ дээр ч, Засгийн газрын танхимд ч нефтийн үйлдвэр барих талаар нэг ч үг унагахгүй байгаа нь хачирхалтай. Мэдээжийн зүйл гээд ярихгүй орхисон уу, эсвэл сонгууль ойртсон болохоор мэдэн будилаад үлдээв үү гэдэг эргэлзээтэй. Бид нефтийн үйлдвэртэй болох асуудлыг дахин сөхөж байна. Монголд нэг бус нефтийн үйлдвэр барих төсөл нэлээд хэдэн жилийн өмнөөс яригдсан. Хэдийгээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр байн байн бичигддэг хуучин сэдэв ч хэрэгтэй цагт нь хэн ч тоохгүй байгаа учраас асуудлыг сэргээхийн буруу байхгүй болов уу. Газрын тосны үйлдвэр байгуулах асуудал уланд гишгэгдэж

хоцорсон уу, урагшаа дөтөлж байна уу гэдгийг түлхүү сонирхъя.

Өнгөрсөн хугацаанд Дорнодын Зүүн баян, Улаанбаатар хотын Рашаант өртөө, Багахангай дүүрэг зэрэг газарт жижиг хэмжээний үйлдвэр барих төслүүд дуулдсан ч чихэнд цэцэг ургуулаад өнгөрсөн нь нэг хоёроор тогтохгүй. Эдгээрийн дундаас арай ч алга болчихдоггүй, үе үе яригддаг нь мөнөөх академич Т.Намжимийн Дархан-Уул аймагт барих үйлдвэр.

Тус аймгийн Хонгор суманд байгуулах тус газрын тосны үйлдвэр нь 600 сая ам.долларын өртөгтэй. Хоногт 44 мянган баррель, жилд хоёр сая тонн газрын тос боловсруулж, 1.7 сая тонн шатахуун үйлдвэрлэх боломжтой аж. Энэ төслийн ажил сүүлийн үед хэр урагштай яваа талаар “Монголсекию” компанийн захирал доктор, профессор Т.Намжим “Засгийн газрын тогтоол гарсан. Төр, хувийн хэшлийн оролцоотойгоор үйлдвэрийн барилгын ажлыг энэ хавар эхэлнэ” хэмээн чихэнд чимэгтэй шинэ мэдээлэл дуулгалаа. Мөн тэрбээр “Манай үйлдвэр ашиглалтад орсноор эхний ээлжинд 600 гаруй хүний ажлын байр бий болно. Японд газрын тосны чиглэлээр 50 гаруй хүн сургахаар болсон. Мөн 200 гаруй ажилтанг Япон мэргэжилтнүүд дотоодод сургана. Жилдээ 700 тэрбум төгрөгийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Улсын төсөвт жилд 260 гаруй тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх техник эдийн засгийн тооцоо гарсан” гэж нэмж тайлбарлав.

Одоогоор “Дархан газрын тос” компанийн төрийн хувь оролцоог тодорхой болгохоор ТӨХ, ҮХШХ, ЭБЭХЯ, “Монголсэкию” компанийн төлөөлөл багтсан Ажлын хэсэг байгуулагдсан ч өнөөг хүртэл аль аль талынх нь хувь оролцоо тодорхой болоогүй байна. Намжимийн тайлбарласнаар тус төсөлд Японы “Марубени”, “Тоёо инженеринг” корпораци оролцохоор болсноо мэдэгдсэн гэнэ. Үүнээс гадна Монголын нефть импортлогч “Жаст” групп, “Петровис”, “Магнайтрейд” “Монголсэкию” компани хамтарсан консорциум байгуулж “Дархан-газрын тос” компанийг байгуулж, дээрх төслийг хэрэгжүүлэхээр болжээ. Үйлдвэрийг 2015 оны зургадугаар сард ашиглалтад оруулахаар төлөвлөжээ.

Японы “Марубени” компани хөрөнгө оруулалтын асуудалд анхаарч байгаа бол “Тоёо инженеринг” корпораци үйлдвэрийн ТЭЗҮ, тоног төхөөрөмж, ▶

технологийн асуудлыг шийдэж, түлхүүр гардуулж өгөх хүртэлх гүйцэтгэлийн ажлаар төсөлд оролцох ажээ. Харин үйлдвэр барихад шаардлагатай 600 сая ам.долларыг жилийн 3.5 хувийн хүүтэйгээр Японы Засгийн газрын Олон улсын хамтын ажиллагааны банкнаас зээлэхээр болсон байна. Үйлдвэрийг гурван жилийн хугацаанд барих бөгөөд 14 дамжлагатай байхаар тооцжээ.

Газрын тосны үйлдвэр байгуулах талаар ЭБЭХЯ-ны Түлшний бодлогын газрын орлогч дарга Н.Болдхүүтэй уулзлаа. Тэрбээр “Чойр, Сайншанд, Дархан, Зүүн баян, Дорнод, Эрдэнэтэд газрын тос боловсруулах жижиг хэмжээний үйлдвэр барихаар дөрвөн компанид эрх олгосон. Нийтдээ 600 мянгаас нэг сая хүртэлх тоннын хүчин чадалтай үйлдвэрийг 2014-2016 оны хооронд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. Эхний үйлдвэр 2014 онд ашиглалтад орно” гэлээ. Харин үйлдвэр барих ажил хэт удаашралтай

байгаа талаар асуухад “Бид дөнгөж сая л 2017 оны газрын тосны бодлогоо тодорхойллоо. Үйлдвэр барих асуудал бодлогын түвшинд хоцрогдсон нь үнэн. Газрын тосны төрөөс баримтлах бодлогын баримт бичгийг батлуулсан. УИХ-аас энэ чиглэлийн үйлдвэрийг эрчимжүүлэхэд анхаарч байгаа” хэмээсэн юм. Түүнчлэн Болдхүү дарга зөвхөн газрын тосноос гадна нүүрс, занараас шингэн түлш гаргах арга технологийг нэвтрүүлэхэд салбарын яам анхаарч байгааг хэлсэн. Мөн “Дорнод газрын тос” төрийн өмчийн оролцоотой үйлдвэр байгуулахад салбар яам, агентлаг болон ТӨХ-ны хамтарсан ажлын хэсэг байгуулжээ. Тус бүсэд үйлдвэр барихаар “Хэт” компанитай хэлэлцэж байгаа бөгөөд төрийн оролцоотой компани байгуулахаар тохиролцох юм байна. Дорнодын сав газар бол манай улсын газрын тосны гол бүс нутаг.

Өдгөө Монголд газрын тосны 18 талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ/БХГ/-ний дагуу 14 гэрээлэгч компани үйл ажиллагаа явуулж байгаа аж. Шинээр зургаан талбайд БХГ байгуулах шатанд, дөрвөн талбайд олон улсын нээлттэй тендер зарлаад байгаа юм байна. Энэхүү гэрээлэгчдийн 33 хувь нь Монгол Улсын, 39 хувь нь Хятадын, үлдэж буй 28 хувь нь бусад орны харьяалалтай аж.

Манай улсын нефтийн бүтээгдэхүүний хэрэглээ жилээс жилд өсөн нэмэгдэж буй тул 2020 онд хоёр сая тонн бүтээгдэхүүн хэрэглэх таамаг тооцоо гарчээ. 120 мянган сая тоннын хүчин чадалтай үйлдвэрийг 40-50 сая ам.доллар, 300 мянган тоннын хүчин чадалтай үйлдвэрийг 120-170 сая тонн ам.долларын өртөгтэй барих урьдчилсан тооцоо бий. Хэрвээ дотоодод нефтийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн тохиолдолд Засгийн газраас худалдан авах баталгаа гаргаж өгөхөө өнгөрсөн онд Ерөнхий сайд С.Батболд мэдэгдсэн нь энэ чиглэлийн төслүүдийн ажил урагшлахад томоохон ахиц болохыг мэргэжилтнүүд тэмдэглэж байв.

Хүссэн үйлдвэр, хүсээгүй дарамт

Тамсагийн сав газарт Тосон-Уулын талбайн газрын тосны баталгаат нөөц 179.08 сая тонн, үүнээс ашиглалтын баталгаат нөөц нь 20.17 сая тонн. Харин Зүүн баян дахь БХГ-ний талбайн баталгаат нөөц 26.05 сая тонн, үүнээс ашиглалтын нөөц 2.07 сая тонн хэмээн Газрын тосны газрын дарга асан


Д.Амарсайхан тэмдэглэсэн юм. Манай улсын хувьд сүүлийн гурван жилд ОХУ, БНХАУ, БНКУ, БНСУ, Литва зэрэг орноос 779.5-1050.0 мянган тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолжээ. Харин үйлдвэр барих бус шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжийг өргөтгөх зорилгоор төсөвт 4.5 тэрбум төгрөг тусгажээ. Замын-Үүд дэх шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжийн өргөтгөлийн ажилд одоогоор 1.3 тэрбум төгрөгийг зараад байгаа аж. Үүнийг “Алхана-трейд” компани гүйцэтгэж байгааг Газрын тосны газраас мэдээлсэн юм. Уг байгууламжийн өргөтгөлийн ажлыг энэ оны арванхоёрдугаар сард хүлээн авахаар төлөвлөсөн байна. Газрын тос боловсруулах үйлдвэрийн чиглэлээр гадаадад төрийн зардлаар 50 орчим хүүхэд суралцаж байгаа гэх сайн мэдээ бий. Газрын тосны олборлолт болон экспорт сүүлийн дөрвөн жилд тав дахин өсчээ. Манайх шатахууны үнийн өсөлтөд бүдрээд, нийгэм тэр аяараа сандарч, тэвдээд байх орон гэтэл мөн үү. Улсын ашигт малтмалын нэгдсэн санд бүртгэснээр 200 гаруй сая тонн газрын тосны нөөцтэй, жилийн хэрэгцээ нь нэг сая тонн ч хүрэхгүй жижиг зах зээлтэй орны нэг. Энэхүү нөөцийн 20-30 хувийг шууд ашиглах боломжтой юм байна.

Хэдийгээр импортлогч компаниуд шатахууны үнээ 50 төгрөгөөр буулгасан ч үйлдвэртэй болох үндэсний мөрөөдлөө орхиж боломгүй. Хөл дүүлжлэх унаатайгаасаа эхлээд хөлөө амраах унаагүй нь хүртэл бензиний үнэ огцом нэмэгдэх үеэр манайх газрын тосоо дотооддоо 20,30 хувь ч гэсэн үйлдвэрлэдэг болоосой гэсэн мөрөөдөлд өөрийн эрхгүй автсан биз ээ. Хэчнээн ч жил бид газрын тос боловсруулах үйлдвэртэй болох талаар мөрөөдөв. Гэхдээ тэрхүү мөрөөдөл цаг хугацаа өнгөрөх тусам мартагдаж бүдгэрэх биш, бүр үндэсний шинжтэй болж байна гэлтэй. Нефтийн үйлдвэрийн талаар хувийн болон хувьсгалын салбарын хүмүүстэй уулзаад явж байхад үйлдвэр үнэхээр хэрэгтэй гэдэгтэй санал нэгдэж, ядаж л дотоодын хэрэгцээнийхээ 30 хувийг хангаад байвал үнийг боломжит хэмжээнд бариад байх боломжтойг онцлон тэмдэглэж байв. Хүссэн үйлдвэр, хүсээгүй дарамт гэж энэ байх.


Хэрэв өвдөлт мэдэрсэн бол ...

Хятадын хөрөнгө оруулалттай

Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбай болон гэрээлэгчдийн талаарх тоон үзүүлэлт



2008-2011 онд өрөмдсөн цооногийн тоо




2008-2010 оны Гэрээлэгчдийн Монгол Улсын харьяат үндсэн болон гэрээт ажилтны харьцаа



“Петро чайна Дачин Тамсаг” компани Монголд 1993 оноос хойш нийт 5.3 сая тонн баррель түүхий нефтийг нэг ч төгрөгийн роялтийн татваргүйгээр олборложээ. Тус компанид 2012 оны нэгдүгээр сарын байдлаар Дорнод аймгийн 90 гаруй хүн ажиллаж байгаа гэсэн мэдээллийг Газрын тосны газраас өгсөн юм. Дөрвөн жилийн хугацаанд тус компани 6.05 сая тонн баррель “шингэн алт” олборлож, үүнийхээ 5.9 сая баррелийг нь түүхийгээр нь экспортолсон байна. Дорноговь аймгийн Зүүн баян, Цагаан-Элсний сав газраас олборлох баталгаат нөөцийг 26.05 сая тонноор тооцоолсон бөгөөд ашиглалтын нөөц нь 2.07 сая тонн хэмээн бүртгэсэн аж. Өнгөрсөн оны байдлаар хойд хөршөөс импортын 94.3 хувь буюу 990 мянган тонн газрын тосны бүтээгдэхүүн авчээ. Үүний 68 хүртэлх хувь нь “Роснефть” компанийн бүтээгдэхүүн эзэлж байгаа болохыг Газрын тосны газраас өгүүлсэн юм.

Өдгөө “хэн нефть, цэвэр усны нөөцийг хянана, тэр дэлхийд ноёрхох” цаг ирснийг саяхны шатахууны үнийн өсөлт бага ч гэсэн төрд мэдрүүлсэн гэдэгт найднам. Дорноговь, Чойбалсанд барих газрын тос боловсруулах үйлдвэртэй холбоотой төгсгөлгүй маргаан эхэлж байна. Улс орны



Эх сурвалж: Газрын тосны газар

хэтийн ирээдүйг харсан үйлдвэр барих төслөөс гадна Монголын газрын тосны арвин нөөцөд шунасан атгаг санаа ч энэ салбарт үйлчилсээр байгааг холбогдох албаны хүмүүс учирлаж байв. Хэрэв сая өвдөлт мэдрсэн

бол Монголын төр, засгийнхан зөвхөн нефтийн үйлдвэртэй болох ажлыг урагшлуулах асуудалд сонгуулийг ч умартан ажиллах учиртай. ■

Импорт

Нефть импортлогчдыг өмгөөлөх нь бас үгүйсгэх нь

Б.Алтай

Манайд шатахууныг бөөнөөр болон жижиглэнгээр борлуулах эрх бүхий 70 гаруй аж ахуйн нэгж байдаг аж. Тэдний 20 гаруй нь тогтмол үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд найман компани нь Монголдоо монополь. Импортын дийлэнх хувийг эзэлдэг учраас ардаа том улс төрийн хамгаалалттай, эзэд нь хүсэл зорилгоороо улстөрчидтэй холбогдсон тул импортлогчид улс төр, эдийн засагт нөлөө бүхий хүмүүс болжээ. Бид импортлогч компанийн эздийг ингэж улс төрийн нүдээр харж бас болох юм. Мөн эсэргээрээ өөрсдийн чадлаараа бизнесийн салбарт хөлөө олсон

мохошгүй зоригтнууд гэж магтаж бас болно. Бензиний үнэ өнгөрсөн сард 300 орчим төгрөгөөр огцом нэмэгдсэнд хэн буруутай вэ. Бурууг хэнд тохож, зөвийг хэнээс асуух вэ. Эдгээр асуултын хариулт одоо ч олдоогүй л байна.

Нефть импортлогчид шатахууны үнээ үгсэн хуйвалдаж нэмсэн гэж үнэн үү. Байгаа байхгүй нь мэдэгдэхгүй шахам байдаг Засгийн газрын тохируулагч агентлаг Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх газар гэнэт хэлд орж, дээрх дүгнэлтийг гаргасан нь хэр үнэний үндэслэлтэй бол, импортлогчид оо. Үнэндээ литр шатахууныг 1850 төгрөгөөр

худалдаж авах санхүүгийн чадамжтай хэчнээн хүн манайд байгаа билээ. Эсрэгээрээ ядуурал буурсан уу? Өрхийн орлого өссөн үү? Ажилгүйдэл багассан уу хэмээн импортлогчдоос асуух хэрэгтэй болох нь. Монголын арилжааны банкуудад буй нийт хадгаламжийн 95 хувь нь нийгмийн 10 хүрэхгүй хувьд ногдож байгаа тухай Төвбанкны мэдээлэл бий шүү дээ. Энэ нь монголчуудын амьдралын алаг эрээнийг тодотгох бус уу.

2012 оны нэгдүгээр сарын эхний долоо хоногийн баасан гаригийг эргэн санацгаая. Шатахуун импортлогчид гэнэт үнээ огцом нэмж, иргэд багагүй ▶

▶ сандралдсан. Амралтын өдрүүдийг тааруулан үнээ өсгөсөн болохоор 2-3 хоногийн дараанаас Ерөнхий сайд тэргүүтэй Засгийн газрын холбогдох яам, агентлагийнхан үнэ бууруулах талаар идэвхийлэн ажиллаж, хэчнээн эрээн цаас үйлдвэрлээд ч нэгэнт нэмэгдсэн үнийн нийгэмд тарих балаг их байлаа. Бензиний үнэ нэмэгдэх гэж байна гэсэн сургаар шахуу таксину

ашиг хөөсөөр. Ийм байгаа нөхцөлд хямд үнэтэй шатахуун хэрэглэнэ гэдэг санасны гарз бололтой. Том, жижиг нь хамаагүй, Монголд яаралтай нефтийн үйлдвэртэй л болохгүй бол горьгүй. Дээрх үйл явдалтай холбоотойгоор нефтийн бүтээгдэхүүн импортлогчдыг хэвлэлийнхэн хараан цөхөж, хамгийн муу муухай бүхнээр хэлж бичсэн. Асуудлыг нөгөө талаас нь харахыг

өмгөөлөх, хамгаалах гурван шалтгаан бий. Гэхдээ үгүйсгэх, үл итгэх баримт басхүү байгааг хамтад нь хүргэе.

Нефть импортлогчдыг зөвтгөх нэг дэх шалтгаан

“Урсгал усыг боож, урсацыг хорих юм бол ус далангаа сэтэлж, сад тавин урсдаг. Боогдож хураагдсан урсгал ус



үйлчилгээнд явдаг жолооч нараас эхлээд үнээ 100-200 төгрөгөөр өсгөж, шинэ тариф мөрдөж эхэлсэн. Энэ байдал өргөн хэрэглээний бараа үйлчилгээ эрхлэгчдэд гэрлийн хурдаар халдварласан гэж хэлж болно. Тиймээс “Өнгөрсөн борооны хойноос дах нөмрөөд ч” болтугай нь төр, засгийн түвшинд ярьж хэлцэж байж огцом нэмэгдсэн бензиний үнийг 50 төгрөгөөр бууруулсан ч бусад юмны үнэ дагаад буураагүй. Нэг үгээр хэлбэл, огцом хөдөлсөн шатахууны үнийн нэмэгдэл өнөөдөр, маргааш, цаашид ч өрхийн төсвийг ганхуулсан хэвээр байна гэсэн үг. Эцсийн дүндээ шатахуун импортлогчид хожиж, хэрэглэгчид хөлд нь үрэгдсэн үйл явдал болоод л өнгөрлөө.

Монгол Улсын хувьд хойд хөршөөсөө нефтийн бүтээгдэхүүний хувьд бараг 100 хувийн хамааралтай. Гэтэл дотооддоо импортлогч компаниуд нь

сэтгүүлчид огтхон ч хүсээгүй. Импортлогчдын хувьд хэвлэлийнхнээр ингэж муугаараа дуудуулах зүйл огт хийгээгүй биш хийсэн. Чухам санаатай юу, санамсаргүй юу гэдэгт л хэргийн учир байгаа байх. Гэхдээ тэд үнээ өсгөхдөө байнгын л баасан гаригийн оройг сонгодогт байгаа юм. Мөн түүнчлэн энэ нь Засгийн газарт улс төрийн томоохон асуудал тулгарсан эгзэгтэй үетэй таарсан нь нефть импортлогчид зохион байгуулалттай зохиомлоор үнээ нэмлээ гэдэг хардалтыг улам бүр бадраасан юм. Бензиний үнийн талаар ингээд бичээд байвал бичээд байж болно. Гэхдээ манай сэтгүүлийн хувьд асуудалд арай өөр өнцгөөс хандахын сацуу илүү бодитой мэдээлэлд тулгуурлаж хөндөхийг хичээе.

Монгол Улсыг стратегийн нэгэн гол бүтээгдэхүүнээр таслахгүй хангаж ирсэн, цаашид ч хангасаар байх нефть импортлогчдыг зөвтгөх,

ямар ч далан, хамгаалалтыг эвдэн сад тавих нь байгалийн хууль. Үүний нэгэн адил шатахуун импортлогч компанийн эзэд хэчнээн үнийг хямд барихыг хичээсэн ч нэмэхээс аргагүй байдалд орсон байж болох юм” хэмээн МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш, доктор, профессор Б.Эрдэнэбат хэллээ. Тэрбээр цааш хэлэхдээ “Засгийн газраас шатахууны үнийг зохицуулж ирсэн. Татварын бодлогоор импортлогч компанийг дэмжиж зөвхөн НӨАТ авч байна. Засгийн газар үнийг зохицуулахад хамаг л арга чаргаа хэрэглэсэн. Хэрвээ татварын хөнгөлөлтгүй өнөөдрийг хүрсэн бол үнийн өсөлт одоогийнхоос ч өндөр байх байлаа. Импортлогчдийн хувьд үнээ нэмсэн нь нэгдүгээрт, зах зээлээ хадгалах үүднээс эрсдэлээс өөрсдийгөө хамгаалсан хариу үйлдэл. Хоёрдугаарт, ашгаа нэмэх сонирхол байсан юм болов уу. Өөрөөр хэлбэл, ▶

эзэ удаагийн үнийн нэмэгдэл 200 төгрөг байсан нь яалт ч үгүй л шархаа нөхсөн арга байх. Олон жилийн алдагдлаа нөхөх үүднээс дунджаар 230 төгрөгөөр шатахууны үнээ нэмсэн ч байж болох юм” гэв. Эрдэнэбат багшийн үгийг сонсох ёстой. Учир нь, тэрбээр “Газрын тосны цочрол ба Монгол-1” нэртэй судалгааг бие даан хийсэн юм

Засгийн газар “Нефтийн бүтээгдэхүүний хангамж, нөөц, үнийг тогтоох комисс”-ийг 2008 онд байгуулж, шатахууны үнийг татварын зохицуулалтаар, захиргааны аргаар тогтоон барьж ирсэн нь ус далангаа сэтлэх эхний шалтгаан болсон байж мэдэхийг судлаач Б.Эрдэнэбат ийн тайлбарласан юм.

Өмгөөлөх хоёр дахь шалтгаан

Шатахууны үнээ өссөнтэй холбогдуулан Монголын нефть хийн ассоциаци өөрийн байр сууриа илэрхийлэв. Тус байгууллагын мэдэгдэл олон нийтэд гэхээс илүүтэй С.Батболдын Засгийн газарт хаягласан гэж хэлж болохуйц. Импортлогч компаниудыг өмгөөлөх хоёр дахь шалтгаан энд гарч ирлээ. Нефтийн бүтээгдэхүүний хангамж, худалдаа нь гадаад зах зээлээс тэр тусмаа импортын дийлэнх нь хөрш ОХУ-аас бүрэн хамааралтай гэдгийг бид мартаж болохгүй. Мөн хамтарсан Засгийн газрын задрал шатахуун импортлогчдод огтхон ч нөлөөлөөгүй хэмээн мэдэгдсэн.

Шатахууны импортлогч компаниуд нийлүүлэлтийн бусад эх үүсвэрийг байнга эрэлхийлж, зохих хэмжээгээр үр дүн гарч байгаа ч газар зүйн байршлын нөлөөлөл нь хамаарлыг бууруулах хэмжээнд хүрч чадахгүй байна хэмээн бэрхшээлээ учирласан юм. Хямд үнээ, хямд зардлыг импортлогч компанийн эзэд хайсаар байгаа ажээ. Гэлээ ч хойд хөрш нефтийн бүтээгдэхүүний экспортын татвараар чангалсаар байгаа нь Монголд үнээ нэмэгдэх анхдагч шалтгаан болсон юм байна. Мөн өргөн хэрэглээний барааны болон шатахууны үнийн өсөлт нь дан ганц шатахуун импортлогч компаниудаас болсон гэж үзэх үндэслэл нь учир дутагдалтай хэмээн Нефть хийн ассоциацийнхан мэдэгдэв. Монголд шатахууны үнээ огцом нэмэгдсэн “оросууд л буруутай” гэнэ.

“Петровис” компанийн Олон нийттэй харилцах ахлах менежер П.Цэрэнням

“Үнийн нэмэгдлийн гол шалтгаан нь ОХУ өнгөрсөн жил дотоодын бичил үйлдвэрээ дэмжих үүднээс 60:66 гэсэн экспортын татварын шинэ систем нэвтрүүлсэн нь тус улсаас шатахуун импортлогч улсуудад хүнд цохилт болсон” хэмээн ярьсан юм. Нэг үгээр хэлбэл, шатахууны үнээ нэмэгдэх үндсэн шалтгаан нь ердөө л хойд хөршийн экспортын татвар гэвэл байгаа онож таарах нь.

Хамгаалах гурав дахь шалтгаан

Монголбанк муу ажилласан учраас нефть импортлогчид үнээ нэмсэн хэмээн импортлогчид олонтаа ярилаа. Ам.долларын ханшийг тогтоон барьж чадалгүй алдаснаас болж үндэсний импортлогч компаниуд иргэдээс ч илүү их алдагдалд орсон байна. Тэгэхээр нефть импортлогчдыг хамгаалах гурав дахь шалтгаан энэ бололтой. Монголбанкны Ерөнхийлөгч Л.Пүрэвдоржийг ажлаа муу хийсэн гэж огцруулах санал хүртэл гарав. Бензиний үнээ нэмэгдсэн үйл явдлын өрнөлийн үеэр “Жаст ойл” компанийн гүйцэтгэх захирал Ш.Баасанжав “Шатахууны үнийн өсөлт хоёрхон хүчин зүйлээс шалтгаалсан. Юун түрүүнд ОХУ боловсруулсан нефтийн экспортын үнээ нэмэгдүүлснээс үүдэлтэй. Үүнийг гадаад хүчин зүйл гэж ойлгож болно. Харин дотоод хүчин зүйл нь ам.долларын төгрөгтэй харьцах ханш өссөнтэй шууд холбоотой” хэмээн мэдэгдсэн юм. НИК компанийн гүйцэтгэх захирал М.Халиунбат “Ам.долларын ханш өсөөд л байвал бид шатахууныхаа үнийг дахин нэмэхээс аргагүй байдалд хүрнэ” гэсэн нь яалт ч үгүй импортлогчдыг хамгаалах эцсийн найдвар болов.

Шатахуун импортлогчдыг үгүйсгэх нэг дэх баримт

Дээрх шалтгаанаар үнээ нэмсэн импортлогчдын үг хэл, үйлдэл хэр үнэн зөв бэ. Үүнийг төр, засгийн хэмжээнд шалгаж үзээд үнээ зохиомлоор нэмсэн гэсэн дүгнэлт гаргасан нь тэднийг үгүйсгэх нэг дэх баримт. Тиймээс өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнээ хөөрөгдөхөд хүргэсэн эзэд бол шатахуун импортлогчид болж байна. Мэргэжлийн байгууллагын хийсэн тооцоогоор ам.долларын ханшийн өсөлттэй холбоотойгоор шатахууны үнээ нэмэгдлээ гэхэд 170 төгрөгөөр

л өсгөх тооцоо байтал 260 төгрөгөөр нэмсэн тул Засгийн газрын тэргүүн холбогдох удирдлагуудад хариуцлага тооцохоор болсон. Чоно борооноор гэдэгчлэн шатахуун импортлогчид улс төрийн тогтворгүй байдлыг овжин ашиглаж, үнээ нэмэгдүүлэх асуудлыг хөндсөн нь тэднийг үгүйсгэх баримтын нэг. Засгийн газрын хуралдаанаар 260-300 төгрөгөөр шатахууныхаа үнийг нэмсэн импортлогчдод арга хэмжээ авахыг даалгаагүй бол 50 төгрөгөөр ч буухгүй байсан биз. Засгийн газрын тооцоотой тэнцүүлэхэд дахиад 40 төгрөгөөр бууруулах боломж ч тэдэнд бий.

Үл итгэх хоёр дахь баримт

Төвбанкны зүгээс валютын ханшийн өсөлтөөс шалтгаалж нефтийн бүтээгдэхүүний үнээ өсөөгүй гэж тайлбарласан. Монголбанкны удирдлагуудын зүгээс дэлхийн зах зээлд түүхий нефть өнөөдөр 96 ам.долларын үнэтэй байна. Хоёр жилийн өмнө 76 ам.доллар байсан. Өөрөөр хэлбэл, манайд нефтийн бүтээгдэхүүний үнээ дэлхийн зах зээлийн үнийн өсөлтөөс 60-70 хувиар өндөр байгаа. Засгийн газраас татваруудыг нь тэглэж дэмжлэг үзүүлээд байхад шүү дээ. Мөн хоёр жилийн өмнө ам.доллар 1450 төгрөгийн ханштай болоход нефть импортлогчид бүтээгдэхүүнийхээ үнийг өсгөсөн хэрнээ долларын ханш 1200 төгрөг болж буурахад үнээ буулгаагүй. Энэ мэтчилэн нефть импортлогчдын даварсан үйлдлээс болж зах зээлд ам.долларын үнийн хөөсрөл бий болж, тэр нь эцэстээ хэрэглэгчдийн нуруунд дарамт үүсгэж байна” гэсэн тайлбарыг хийсэн.

Үүссэн нөхцөл байдлын хүрээнд УИХ-ын Шалгалтын хэсэг валютын ханшийн нөлөөллийг Монголбанкны 2011 оны арваннэгдүгээр сарын дундаж албан ханштай зэрэгцүүлэн авч үзсэн байна. Энэ сарын 7-ны байдлаар ам.долларын албан ханш 1429 төгрөг болсон бөгөөд ханшийн зөрүүгээр нэг литр А-80 бензин 93, АИ-92 бензин 113, дизелийн түлш 118 төгрөгөөр нэмэгдэхээр байжээ. Мөн өдөр “Найман шарга” валютын захад ам.доллар 1475 төгрөгийн ханштай байсан бөгөөд ханшийн зөрүүгээр нэг литр А-80 бензин 133, АИ-92 бензин 163, дизелийн түлш 170 төгрөгөөр өсөхөөр байсан гэсэн тооцоо гарчээ. “Валютын ханшийн өсөлт шатахууны ▶

үнийг 200-240 төгрөгөөр нэмэх үндэслэл болоогүй. Эдийн засгийн хийсвэр агуулгаар үнэ нэмсэн. Үүнд улс төрийн нөлөөлөл орсныг үгүйсгэхгүй” хэмээн Монголбанкинд шалгалт хийсэн Ажлын хэсгийн дарга УИХ-ын гишүүн Ч.Улаан мэдэгдэв. Түүнчлэн Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрынхан сая л гэнэт үүргээ ухаарч, нефть импортлогч компаниудад шалгалт хийн, үгсэн хуйвалдаж

үнээ нэмсэн хэмээн дүгнэсэн юм. Импортлогч компаниударгагүй байдалд ороод үнээ нэмсэн хэмээн учирласан мөртлөө эргээд үнээ 50 төгрөгөөр буулгаж байгаа нь бодит шалтгаан мөн эсэхэд эргэлзэхэд хүргэж буй юм. Нөгөө талаас ном хэвлэлээс уншсан ч, мэргэжлийн хүмүүсийн ярианаас үзсэн ч аливаа бизнесийн ашиг 15 хувьтай байх юм бол олон улсын жишигт нийцсэн боломжит ашиг гэж үзэх

нь байдаг билээ. Тэгвэл Монголын нефтийн бүтээгдэхүүн импортлогчдын ашиг дээрхээс хоёр дахин их байх тохиолдол ч байдаг гэсэн судалгаа ч байдаг аж.

Газрын тосны цочрол ба Монгол цаашид яах вэ

“Монгол Улс шатахууны хувьд зөвхөн нэг улс, нэг компаниас шууд ▶



Ч.Отгочулуугийн булан

Монголын төр хаанаас эхэлдэг вэ

Улс төрийн хувьд “бүс нутагтаа үлгэр жишээ, ардчилсан” хэмээн тооцогдох болсон хэдий ч “зах зээлийн бус эдийн засагтай”, “эдийн засаг нь чөлөөт бус”, “төрийн бодлого нь тогтворгүй” гэх зэрэг цолноосоо Монгол Улс хэзээ салах вэ. Улстөрчид ч, судлаачид ч, хэвлэл мэдээллийнхэн ч сонгуулиас сонгуулийн хооронд сэтгэдэг хэвшилтэй болох нь. Энэ бол аюул. Иймд, гадна дотноос өгч буй дохио санамжийг авч, шинэ цагийн Монгол төрийн мөн чанар, түүний зах зээлийн эдийн засагт гүйцэтгэх үүргийн талаар авч үзсэнээ толилууль байна.

АНУ-ын төрийн үүсэл, зарчим. АНУ-ын тусгаар төрийн түүх Британийн колончлолыг эсэргүүцсэн “Үндэстний эцгүүд” хэмээх хувьсгалчдын тэмцлээс эхтэй. Чөлөөт иргэнээс эхлэх төрийн эрх мэдлийг ардын төлөө хэрэгжүүлэх нь тэдний үндсэн уриа байв. Анхны Ерөнхийлөгчид нь Хаан болох боломж байсан ч татгалзаж чадсанаараа Францын Наполеоноос ялгарч байв. Филадельфи хотноо эрх чөлөөний тунхагаа бичсэн нь Үндсэн хуулийнх нь эхлэл болсон бөгөөд төслийг нь бие даасан 13 муж улсууд руу илгээж батлуулсан байдаг. Зарим нэг жижиг муж улсаас ирэх хариуг хоёр жил хүлээсэн гэдэг. Уг нь бол татвар төлөгч иргэд буюу ард түмнээс асуулгүйгээр, шууд конгрессээс батлах боломж байсан ч, ардчилсан зарчмыг сонгосон нь энэ төрийн нэгэн гайхамшиг болжээ.

Үндсэн хуулиндаа Холбооны болон Муж улсын засаг, захиргаа ямар үүрэг хүлээх төдийгүй эрхийг нь ч тодорхой зааглаж өгсөн байдаг. Суурь зарчим нь Эрх мэдэл дороосоо дээшээ өгсөн хэрэгжих гэж болно. Холбооны түвшинд Соёлын яам, Үндэсний хөгжлийн яам гэх зэрэг байгууллага байхгүй. Харин шүүх, батлан хамгаалах болон мөнгөний бодлого гэх зэрэг цөөн тооны чиглэлд төр нь үүрэг хариуцлага авсан шиг аваад даацтай хэрэгжүүлдэг. Ингэхдээ сонгуулиас сонгуульд савладаггүй бөгөөд урт

хугацааны бодлогыг хэрэгжүүлдэг, ардчилал шударга ёс, бизнесийн тогтвортой орчинг хангадаг Шүүх, Төвбанк зэрэг хүчирхэг байгууллагуудын хөгжилд гойд анхаарсан байдаг.

Америкийн төртэй харьцуулах нь. Манай төрийг Америкийнхтэй харьцуулж үзвэл орооцолдсон эрх мэдэл, бүхнийг төвлөрүүлсэн буюу орон нутгийн ард түмэндээ итгэдэггүй зөвлөлт маягийн тогтолцооны ул мөр гүнзгий ажиглагддаг. Монгол төрийн байгууламжийн үндэс болсон үндсэн хууль, засаг захиргааны нэгжийн зохицуулалт нь Герман-Франц-Зөвлөлт системийн хольц юм. Тэгсэн хэрнээ улс төрийн чөлөөт сонгууль бүхий системээ харахаар Америктэй төстэй ч юм шиг. Ард түмний амьжиргааг тэтгэх учиртай төсвийн системээ харахаар Шинэ-Зеландын хуулийн загвар байх жишээтэй. Шинэ Зеланд нь огт өөр хуулийн системтэй, газар нутгаар хамаагүй жижиг улс. Гэтэл энэ загварт түшиглэснээр Монголын орон нутгийн удирдлага нь мөнгө санхүүгийн хувьд кассчинаас хэтрэхгүй эрх мэдэлтэй болсон. Өнөөдөр нэг сумын сургуулийн засварын зардлыг Их хурлын гишүүн шийдэж байна. Гэр хорооллын нэг хороонд хэн ажилгүй, хэн архидаад байгааг хороон дарга маш сайн мэднэ. Гэтэл түүнд татвар болон урамшууллын ямар ч эрх мэдэл үгүй. АНУ-д бол манайхаар хороо, сум харьцангуй их эрх мэдэлтэй. “Сумын засаг дарга” буюу Говернер эвсэл майорууд нь ажлын байр бий болгох хувийн хөрөнгө оруулалтыг татахын төлөө хоорондоо өдөр шөнөгүй өрсөлддөг.

БНХАУ-ын төрийн үүсэл, өнөөдөр баримталж буй зарчим. Хятадын төр яг хэзээ үүссэн нь тодорхойгүй. Хятадын төрийг байгуулагч гэх хүн эсвэл хүмүүсийн тухай баримт олдоогүй, харин салж бутарсан төрийг эргүүлэн нэгтгэсэн нэгэн айхтар Шар эзэн хааны тухай домог байдаг. Домгоос үзэхэд, домог үүсэхээс ч өмнө нэг төр байж байгаад тэр нь задарсан гэдэг нь илт. “Эртний Хятадын дайны урлаг” ▶

▶ хамааралтай байгаа нь Монгол Улсын эдийн засгийн тогтвортой байдалд тулгараад байгаа томоохон эрсдэл. Цаашилбал манай гол нийлүүлэгч болох “Роснефть” компани 100 хувь ОХУ-ын төрийн мэдлийнх учир нийлүүлэлтийн талаарх шийдвэр зөвхөн эдийн засгийн үүднээс бус улс төрийн сэдэлтэй байх боломжтой. Иймд түлш шатахууны хоёрдогч эх үүсвэрийг

эрэлхийлэх, эдийн засаг дахь хэрэглээг төрөлжүүлэх, хэмнэлтийг урамшуулах шаардлагатай” хэмээн МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш Б.Эрдэнэбатын “Газрын тосны цочрол ба Монгол-1” судалгаандаа тэмдэглэжээ. Тэрбээр шатахууны зах зээлийн зохицуулалтын үр дүн хангалтгүй байгааг тайлбарласан юм. 2008 оны байдлаар манай улс Ази, Австрали, Номхон Далайн бүс

нутагт хамгийн өндөр үнэтэй дизель түлш хэрэглэж байгаа улсаар тодорч байсан байна. Мөн үнийн гэнэтийн өсөлтийг захиргааны болон татаасын аргаар хязгаарлах механизм байгаа ч дэлхийн зах зээлийн үнийн бууралтыг дотоод зах зээл дээрх бүтээгдэхүүний үнийн бууралттай уях механизм алга байна гэж дүгнэсэн юм. ■

▶ хэмээх нэг номонд Хүннү нарын ов мэхийн талаар олонтаа дурдсан байдаг. Түүхээсээ асар их сургамж авдаг энэ гүрэн цагтаа өөрсдөөсөө илүү хүчирхэг нүүдэлчдийн олон төрийг өөрсдөдөө уусгаж байв. Ердөө 100-200 жилийн өмнө “Улаан үст зэрлэгүүд” (барбарууд) буюу Европчуудын түрэмгийлэлд шаналж байсан энэ улс өнөөдөр үйлдвэрлэл, мөнгө санхүүгийн хувьд дэлхийн эзэнт гүрэн болон өндийж буй нь олон мянган жилийн турш тасралтгүй сайжирч ирсэн төрийнх нь хөгжилтэй холбоотой биз ээ.

Америкаас эрс ялгаатай зарчим гэвэл эрх мэдэл нь дээрээсээ доош явна. Нэг төлөвлөөд түүндээ бүх хүчээ хаях нь манай туулаад гарсан социалист системтэй төстэй. Гэхдээ БНМАУ болон ЗХУ-д хүчээ авч байсан социалист догматикаас илүү уламжлалт прагматик хандлагадаа тулгуурлаж иргэддээ эдийн засаг, санхүүгийн боломжийг бүрдүүлж өгснөөр илүү амжилтад хүргэжээ.

Төр гэж ер нь юу юм бэ. Барууны хайрцагаар мэдээлэл хүлээж авдаг, сэтгэдэг, харьцдаг хүмүүст бол энэ нь чөлөөт иргэдийн нэгдэл. Төрийн гишүүн байх нь эс байхаас илүү дээр. Татвараа өгчихнө, хэн тэр татварыг юунд захиран зарцуулахыг сонгоно. Коммунист онолд, ядуу ажилчин анги хувийн өмчгүй, ангигүй нийгэм байгуулахад төр хэрэгтэй. Дорнын уламжлалт ухаанд тэнгэр, бурхнаас өгсөн эрхийг газар дээр хэрэгжүүлэх хэрэгсэл нь төр болно.

Төр ямар эрхтэй, ямар үүрэгтэй, иргэн ямар эрхтэй, ямар үүрэгтэй байх талаар ул суурьтай бодох нь монголчуудын асуудал. Учир нь, бид одоо гадаадаас нэмж хуулах зүйл хомс. Харин одоо бидний өмнө байгаа орооцолдсон, данхайсан төрийг яаж олон нийтийн үйлчилгээний алба болгох вэ гэдэг нь зөвхөн бидний л хийх ажил болно. Иймд суурь мөн чанар руу эргэн орж, төрийг эрх үүргийн солбилцол гэх өнцгөөс харж эхлэх нь зүйтэй.

Жирийн нэг иргэний эрх, хүслээр жишээ авъя. Жирийн иргэн инфляци багатай, тогтвортой орчинг хүсч байна. Хэрэв Улаанбаатарт амьдардаг бол гудамжинд буй онгорхой нүхнүүдийг тагтай байлгах нь төрийн аль байгууллагын үүрэг вэ гэдгийг мэдэх эрхтэй. Хөдөөний суурингийнхан халуун устай, тогтой, чанартай орон сууц, сургууль, эмнэлгийг хүсч байна. Тэд илүү их санхүүгийн эрх мэдэл, өөрсдийнхөө орон нутгийг хөгжүүлэх эрх, хариуцлагаа Улаанбаатараас салгаж авахыг хүсч байна. Гэвч улс төрчид (УИХ) маань даахгүй нохой булуу хураана гэгчээр УБ-ын хэдэн яаманд хэт ахадсан эрхийг нийслэлийн хэдэн албан хаагчдад хадгалсаар байгаа юм.

Дүгнэлтийн оронд. Америк юм уу Хятад маягийн төрийн тогтолцоог харьцуулан харахад аль ч улсын төр бол “Эрх үүргүүдийн зах (супермаркет)” гэдэг нь ил болж ирж байна. Гол нь өөрийн түүх, соёлд тохируулсан загвар буюу хэлбэршлийг хэрхэн олсноороо л ялгагдана.

Манайд төрийн засаглал нь улс төр, хууль эрх зүй, төсөв мөнгө гэсэн гурван түвшиндээ өөр өөр системээс хуулаад бантагнуулчихжээ. Дан бидний буруу ч бас биш ээ. Сүүлийн зуунуудад гаднын эрхшээлд явж ирсэн, мөн уламжлалт төрт ёсны суртал нь аж үйлдвэржилтээр тодорхойлогдох цаг үед тэр бүр тохирохгүй байсан зэрэг бэрхшээл бий.

Бидний буруу бас байна. Өөрийгөө танин мэдэх бололцоогүйгээр гаднын системийг хүчээр болон дурандаа авч ирсний үр дүнд Монгол төр өнөөдөр өөрийгөө ч танихаа болтлоо харьжжээ. Хятадын төрийн гаднаас суралцах чадвар бол гайхамшигтай. Хэдий хятад соёл, хятад онцлог гэж ярьдаг ч энэ орон Монголоос ч илүү орчин үежсэн гэдэгтэй маргах хүн гарахгүй биз. Америкийн төр нь иргэндээ итгэх итгэлээс эхэлдэг бол Хятадынх төрт уламжлалдаа итгэх итгэлээс эхэлдэг. Харин Монголын төр хаанаас эхэлдэг вэ? ■

Хөмсөг солиорой

“Хар хун”-гийн сүрэг айлчлах уу?

Б.Энхцэцэг

Европын буурангуй төрх, Ойрхи Дорнодын дайны сүүдэр, Хятадын юанийн хүчин мөхөстөл өнөө дэлхийн санхүүгийн салбарт дахин хямрал даллаж буй “Хар хунгуудаар” тодроод байгаа юм. Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, бодлого тодорхойлогчдын чадуу хяналт, буурай орнууд дахь улс төрийн ярвигтай тэмцлүүд гамшигт үйл явдлын давтамжийг ойртуулж буй юм. Хар хунгуудын зөвхөн дэвэлт нь хурдассан бус хүч нь ч нэмэгджээ. Харилцан хамаарч улам бүр нягтаршсан өнөөгийн ертөнцөд хямрал шууд болон шууд бусаар “халдварладаг”. Тухайлбал, 2011 оны Японы газар хөдлөлтөөс үүдэн Хойд Америк дахь автомашины үйлдвэрүүд сэлбэгийн хомсдолд орсон. Мөн 2008 оны хямралын үеэр АНУ-ын дөрөв дэх том хөрөнгө оруулалтын банк “Lehman Brothers” (LEH) дампуурал зарласан билээ. Тэгвэл өдгөө даяаршсан ертөнцөд хар хунгийн сүрэг манайд айлчлах болов уу гэж асуух шаардлагагүй болжээ. Өөрөөр хэлбэл, энэ нь асуулт биш болсон гэсэн үг. Харин Хэзээ? Яаж? гэдэг л зөв асуулт болчихоод байгаа тухай дэлхийн хэвлэлүүдэд бичиж буй юм.

Домогт хөрөнгө оруулагч Жим Рожерсийн таамаглалаар бид 2008

оныхоос ч дор хямрал руу дөтөлж яваа гэнэ. “Урт хугацааны туршид ам.доллар шалдаа бууж, Хятадын үлэмж өсөлтөд усны асуудалцэг тавьж мэдэхээр байна. Гэвч нөгөө талаас хөрөнгө оруулагчид өнгөрсөн хямралын үед гаргасан алдаагаа давтаж суухын оронд хямрал гэдэг нөгөө талаар боломж гэдгийг ойлгох хэрэгтэй” хэмээн хэлжээ.

Европ хэзээ мөдгүй дэлбэрэхэд бэлэн сууна. Европын өрөнд баригдсан үндэстнүүдийн өтийг банкууд агуулж сууна. Хятад улс ч мөн адил аюулын бүс болж хувирлаа. Хамгийн гол нь аюул яаг хаанаа байгааг мэдэх арга алга. Тус улсын эдийн засгийн өсөлт 5 хувиас багагүй хэмжээнд гүрийсээр л байгаа юм. Хэрэв энэ үзүүлэлт улам сайжирвал Хятад улс гаарч, газрын газрын тос ба таваарын зах зээлд дарамт өгч улмаар АНУ, Европын айл өрхийг бүр ч хэцүүхэн байдалд түлхэнэ гэсэн үг. Арай өөр өнцгөөс нь аживал Хятад улсын удаашрал нэг талаас дэлбэрэлт болох дохиог өгөөд эхэллээ. Учир нь Шанхайд үл хөдлөх хөрөнгийн үнэ эрчимтэй унаж байна. Дээр нь Хятадын чанаргүй зээлүүд Америкийн чадваргүй зээлдэгчид болон Европын “Олив улс”-ын бондын дэргэд хамаагүй том эрсдэлийг дагуулж байгаа

юм. Хятад улсын гадаад худалдааны ашиг бол тус орны хөрөнгө оруулалтын эх үүсвэр. Гэтэл гадаад зах зээл дэх хэрэглэгчдийн эрэлт буурсан нь тэр их хөрөнгө оруулалтыг ямар мөнгөөрөө тэтгэх вэ гэдэг асуулт урган гарч байгаа юм.

Энэ хооронд Нэгдсэн улс нэг л хөөрхөн суугаад байдаг. Гэвч Америк ч аюултай. Учраа олж зүгээ ялгах аа байсан Конгресс, тэтгэвэртээ гарахаар завдаж буй мөнгөн тэмдэгт, хяналтаас гарсан цэргийн хүчин нь дайсагнал авчирхаас өөр ид шидгүй боллоо. Ажилгүйдэл газар авч, мөрөөдөл эхлэдэг гэлцдэг гүрэнд, мөрөөдөл төгсдөг болов уу гэлтэй тус улсыг орхин одогсдын тоо эрс өссөн байна. Тухайлбал 2008 оноос хойш зөвхөн Мексикийн гэхэд 300,000 цагаачид төрөлх нутагтаа буцжээ. Хятад болон Япон улсууд АНУ-руу цутгах зээлээ сааруулах ба бүр зогсоовол тус улсын төв банк албан шахалтаар өөрийн орныг цааш нь авч явахын тулд шинэхэн ногоонуудыг тэрбум тэрбумаар нь үйлдвэрлэх болно. Ингээд ирэхээр ногоон дэвсгэртийн үнэ цэнэ далайн ёроолд хэвтэж байгаатай адил үнэгүйднэ.

Бидний хувьд аль бөмбөг нь түрүүлж дэлбэрэхийг таашгүй. Гэвч эрт оройгүй зад авна. 2008 онд ийм онош байгаагүй тул хар толгойгоо хаахаа мэдэхгүй бэмбэгнээсээр дэлбэ явсан. Харин одоо бол ядахдаа л бид толгойгоо дарах ёстойгоо мэдлээ.

Тайван цагт хөлс их урсгавал, Дайны цагт цус бага урсана

Reuters агентлаг Монгол Улсад хөрөнгө оруулахад учирч болох эрсдэлийг улирал тутам тооцож мэдээлдэг билээ. Монголын улс төрийн байдал хамгийн ноцтой эрсдэлд тооцогдож, хөрөнгө оруулагчдыг сонгуул дуустал харзняя гэж уриалсан өнгө аяс тэрхүү нийтлэлд тусчээ. Амлалтаа биелүүлэхээр бэлэн мөнгө тарааж, төсвөө түүхэнд байгаагүйгээр тэлэн суугаа Монголын төр, засаг “Хэрвээ ингэвэл яах вэ” гэдэг эрсдэлийн асуултад бид өнөөдөр хариултгүй сууна. ▶



► 2010-2020 оны хооронд Монголын эдийн засаг жилд дунджаар 12 хувиар өсөхөөр хүлээгдэж байгаа гэнэ. Уул уурхайн салбарт сүүлийн жилүүдэд ажиглагдсан чиг хандлага, энэ салбарт гарахаар хүлээгдэж буй огцом өсөлтөөс шалтгаалан манай улсын нийгэм, эдийн засаг төрөл бүрийн эрсдэлд өртөж магадгүй дүр зураг харагдлаа хэмээн “Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн”-гээс гаргасан эрсдэлийн үнэлгээнд дурджээ. Өөрөөр хэлбэл, манайх урьд урьдын жилүүдийг бодвол гадаад, дотоодын эрсдэлд нэн өртөмтгий болсон байгаа гэсэн үг гэнэ. Дээрх судалгаанаас үзэхэд тухайлбал, ДНБ-д эзлэх уул уурхайн хувийн жин ихээхэн өсч 2010 оны байдлаар нийт экспортын 80 гаруй хувийг эзлэх болсон байна. Гэтэл Монгол орны хөгжлийн голлох хэсгийг нуруундаа үүрч ирсэн, цаашид ч үүрэлцэх хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл дээрх хугацаанд нэлээд буурсан байх жишээтэй. Ийнхүү макро инфляци, ДНБ, төсвийн зарлага, мөнгөний нийлүүлэлтийн өсөлт зэрэг нь хэлбэлзэл ихтэй, өндөр өсөлттэй явж ирсэн нь манай улсын эдийн засагт томоохон өөрчлөлт гарч байгааг харуулж байгаа төдийгүй төрөл бүрийн эрсдэлд бүдрэмтгий гэдгийг давхар үзүүлж байна. Мөн сүүлийн жилүүдэд манай улсын эдийн засаг тогтворгүй байгаа. Энэхүү мөчлөгийг өдөөж байгаа хоёр гол хүчин зүйл бий. Нэгдүгээрт, эрдэс баялгийн дэлхийн зах зээл дээрх үнэ ханш. Хоёрдугаарт, энэхүү үнийн хэлбэлзэлийн нөлөөллийг улам бүр дэвэргэж байгаа бодлогууд хэмээн дээрх эрсдэлийн үнэлгээнд тодорхойлжээ. Цаашид уул уурхайн томоохон төслүүд ашиглалтад ороод ирэхээр эрдэс бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл эдийн засаг улам тогтворгүй байх эрсдэлийг учруулах аж.

Манай улс санхүүгийн эрсдэлд өртөмтгий байх талтай бөгөөд капиталын урсгалыг зохицуулж байгаа өнөөгийн тогтолцоо нь тэр бүр хангалттай сайн биш байна гэсэн дүгнэлт “Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн”-гийн эрсдэлийн судалгаанд бий. Түүнчлэн гадаад капиталын дотогшлох урсгалд зохицуулалт хийхийн тулд одоогийн тогтолцоонд өөрчлөлт хийх шаардлагатай байгаа гэдгийг ч уг судалгаанд тусгажээ.

Эдийн засгийн хямралын хамгийн хүнд тэр үед төсөв, сангийн тэлэх бодлого хамгийн хэрэгтэй арга хэмжээ

байсан атал Засгийн газарт “май” гээд гаргаад өгөх хуримтлал байтугай төсвийн зарлагаа бууруулалгүй авч үлдэх нөөц хөрөнгө ч байхгүй болсон байжээ. Эдийн засаг өсөлттэй үед Засгийн газар үрэлгэн зангаа өөгшүүлж нийт эрэлтийг улам дэвэргэж байсан бол эдийн засгийн уналтын үед Засгийн газрын зарлага буурснаар хямралыг улам хүндрүүлсэн байна. “Одоогийн байдлаар Төсөв, сангийн болон мөнгөний бодлого хоёул хамтдаа тэлээд яваад байгаа. Эдийн засгийн хэт өсөлтийн далайцыг бууруулахад сангийн хумих бодлого чиглэгддэг. Харин нөгөө талаас мөнгөний зөөлөн бодлого явуулснаар хүү болон ханш дээр очих дарамт багасна” гэдгийг “Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн”-гийн захирал Б.Түвшинтөгс багш Д.Баярмаа нар сэтгүүлчдэд зориулсан сургалтын үеэр тэмдэглэж байсан юм.

Олон улсын хямралын эсрэг даатгуулсан компани манайд алга

“Мандал Женерал” компанийн дэд захирал Г.Отгонжаргал “Олон улсад үүссэн хямралыг Монгол Улсад халдварлуулах вирус тээгч нь санхүүгийн салбар өөрөө. Хүссэн хүсээгүй бид өртөнө.Түүний эсрэг дархлааг бий болгохын тулд нэн тэргүүнд чанаргүй зээл өгөхгүй байх тал дээр банкны салбарын үйл ажиллагаанд анхаарч, хянамгай байх хэрэгтэй. Өнөөдөр даатгалын компанийн харилцагчдын бүтцийг аваад үзэхэд эд хөрөнгө, хариуцлагын даатгал зонхилдог. Гэтэл Монголын ДНБ-ий дийлэнх хэсгийг бүрдүүлдэг хувийн хэвшлийнхнээс олон улсын хямралын эсрэг даатгуулчихсан зүйл огт алга. Манай зүгээс бизнесийн үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн олон төрлийн даатгал санал болгодог. Харамсалтай нь түүнийг ойлгож, ашигладаг бизнес эрхлэгч цөөхөн байна. Хямралд бэлэн үү? гэвэл “Үгүй” гэж хариулна” гэв.

Засгийн газар бороотой өдөр гаргаад өмсчих цувтай явах хэрэгтэй

“Зээлийн хүү ууланд мацаж, валютын ханш муудаж, хөрөнгө оруулалтын урсгал саарч байна. Яг одоо банкны салбар эрсдэлийн шугамын эн тэргүүнд зогсож байна. Монгол Улмын хувьд шаардлагатай үед гараа дүрдэг тийм санхүүгийн нөөцийг бүрдүүлэх л хэрэгтэй. Ирээдүйд хувь заяа яаж

эргэхийг бид бүрэн дүүрэн хэлж мэдэхгүй. Засгийн газар бороотой өдөр гаргаад өмсчих цувтай явах хэрэгтэй. Монголын Засгийн газар мах нөөцөлж үнэ өссөн үед гаргаад ирдэг шигээ боломжтой үедээ мөнгөө нөөцөлж, цөвүүн цагт ашиглахаар тооцоолох ёстой. Хэрвээ АНУ, Европын байдал гамшгийн хэмжээнд хүрвэл аль ч улс орон үүнээс бултан зайлах боломжгүй. 2008-2009 оны хямрал олон арван жилийн өсөлт, амжилтын дараа гарч ирсэн учир гэнэтийн хүчтэй цохилт болсон. Бид одоо яг ч хямралаас гарчихсан юм биш. Зүгээр л асуудлыг даамжирахаас сэргийлэн, тодорхой хяналтад барьж, нөхцөл байдлыг дээшлүүлэх арга хэмжээг авч сууна. Гэвч одоо гайхшралд ороод байхгүй ч гэсэн хямралыг бид хялбархан давна гэсэн үг биш” хэмээн ХААН банкны Эрсдэл хариуцсан захирал Стефен Калей өгүүлсэн юм.

Өнөөдөр бид өөрөөсөө бус өрөөлөөс дэндүү их хамааралтай болсон гэдгээ сайтар ойлгох хэрэгтэй. Залбирч мөргөж, зайдуу өнгөрөөсэй хэмээн муйхарлаж суухын оронд эдийн засгийн эрсдэлийн зураглал бий болгох ажлаа түргэлье. Дусал залгуулж, амиа аргацаасан дэлхийн томоохон орнууд хэзээ ч амь тавиа билээ.

-2007 оны “New York Times” шилдэг борлуулалттай номоор шалгарч байсан зохиолч Нассим Николас Талебын “Хар хун /The Black Swan/” номын нэрийг ашигласан болно.

**-<http://business.financialpost.com>
Are you ready for the next Black Swan? 12/16**

-<http://www.ibtimes.com>The Next Economic Crisis Will Be Much Worse Than 2008

-<http://dailyreckoning.com> Avoiding the Danger Zones in the Year Ahead 12/9

-<http://www.nytimes.com> Will China Break? 12/8

**-Монгол улсын эрсдлийн үнэлгээ (анхны хувилбар)
Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн (ERI) ■**

Үзэл бодол

Төвбанкны валютын нөөцөд ханшийн тэгшитгэл хийх нь зөв үү?



Ө.Ганзориг
/Санхүүгийн зах зээлийн холбооны тэргүүн/

Саяхны УИХ-ын байнгын хорооны хуралдаан дээр 2010 онд 145 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан, 2011 онд мөн хуримтлагдсан алдагдалтай байгаа Төвбанкыг зэмлэж, хариуцлага хүлээлгэх асуудал яригдсан гэж мэдээлэгджээ.


Ханшийн тэгшитгэл

Монгол Улсын компани бүр санхүүгийн тайлангаа төгрөгөөр илэрхийлж гаргадаг. Хэрэв компани кассандаа 1000 ам.доллартай бөгөөд бусдад ам.доллараар төлөх өр төлбөр үгүй бол үүнийг “долларын урт позицтой байна” гэж нэрлэдэг. Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу энэхүү 1000 ам.долларыг санхүүгийн тайланд тусгахдаа өдөр бүр mark-to-market буюу ханшийн тэгшитгэл хийж төгрөгөөр илэрхийлэгдэх дүнгээр нь бүртгэж явах ёстой. Ийнхүү ханшийн тэгшитгэл хийхэд өдөр бүр ханшийн өөрчлөлтөөр зөрүү гарч, ашиг эсвэл алдагдал болон бүртгэгдэж явдаг.

Төв банкны нөөц


Би Төвбанкны гадаад валютын нөөцөд ханшийн тэгшитгэл хийх учиргүй гэж эртнээс үзсээр ирсэн. Өөрөөр хэлбэл орлого үр дүнгийн тайландаа нөөцийн дахин үнэлгээний өөрчлөлтийг тусгах учиргүй. Дэлхийн олон том банк баланс дээрээ ханшийн тэгшитгэл хийдэггүй. Мэдээж балансас гадуурх ханшийн тэгшитгэлийг өдөр тутам хийх нь зөв. Хэдийгээр Төвбанк ханшийн тэгшитгэл хийх нь зүйтэй гэж үздэг зарим томоохон эдийн засагч байдаг ч, тэдний гаргаж ирдэг аргументүүд нь хангалттай бус юм. Төвбанк бол ашгийн төлөө бус, мөнгө хэвлэх эрхтэй, зах зээл дээрх мөнгөний эрэлт нийлүүлэлтийг зохицуулах үүрэгтэй, ард түмэн, хүн ардын сайн сайхны төлөөх зорилго бүхий онцгой статустай байгууллага. УИХ эсвэл аливаа нэг байгууллага Монголбанкны үйл ажиллагааны зардал, түүний төсөв талыг хэлэлцэхээс биш, орлого талыг, тэр тусмаа гадаад валютын нөөцийн ханшийн тэгшитгэлийн ашиг, алдагдлыг хэлэлцэх ёсгүй. Бүр түүгээр нь дарамт шахалт үзүүлж ч болохгүй.

Төвбанк бол ашгийн төлөө бус онцгой статустай байгууллага. Монголбанкны удирдлаганд буй улсын валютын нөөцөд ханшийн тэгшитгэл хийх, улмаар түүний орлого үр дүнгийн тайланд тусгах нь тохиромжгүй хэрэг юм.



Манай орны эдийн засаг, гадаад худалдаа нэмэгдэхийн хэрээр гадаад валютын албан нөөцийн хэмжээ нэмэгдсэн.

Монголбанкны валютын ханшийн тэгшитгэлийн ашиг/алдагдал (тэрбум төгрөгөөр)



Тайлбар:

Ханшийн тэгшитгэлийн алдагдал гээд байгаа энэ зүйл үнэндээ бодит бус алдагдал. Төвбанкнд байгаа валютын нөөц өсөхийн хэрээр Монголбанкны орлого үр дүнгийн тайлан их хэмжээгээр савлах болно. Валютын нөөц бол улсын эдийн засгийг тэнцвэржүүлэх зорилготой, улсын нөөц юм.

Учир нь, бид ардчилсан дэглэмтэй, чөлөөт зах зээлт орон. Ийм зах зээлд валютын ханш нь эрэлт нийлүүлэлт болон макро эдийн засгийн суурь хүчин зүйлийн зарчмаар тогтоогдох ёстой. Төвбанк нь ханшийн огцом савлагааг бууруулах, макро хүчин зүйлсийн тогтвортой байдлыг хангах л байдлаар оролцохоос биш зах зээлийн хандлагыг тогтоохгүй юм. Хэрэв төгрөгийн ханш макро шалтгааны улмаас чангарах ёстой бол чангарах л учиртай. Эсрэг тохиолдолд мөн үнэн.

Хэрэв Та анзаарсан бол төгрөгийн ханш бусад гадаад валютын эсрэг чангарах тусам Монголбанк ханшийн тэгшитгэлийн маш их алдагдал хүлээхээр харагдаж байна. Яагаад гэвэл Монголбанкны нөөцөд байгаа нөгөө 1000 ам.доллар чинь өмнө нь орлого үр дүнгийн тайлангаас харахад 1300 төгрөгтэй тэнцэж байснаа харин одоо 1200 төгрөг болоод ирж байна. 100 төгрөгийн алдагдал хүлээж байна. Эсрэгээр төгрөгийн ханш суларсанаар Монголбанкны орлого үр дүнгийн тайлан ашигтай гарна. Гэтэл Монголбанк суурь зарчмаараа ашгийн төлөө бус байгууллага, эдийн засгийн онцгой үүрэг бүхий субъект байдаг. Хэрэв Монголбанк ашгийн хойноос хөөцөлдөж, жил бүрийн эцэст төгрөгийн ханшийг зохиомлоор сулруулах сэдэлтэй болвол энэ нь макро эдийн засаг, бизнес, цаашлаад ард иргэдэд маш хортой зүйл болох болно. Энэ бол зарчмын асуудал. Энэ бол сонирхлын зөрчлийн тухай асуудал. ■

“Газрын ховор элемент уул уурхайн бизнес биш”

Б.Энхцэцэг

Та Iphone I pad хэрэглэдэг үү? Хэрэв “Үгүй” бол шингэн дэлгэцтэй хавтгай зураг танайд бий юу? Дахиад л “Үгүй” гэж хариулах гэж байгаа бол гэрлийн чийдэн, баттерей бол байж л таараа. Газрын ховор элемент орчин үеийн технологийн үйлдвэрлэлд ус агаар мэт хэрэгцээтэй зүйл аж. Нэрнээсээ авахуулаад сонирхол татах энэхүү ашигт малтмалын талаар энгийнээр учирлах гээд оролдоё. Газрын ховор элемент үгүй бол наад зах нь бидний хэрэглэж байгаа гар утас 1980 он руу ухарч тоосгоны дайтай аварга хэмжээнд очно. Мөн хөнгөн авсаархан зөөврийн нөүтбүүк тань чемоданы дайтай нүсэр болно гээд төсөөлөх гээд үз дээ. Санаанд багтамгүй байгаа биз. Дэлбэлэх тэслэх бодис, радиоэлектроник, машины тоног төхөөрөмж, гэр ахуйн барааны үйлдвэрлэл, химийн үйлдвэрлэл, металлург гээд олон салбарт хэрэглэгддэг газрын ховор элемент үгүй бол амьдрал хэчнээн өөр байх болоо. Дэлхий дээр газрын ховор элемент (ГХЭ) өргөн тархсан байдаг. Басхүү 17 төрөл бий. Гэтэл яагаад “ховор” гэж нэрлэх болсон юм бол гэдэг бас сонин. Мэргэжилтнүүдийн хэлж буйгаар тарха

цынхаа хувьд хомс бус нэгээс нөгөөг нь салган авч, хэрэглэх үйл явц нь л түүхэн цаг хугацаанд ихээхэн хүндрэлтэй байсан учир тэр гэнэ. Хамгийн гол нь газрын ховор элемент бусад ашигт малтмал шиг дан дангаараа оршдоггүй онцлогтой.


“Хятадын газрын ховор элементийн нийгэмлэг”-ээс гаргасан нийтлэлд хүхрийн хүчлийн коннтрацыг өндөр температурт шатаах технологийг ашиглан нэг тонн газрын ховор элемент үйлдвэрлэхэд ойролцоогоор 805 кг флор, 13 кг тоос болон 9600-12000 шоо метр олон төрлийн хорт бодис агуулсан хаягдал хий ялгардаг байна. Мөн түүнчлэн 75 шоо метр хүчил агуулсан ус, нэг тонн гаруй радио идэвхт хаягдал тухайн орчинд үлдэж хоцордог хэмээн бичсэн байгаа юм. Энэ нь боловсруулах үйл явцын хувьд уул уурхайн ямар ч бүтээгдэхүүнээс илүү өндөр эрсдэлийг дагуулдаг гэсэн үг юм. “Энэ бол уул уурхайн бизнес биш. Харин химийн мэргэшсэн салбар юм” хэмээн Хятад дахь “Форбэс & Манхаттен” компанийг төлөөлөн Монголд болсон хуралд оролцсон Аластэйр Нэйл “Газрын ховор элементийг хөгжүүлэхэд анхаарах

зүйлүүд ба уурхай-үйлдвэрлэл-борлуулалт” илтгэлдээ дурдсан билээ. Гэхдээ энэ бол бохир хортой химийн үйлдвэрлэл биш л дээ. Дүрэм горимынх нь дагуу зохих ёсоор ил уурхайн олборлолт явуулж, ангилан ялгаж авсаны дараа хэрэггүй хаягдлаар овоолго хийснээр эхний шат дуусдаг ажиллагаа юм. Харин тухайн улс өөрийн хүсэл сонирхол, хүчин чадлаас хамааран дараагийн шатны боловсруулалт хийх, бусад төрлийн үйлдвэрлэл явуулах эсэхээ шийддэг байна.

Хүүеэ цаана чинь....

...Үс нь халзарч, шүд нь унасан, үр тариа нь хорчойж хатсан, хорт хавдраар нас барагсад ихэссэн гэхчилэн олон тооны гомдол санал манай урд хөршид тасардаггүй байна. Нэг үгээр хэлбэл, ийм төрлийн уурхайн олборлолт, боловсруулалтын үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчны гамшигт нөхцөл байдалтай холбоотой гомдол саналууд тус улсын шийдвэр гаргаж, бодлого тодорхойлогчдыг зүгээр суух аргагүй байдалд хүргэсэн гэж үзэж болох нь. Тиймээс Хятад улс байгаль ▶

Газрын ховор элементийн хэрэглээ




орчин, ард иргэдийнхээ эрх ашгийг эн тэргүүнд тавьсан уу, эсвэл газрын ховор элементийн үнэ дэлхийн зах зээл дээр 20 орчим хувиар унасан тай холбогдуулан үнээ өсгөх бодлого барихаар шийдсэн үү. Ямартай ч сүүлийн жилүүдэд Хятадын газрын ховор элемент боловсруулах хэд хэдэн томоохон үйлдвэр хаалгаа барьж, эрх баригчдын зүгээс экспортоо хумьж, татвараа нэмэх бодлого явуулж эхэлсэн байна. Харин дэлхий нийт энэ үйл явдалтай холбоотой хэдийнэ тайлбар дүгнэлт хөврүүлээд эхэлсэн. Чингэхдээ тэд БНХАУ-ын нөхцөл байдлыг байгаль орчин, ард түмэн гэхээс илүү эдийн засгийн сонирхлынх нь үүднээс өлгөн авч тайлбарлаж буй юм. Харин Хятадын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийнхэн энэ талаар бичиж, нэвтрүүлэхдээ дараах гурван нөхцөл байдлыг үндсэн шалтгаан болгож ишилжээ. Мэдээж хэрэг Хятадын энэ төрлийн бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээ өссөн нь нэгдэх үнэн. Томоохон үйлдвэрлэгчдийн зүгээс зах зээлийн уруудсан үнийг өсгөх зорилгоор хаалгаа түр хугацаанд барьсан нь хоёр дахь үнэн. Түүнчлэн Хятад улсын хувьд байгаль орчиндоо учруулсан хор хөнөөлөө арилгахын тулд газрын ховор элементээс олсон доллар тутмынхаа хариуд 100 доллар зарцуулах хэрэгтэй болж байгаа нь хамгийн гашуун гурав дахь үнэн гэж ярих нь байна.

Анх 1992 онд Хятадын коммунист намын Засгийн газрын тэргүүн асан Дэнь Сяопин “Ойрхи Дорнод газрын тос үйлдвэрлэдэг бол Хятад улс газрын ховор элемент үйлдвэрлэж чадна” гэж хэлж байжээ. Үүнээс хойш тус улс түүний хэлсэнчлэн газрын ховор элементэд гол анхаарлаа хандуулж эхэлсэн юм байна.

Хөөх тийм үү?..

Хятад улс дэлхийн зах зээл дээр газрын ховор элементийн монополь эрх тогтоохын тулд бусад орны үйлдвэрлэгчдийг дампууруулах хэмжээний асар бага үнийг санал болгож, хүчээр хаанчилсан. Тус улс өнөөдөр 17 төрлийн ховор элементийн 90 гаруй хувийг дэлхийн зах зээлд дангаараа нийлүүлдэг бөгөөд газрын ховор элементийн нөөцийн хувьд 1997-2010 оны хооронд 43-30 хувь болтлоо буурчээ. Одоогийн үзүүлэлтээр дээрх нөөц 15-20 жилийн дараа гэхэд шавхагдаж дуусна. 2010 онд Хятад улс экспортын хэмжээгээ 72 хувиар багасгах зах зээлийн үнийг хоёр дахин нэмэгдэхэд хүргэсэн бол өнгөрөгч оны эхэнд



Эх сурвалж: “Иел” цахим хуудас /Yale Global Online/

экспортоо дахин 35 хувиар бууруулжээ. Гэхдээ энэ үнэ өмнөх жилийнх шиг өсөх биш, харин ч эсрэгээрээ урууджээ. Зах зээлийн үүднээс авч үзвэл, Хятад улс тус ашигт малтмалын үнийг өсгөхийн тулд хэдэн сарын хугацаанд үйлдвэрлэлээ зогсоосон нь буруутгаад байхааргүй шийдвэр гэдгийг мэргэжилтнүүд хэлж байна. “Өнгөрсөн 10 жилийн хугацаанд манай улсын газрын ховор элементийн салбарт зөвхөн анхан шатны боловсруулалт хийсэн бүтээгдэхүүнийг экспортолж ирсэн. Ингэхдээ байгаль орчноо золиослож, багахан ашиг хүртэж ирлээ” хэмээн Хятадын NTD телевиз өнгөрсөн оны аравдугаар сард мэдээлж байсан юм.

Нөгөө талаас тус улс дахь VOA сувгийн мэдээлснээр улс орнууд газрын ховор элементийн салбарт БНХАУ-ын хараанаас мултрах бодлого явуулж байна. Тухайлбал, “Тоёото”, “Женерал моторс” зэрэг газрын ховор элементийн “мангасууд” хэрэглээгээ аль болох багасгах арга замыг тууштай эрэлхийлж эхэлсэн аж. Мөн Хятад улсаас гадна энэ төрлийн эрдсийн эх үүсвэрүүдийг АНУ хөгжүүлэх шаардлагатай байна гэдэг саналыг Пентагон Конгресст өргөн барьсан тухай “The wallstreet journal” мэдээлсэн юм. Үүнтэй холбоотой өгүүлэхэд дэлхийн зах зээлд газрын ховор элементийн эрэлт ихтэй орны тоонд Европ, АНУ, Япон, Солонгос зэрэг багтана. Тэр дундаа Япон улс “Бухын доодохыг харж үнэг турж үхнэ” гэдгээр байн байн араасаа дэлсүүлж, цочирдоод байхыг хүлцэн тэвчихээ больж, энэ чиглэлээр олон тооны төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг авч эхлээд буй аж. Түүнчлэн манай хойд хөрш ОХУ ч ховор элементийг стратегийн түүхий эдийн жагсаалтад

оруулаад амжжээ. Мөн гуравхан сарын өмнө малайзчууд эх орондоо баригдах гэж байсан Австрали улстай хамтарсан дэлхийд дээгүүрт орохоор газрын ховор элементийн үйлдвэр барих төслийг эсэргүүцэн байгаль орчноо хамгаалах уриан дор жагсаал хийснийг тэмдэглэхэд илүүдэхгүй болов уу.

Тэгсэн манайх гэдэг айл...

Төрийн ордонд энэ сарын 17-нд “Газрын ховор элемент, стратегийн металлын олборлолтоос зах зээл рүү” сэдэвт уулзалт, семинар болсон. Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага” хөтөлбөр, Үндэсний хөгжил шинэтгэлийн хороотой хамтран зохион байгуулсан уг хуралд Монгол, Канад, Герман улсын төлөөлөгчид оролцож, илтгэл тавьсан. АНУ-ын Геологийн албаны 2009 онд хийсэн судалгаанд газрын ховор элементийн нөөцийн хэмжээгээр Монгол Улс БНХАУ-ын дараа орно гэж өгүүлжээ. Дээрх мэргэжлийн байгууллагын судалгаанд тэмдэглэгдсэн Монголын нөөцийг сонирхвол 31 сая тонн буюу дэлхийн нийт нөөцийн 16,77 хувь юм. Үүнийг Дэлхийн банк мөнгөн хөрөнгөөр илэрхийлэх юм бол 10 гаруй тэрбум ам. доллартай тэнцэнэ хэмээн тооцсон байна. Харин Монголын геологчид, мэргэжилтнүүд манай газрын ховор элементийн нөөц дээрхээс ч их байх магадлалтай гэж үзэж байгаа юм. Алт, зэс, нүүрс зэрэг уул уурхайн уламжлалт бүтээгдэхүүнээс ч дутахааргүй дэлхийн орнуудын сонирхлыг татаж буй газрын ховор элементийн хувьд Монголд таван томоохон орд, 71 илэрц, 246 эрдэсжилт ▶▶

бүхий цэг бий аж. Үүнээс Мушгай худаг, Лугийн гол, Хотгор ба Халзан бүргэдэйн ордууд хамгийн их буюу 6,6 сая тоннын нөөцтэй гэж үздэг байна. Гэвч бүрэн гүйцэд судалгаа шинжилгээ хийгдээгүй учраас манай улсын хувьд газрын ховор элементийг олборлож, ашиглахтай холбоотой асуудал дөнгөж л яриа төдий түүхий, барьцгүй хэвээр байгаа юм.

Хятадаас гадна хоёр уурхай л шинээр үйл ажиллагаа явуулж эхлэхэд газрын ховор элементийн дэлхий нийтийн нэг улсад хэт чанга хүлэгдсэн уяа суларна гэж Их Британийн геологи, эрдэс баялаг судалгааны газрын тэргүүн Эндрью Вүүд хэлсэн удаатай. Энэ нь дээрх төрлийн ашигт малтмалын ганц хоёроор зогсохгүй томоохон ордтой Монгол Улсын хувьд алга ташиж хүлээн авахаар сайхан мэдээлэл юм. Гэвч газрын ховор элемент рүү ханцуй

ирээдүйд үйлдвэрлэх боломжтой болохыг үгүйсгэхгүй. Тэгэхийн тулд гол түүхий эд болох газрын ховор элемент бидэнд зайлшгүй хэрэгтэй юм. Нөгөө талаас энэ эрдэс рүү шунан орж байгаль орчноо сүйтгэсэн удаан жилийн гашуун туршлага бэлээхэн манай урд хөршид бий. Гэхдээ тэдний энэ таагүй байдал нь газрын ховор элементээс олж байгаа ашгаа байгаль орчин эрүүл мэнддээ хуваалцахыг хүсээгүйн үр дүн. Хятадаас өөр дэлхий дээр газрын ховор элементийн салбарт 20 гаруй жилийн туршлага хуримтлуулсан орон байхгүй гэж хэлж болно. Өөрийн зах зээлээ алдахгүйн тулд тэд ч бусад орны энэ төрлийн олборлолтод уриалгахан туслалцахгүй нь лавтай.

Харин Монгол Улсын хувьд Оюутолгой, Тавантолгойн ажил цэгцрэх 2-3 жилийн хугацаанд Америк,

материалын шинжээч Жон Хивакигоос Монгол Улс газрын ховор элементийн дэлхийн зах зээлд ухаалгаар тоглолт хийвэл юуг хожих бас муу ажиллавал ямар сөрөг үр дагавар авчрах бол оо гэдэг асуултыг тавилаа. Тэрбээр “Муугаар бодоход Монгол аль нэг орны түүхий эдийн ханган нийлүүлэгч болж, маш бага цалинтай 2000 гаруй ажлын байртай үлдэж мэднэ. Харин ухаалаг тоглолт хийвэл эсрэгээрээ инженер, химийн мэргэжлийн маш сайн ажиллах хүчтэй болно гэсэн үг. Байгаль орчин сүйдэх тал дээр тийм юм байхгүй” хэмээн хариуллаа.

Түүнчлэн “Одоо л биш бол хэзээ ч биш. Морины уралдаантай зүйрлэбэл, жаахан л хүлээвэл уралдаан чамайг гараанаасаа гараагүй байхад дуусчихна гэсэн үг” хэмээн тус хурлын үеэр Хятад дахь “Форбэс & Манхаттен” компанийг төлөөлөн ирсэн Алайстэйр Нэйл хэлсэн. Тэгвэл УАБЗ-ийн Мэдээлэл, дүн шинжилгээний газрын дарга Ц.Даваадорж “Монгол газрын ховор элементийн салбарт дэлхийн зах зээлд томоохон тоглогч болох замаар бусад салбараа хөгжүүлж, олон тулгуурт хүчирхэг эдийн засагтай орон болох боломжтой” гэлээ. Ер нь хуралд оролцогчид дотоод, гадаадын төлөөлөгчдийн цөөнгүй нь газрын ховор элементийг олборлож, ашиглаж үр дүнг нь үзэх үйл ажиллагаа тийм ч амар бүтэх хоол биш. Урт хугацааны төсөл байх болно гэдэгтэй санал нэгдэж байсан. Ноён Хиваки “Монгол Улсад нөөц сайтай уурхайгаа богино хугацаанд үйлдвэрлэл болгож, сайн чанарын газрын ховор элемент үйлдвэрлэх сонирхол хэрвээ байхгүй байгаа бол би хувьдаа энэ төрлийн ажлыг эхлээд ч хэрэггүй гэж зөвлөмөөр байна” гэж хэлсэн юм.

Эцэст нь хэлэхэд, газрын ховор элементийн дэлхийн зах зээлийг салбарын мэргэжилтэн, судлаачид үнэлж дүгнэхдээ жилдээ дунджаар 120 мянган тонноос хэтрэхгүй хэмжээний олборлолт хийх боломжтой, 3-4 тэрбум ам.долларт эргэлддэг харьцангуй жижиг зах зээл гэж үздэг юм билээ. Тиймээс нэр томъёондоо “Ховор” гэсэн үг агуулсан ч тархацын хувьд ховор биш уг эрдсийг ашиглахад монголчуудад ул суурьтай бодох зүйл бишгүй бий нь энэ нийтлэлээс харагдах болов уу.

80 төрлийн ашигт малтмал хэвлдээ тээсэн уудам Монгол нутгийн хөрсөнд ховор элемент ч ховоргүй гэдэг нь нэгэнт тодорхой учраас Монголын төр, засгийн эрхмүүдийн мэргэн ухааны царая мэдэх хэрэг буй за. ■

Монгол дахь газрын ховор элементийн томоохон ордууд



шамлан орж, шуудран яаравчиллаа ч гэсэн манай улсын хувьд дор хаяж бэлтгэлийн 5-6 жилийн хугацаа шаардлагатай аж. Тэр үед өнөө дэлхий нийтэд хэрэгжихээр хүлээгдэж буй 400 гаруй төсөл амьдралд буугаад ирэхээр газрын ховор элементийн үнэ гэдэг зүйл юу ч болоо билээ бүү мэд. Гэтэл тус элементийг дүрэм журмын дагуу ашиглалт явуулахгүй бол байгаль орчин, хүний эрүүл мэндэд аюул заналхийлэл дагуулах асуудалтай гэж байгаа. Төрийн ордонд болсон дээрх хурлын үеэр хуралд оролцогч дотоод, гадаадын төлөөлөгчдийн сэтгэгдлийг сонсоход, УИХ-ын гишүүн С.Оюун “Ирээдүйд энэ салбар ашигтай ч байж мэднэ, үгүй ч байж болно. Гэхдээ газрын ховор элементийн ашиглалтыг дагаж манайд орж ирэх ашиг бол мэдлэгт суурилсан эдийн засаг, өндөр техник технологи байх болно” хэмээн хэлж байсан. Магадгүй бид өөрсдөө ч тэр эцсийн бүтээгдэхүүн болох өндөр технологийг

Канад, Австрали гэх мэт томоохон орнууд газрын ховор элементийн ашиглалтаар мэдлэг, “ноу хау”-гаа зузаатгах боломжтой. Ингэснээр Хятад цорын ганц эх сурвалж биш болж хувирна” гэдгийг Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага хөтөлбөрийн захирал Штефан Ханселманн ярьсан. Тэгвэл дээрх хурлын үеэр гадаадын зочид төлөөлөгчдийн зүгээс манайханд анхааруулж байсан зүйл бол техник технологи хөгжсөн орчин үед байгальд хор хөнөөлгүй технологийг оруулж ирэх өргөн боломж бий. Хэдийгээр өртөг өндөртэй ч зоосны зөвхөн нэг талыг хараад байх утгагүй хэрэг. Тиймээс хамтрагчаа зөв сонгож хүний нөөцөө эртнээс бүрдүүлэн аль болох яаравчлах хэрэгтэй талаар зөвлөж байсан. Уг хурлын үеэр “Байрон капитал Маркет” компанийн Олон улсын цэвэр технологи, судалгааны хэлтсийн дарга,

Эдийн засагт мандаж буй нар

Б.Тогтох

Говийн цэлгэр талд нүсэр бүтээн байгуулалт нүргэлж буй дүр зураг бол зэрэглээ бус Оюу Толгой. Ийшээ зорих мянга мянган залуусын хүсэл мөрөөдөл нь Оюу Толгойг бүтээлцэж буй билээ. Өмнийн говийн хэвлийд буй зэсийн арвин их нөөцтэй орд монголчуудад юу авчрах вэ? Та бидний амьдралд ирэх жилүүдэд ямар өөрчлөлт орох бол оо. Монголын маргаашийн маргааш ямар байх вэ? Үүнийг л цаг агаарын мэдээ мэт хамгийн ихээр сонирхож буй.

Оюу Толгой төсөл зөвхөн өмнөговьчууд болоод Канадын уул уурхайн Айвенхоу Майнз компанийн өмч биш шүү дээ. Тиймээс л Оюу Толгойтой маргаашийн тухай Тантай ярилцах гэсэн юм. Монгол Улсын түүхэнд гарч байгаагүй хамгийн том хөгжлийн хурдасгуур хэмээн Оюу Толгойн гэрээг батлах үеэр тэмдэглэж байсан. Үнэхээр төсөл нь, хөрөнгө оруулалт нь, үр өгөөж нь том болохоор Оюу Толгой төвтэй Монголын эдийн засаг хэмээн өдгөө нэрийдэж буй.

Хамгийн сүүлийн үеийн мэдээгээр төслийн нэг жилийн хөрөнгө оруулалтын барилгын хэмжээ манай орны эдийн засгийн гуравны нэгтэй тэнцэж байгаа аж. Эдийн засагч Д.Жаргалсайхан “Оюу Толгойн үйл ажиллагаанд иргэн бүр хяналт тавих шаардлагатай” хэмээн онцлов. Тэрбээр “өмнөд бүсэд дэд бүтэц болоод хүн амын шинэ соёл иргэншил бий болно. Тиймээс бидний хандах чигээс хамаарч уул уурхайг дагасан тогтвортой хөгжил хөгжих боломжтой” гэлээ. Уул

уурхай, мал аж ахуй Галбын говьд зэрэгцэн оршиж, малчин, уурхайчин ажиллаж амьдрах таатай орчинг өмнийн говиос харах учиртайг ийн хэлсэн юм.

Оюутолгойн олборлолт хийж эхлэх үед есөн их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт манайд цутгах юм байна. Товчхон хэлбэл, энэхүү их мөнгөний урсгал нь манай улсын эдийн засгийн хөгжлийг түргэсгэх хөшүүрэг хэмээн СЭЗДС-ийн багш Ц.Батсүх тэмдэглээд, баялгийн зохицуулалтыг ижил тэнцүү хүртээмжтэй хуваарилахад анхаарах шаардлагатай гэв. Зэсийн ордоос үүдэн ирэх 2015 хүртэл манай улсын ДНБ-ий өсөлт жилд дунджаар 13 хувь байж, нэг хүнд ногдох ДНБ хоёр дахин өсөх таамаглалыг эдийн засагчид дэвшүүлж байна. Одоогийн Засгийн газраас авч хэрэгжүүлж буй цалин, тэтгэврийн нэмэгдэл уул уурхайн хөрөнгө оруулалттай шууд холбоотойг уншигч та мэдэх билээ.

Өнөөдрийн байдлаар өмнийн говийн Оюу толгой төсөлд 14 мянган хүн ажиллаж байгаагаас үүний 10 гаруй мянга нь монголчууд. Ирэх 2013 онд Оюу Толгой уурхайгаас олборлолт хийж эхлэх үед 3000 гаруй монголчууд шууд ажиллах боломж нээгдэх ажээ. МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн судлаач, багш нар Оюу Толгой төслийн Монголын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тодорхойлсон байна. Чухамдаа Оюу Толгой төслийг “Эдийн засагт мандаж буй нар” хэмээн түүнийг эдийн засагчид нэрлэх болжээ.



► Мандаж буй нар эдийн засгийн эрчимтэй өсөлтийн хөшүүрэг төдийгүй улс орны хөгжлийн гарц болохыг Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн захирал Ч.Отгочулуу тайлбарлаж, эдийн засгаа төрөлжүүлэхэд анхаарах шаардлагатай байна гэв.

Уул уурхайн талаар залуу эдийн засагч хэлэхдээ “Уул уурхайд ханаж болохгүй. Уул уурхайн салбар валютын ханшийг тогтворгүй болгож байна. Цалингийн зардлыг өсгөж байна. Бусад салбар сайн ажилтнаа өөрийн салбартаа авч үлдэхийн тулд цалингаа нэмэгдүүлэх болсон. Тиймээс одоохондоо уул уурхайн салбар бусад салбартаа эерэг нөлөөгөөс илүү сөрөг нөлөө нь их байна” гэж дүгнэв. “Гэхдээ Оюу Толгой төслөөр Монголыг дэлхий мэддэг болсон. Дөрвөн уулын цаана уул даваа, гүвээ байдаг болохыг ч монголчуудад таниулсан” гэв. “Хуучин хүү” шинэ хүү болох үйл явцыг уул уурхай монголчуудад олгож байгааг тэрбээр хэллээ. Цаашид уул уурхайн том ордуудад төрөл бүрийн бараа үйлчилгээ үзүүлдэг сүлжээг бий болгоход бид анхаарах шаардлагатайг учирласан юм. Учир нь, өдгөө Оюу Толгой, Таван Толгой үйлдвэрлэл явуулахдаа ихэнх бараа бүтээгдэхүүнээ гаднаас авч байна. Ажиллах хүчнээ ч ялгаагүй гаднаас авч байгаа нь сул тал болохыг онцлоод уул уурхай манай эдийн засагтай хамааралгүй юм шиг харагдаж байгааг цохон тэмдэглэсэн юм. Мөн Монголын бэлтгэн нийлүүлэгч компани маш өндөр үнэтэй хүү, богино хугацаатай зээл авч байна. Уул уурхайг тойрч ажлын байр бий болгож буй аж ахуйн нэгж санхүүгийн хувьд сууриараа сул талтай байгаа” хэмээн эдийн засагч Ч.Отгочулуу тайлбарлаад уул уурхайн томоохон хөрөнгө оруулагчдаас суралцах зүйл маш их байгаа гэлээ.

Оюу Толгой төслийн нөлөөгөөр 2020 он гэхэд Монголын эдийн засаг 35 хувь өсөж, энэхүү төслөөс жилд дунджаар 800 тэрбум төгрөгийн орлого олно хэмээн тооцоолжээ. Ингэхдээ зэсийн үнийг маш багаар тооцсон байна. Монгол

Улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 57 мянгад хүрснийг Үндэсний статистикийн хорооноос мэдээлсэн билээ. Тэгвэл Оюу Толгой төслийн нэг ажлын байр бүрт эдийн засагт дөрвөн ажлын байр бий болно гэсэн таатай мэдээ чих дэлссэн юм.

Манай улсын хувьд хөрөнгө оруулалтын хамгийн таатай орчин хэмээн гадаадын хөрөнгө оруулагчид шохорхох болсон. Дэлхийн банк, Азийн хөгжлийн сангаас гаргасан судалгаанд энэ онд эдийн засаг нь хамгийн өндөр өсөлттэй байх Азийн 10 орны нэг нь Монгол хэмээн тэмдэглэжээ. Эдийн засгийн өсөлт ийн өндөр байх шалтгаан нь Оюутолгой төсөл аж. Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын захирал Н.Энхтайван “Манай эдийн засаг энэ онд 25,6 хувиар өснө гэсэн тооцоо судалгаа гарсан. Үүнд чиглэж 2012 оны төсөв батлагдсан” хэмээн ярьсан юм. Тэрбээр Оюу Толгой төслийн талаар хэлэхдээ “Дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн том төсөл. Уул уурхай дагасан хөрөнгө оруулалтын хэмжээ энэ онд 17 их наяд төгрөгт хүрэхээр байна. Эдийн засгийн таамаг өсөлт 25.6 хувиар өсөхөд Оюу Толгойн үйлдвэрлэл нөлөөлсөн” гэв. Монголын эдийн засагт мандаж буй нар болох Оюу Толгой төсөл чухамдаа эдийн засгийн өсөлтийг тодорхойлж буй нь энэ.

Харин эдийн засагч Д.Жаргалсайхан “Оюу Толгойн бүтээн байгуулалтын хөрөнгийн 34 хувийг Монголын тал гаргаж байгааг монголчууд бид мартаж учиргүй. Тиймээс гадаадын хөрөнгө оруулалт ил тод. Үйл ажиллагааны зардал тодорхой, түүнд бид хяналт тавих ёстой” гэв. “Оюу Толгой зэсийн ордын эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ” судалгаанд тэмдэглэсэнээр 2020 онд гэхэд нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ өнөөгийнхөөс 34 хувиар илүү байх аж. Энэхүү ДНБ-ий өсөлтийг иргэдийн амьдралд үнэ цэнэтэй болгохын тулд засаглалаа тунгалаг байлгахыг эдийн засагчид эцэст нь зөвлөж байлаа. ■





Фотог зохиогч

Мэргэжлийн хүний үг

“Өнөөдөр би ажилдаа нийтийн тээврээр ирсэн”

Э.Зоригт

“Ногоон эдийн засгийн өсөлт” ТББ-ын тэргүүн “Эко-Ази” дээд сургуулийн захирал Ц.Адъяасүрэнтэй ногоон эдийн засгийн талаар ярилцлаа.

-Байгаль орчны гавьяат гэдэг эрхэм хүндтэй шагналыг дөнгөж аваад буй танд баяр хүргэе. Та өөрийгөө Монголын байгаль орчны салбарт ямар үүрэг гүйцэтгэсэн гэж боддог вэ?

-Баярлалаа. Саяхан Монгол Улсад анхны ардчилсан үндсэн хууль баталсны 20 жилийн ойн баяр болж өнгөрлөө. Үндсэн хууль гэдэг бол Монгол Улсын түүхэнд үлдэх үнэт зүйл. Тиймээс анхны ардчилсан Үндсэн хууль батлалцахад бусдаасаа илүү хувь нэмэртэй оролцсон гэж үзэж зургаан хүнийг төр шагналаа.

Би 1975 оноос эхлээд өнөөдрийг хүртэлх хугацаанд байгаль орчны чиглэлээр тасралтгүй ажиллаж байна. Өөрийгөө энэ олон жил ажилласны хувьд байгаль орчны асуудалд дөрвөн гол үүрэг гүйцэтгэсэн болов уу гэж боддог. Нэгдүгээрт, анх ажиллаж эхэлснээс одоог хүртэл байгаль орчны сансарын тандан судалгааг Монголд хөгжүүлэх шинэ технологи, арга туршлагыг төлөвшүүлэх чиглэлд багагүй зүйл хийсэн. Энэ нь байгаль орчинд мониторинг хийх, нөөцийг

судлах зэрэг ажил юм. Энэ ажлыг Монгол Улсад хөгжүүлэхэд салбарын хамтран зүтгэгчидтэйгээ ажиллаж, удирдаж явлаа. Хоёрдугаарт, 1990-ээд оноос БОАЖЯ, Байгаль орчны хяналтын Үндэсний хороо гээд олон төрийн байгууллагатай одоо ч хамтран ажиллаж байна. Эдгээр яам, тамгын газартай байгаль орчны талаар төрийн бодлого боловсруулахад өөрийн гэсэн хамтын ажиллагаа, хувь нэмрийг оруулсан гэж бодож байгаа. Гуравдугаарт, байгаль орчныг хамгаалахад олон талын оролцоог өндөрсгөхөд хувь нэмрээ оруулсан. Тэр дундаа байгалийн нөөцийг ашиглахад хамтын менежмент чухал асуудал байсан юм. Энэ талын үзэл баримтлалд төрийн бодлогыг чиглүүлэхэд хүчин зүтгэж байна. Энэ санаагаа өнгөрсөн онд Шинжлэх ухааны академийн Гео экологийн хүрээлэн, БОАЖЯ-наас гаргасан Байгаль орчны мастер төлөвлөгөөнд тусгаж оруулсан. Дөрөвдүгээрт, Байгаль орчны салбарын хүний нөөцийг бүрдүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулсан гэж үзэж болох байх. 2000 онд байгаль орчин менежментийн “Эко-Ази” дээд сургуулийг үүсгэн байгуулж одоо хүртэл үйл ажиллагаа явуулж байна. Одоогоор 1000 гаруй боловсон хүчин бэлтгэн гаргаад байгаа. Экологи байгаль хамгаалал, үнэлгээ мониторинг, газрын зохицуулагч, аялал

жуулчлал гээд дөрвөн чиглэлээр мэргэжил эзэмшүүлж төгсгөдөг. Тус сургууль нь шинжлэх ухаан, боловсрол, үйлдвэрлэл гэх гурвалсан сургалтыг явуулдагаараа онцлог юм. Манай оюутнуудын хамгийн гол давуу тал нь дэлхийн нийтийн яриад буй ногоон сэтгэлгээтэй болж төгсдөг.

-Ногоон сэтгэлгээ гэж юу вэ?

-Хүний амьдрал өнөөдөр үйлдвэрлэл, хэрэглээ хоёр дээр л явж байна шүү дээ. Үүнийгээ эдийн засаг гэдэг. Тиймээс энэ хоёрын тэнцвэртэй байдлыг хангах тал дээр анхаарч эхэлсэн. Тийм ч учраас илүү зүйл үйлдвэрлэхгүй, үйлдвэрлэсэн тэр бүтээгдэхүүнээ аль болох хэмнэлттэй, урт удаан хугацаанд олон дахин хэрэглэх зорилгыг бий болгоод байгаа юм. Үүнийг ногоон эдийн засаг гээд байна. Гэхдээ ногоон эдийн засаг нь өргөн ойлголт л доо. Харин байгалийн нөөц, түүхий эд, эрчим хүч гээд бүгдийг хэмнэх шаардлага байна. Үүнийг л ногоон үзэл санаа гэж нэрлээд байгаа юм. Хамгийн энгийн жишээ гэхэд Та нэг удаагийн цаасан аяга хэрэглэх үү, аль эсвэл эдэлгээ урттай олон дахин ашиглаж болох шаазан аяга хэрэглэх үү гэдэг дээр л сонголт хийх юм. Өнөөдөр дэлхий нийт нэг удаагийн хог ихээр бий болгодог хэрэглээнээс татгалзаж эхлээд байна. Хоол идэхдээ ч гэсэн өөртөө тохирсон хэмжээтэйг сонгох нь чухал. Зарм хүмүүс учиргүй их хоол хийчихээд хаях тохиолдол цөөнгүй. Тэр нь эргээд эдийн засгийн хувьд үргүй зардал, байгаль орчны тухайд бохирдол нян үүсэх шалтгаан болж байна гэсэн үг. Энэ мэт энгийн зүйлс л ногоон сэтгэлгээ юм даа. Түүнээс биш, тийм айхтар хол чанадын зүйл биш л дээ.

- Та өнөөдөр өглөө босоод ногоон хөгжилд ямар хувь нэмэр оруулсан бэ?

-Би дээр хэлсэн дээ. Ногоон сэтгэлгээ, ер нь ногоон гэх ойлголтууд маш энгийн зүйлээс эхэлдэг гэж. Тэгвэл ногоон хөгжилд хувь нэмрээ оруулах гэдэг ч энгийн зүйлээс эхэлнэ. Тухайлбал, өнөөдөр би ажилдаа нийтийн тээврээр ирсэн. Энэ нь агаарын бохирдлоос эхлээд эдийн засагт хэмнэлттэй. Ер нь ажлын таван өдрийн хоёроос гурван өдөр нийтийн тээврээр зорчдог. Өнөө өглөө бас Ойн бодлого боловсруулах хуралдаанд оролцсон юм байна.

-Та ярьж байна л даа ногоон хөгжил энгийн зүйлээс эхэлнэ ээ гэж. Тэгвэл манай залуучууд ногоон хөгжилд хэрхэн хувь нэмрээ оруулж болох вэ?

► -Өглөө босоод шүдээ угаах усаа хэмнэхээс авахуулаад олон зүйл дээр ярьж болно л доо. Оройдоо хүн байхгүй өрөөнийгөө гэрлийг унтраах гэдэг ч юм уу. Аль болох нийтийн тээврийн хэрэгслээр зорчих. Бүр боломжтой бол унадаг дугуй унах гээд энгийн хэрнээ олон шийдэл байж болно. За тэгээд томоохон хувь нэмэр оруулъя гэвэл мод тарьж болж байна. Гэхдээ мод тарих үйл ажиллагаанд хүн бүр оролцоно гэхэд жаахан учир дутагдалтай. Тиймээс гэрэл, цахилгаанаа хэмнэхээс л эхлэх хэрэгтэй. Хоолны зохистой хэрэглээ ч чухал. Сүүлийн үед тамхидалт газар авч байна. Энэ нь таны эрүүл мэндэд хортойгоос гадна эдийн засагт ч гарзтай зүйл. Хог хаягдал ч их гарна. Бид ногоон хөгжил, ногоон хүмүүжил, ногоон эдийн засаг, ногоон боловсрол гэж яриад л байна. Энэ бүхэн бидний амьдралд байдаг л энгийн хэвшлийг төлөвшүүлэхийг хэлж байгаа юм.

Манайд нэг тийм зүйр үг байдаг даа “Хүн хэлэхээс нааш ухаардаггүй, цааш чичихээс нааш цоордоггүй” гэж. Тиймээс бид сайн ухуулан таниулж чадахгүй байгаа болохоор иргэдийн амьдралд төлөвшихгүй байх шиг. Аж ахуйн нэгж, албан байгууллагын хувьд ч мөн адил. Бид нийгмийн хариуцлага гэж ярьдаг. Компаниуд энэ талаар ажлууд хийдэг. Тэгвэл бид компанийнхаа үйл ажиллагаанд ногоон бодлогыг тусгаж өгөөд энэ тал дээр өөрсдийн ажлын үйл явцыг чиглүүлээд хөрөнгө оруулаад явах хэрэгтэй. Төр, засгийн хувьд урамшууллын системийг нь бий болгоод өгөх хэрэгтэй. Төр гэдэг чинь ер нь бол үйлчилгээний байгууллага шүү дээ. Тиймээс хүнд сурталгүй байх учиртай. Мөн эрх зүйн талаас нь таатай орчинг бүрдүүлэх хэрэгтэй байна. Үүний тулд өмнөх хуулиудад үнэлэлт дүгнэлт өгч шинээр гарч ирж байгаа хуулиндаа ногоон сэтгэлгээгээр хандаж, баталж хянадаг байх нь чухал.

Мөн ногоон бүтээмжийг дэмжсэн урамшууллын систем хэрэгтэй байна. Манайд өнөөдөртөө тийм зүйл алга. Түүнчлэн эдийн засгийн үзүүлэлтүүдээ эргэж харах хэрэгтэй. Дотоодын нийт бүтээгдэхүүний тэдэн хувь нь ногоон бүтээмж шингэсэн байх ёстой гэдэг ч юм уу. Тэгж чадвал жирийн иргэнээс аваад, банк санхүүгийн томоохон нэгдлүүд ч өөрсдөө үйл ажиллагаандаа тусгаад л явчих зүйл.

-Саяхны судалгаагаар дэлхий дээр байгаа долоон тэрбум хүн, долоон их наяд хүний хэрэглэх хэмжээний илүүдэл хэрэглээтэй байна гэж гарсан байсан. Та ч хэлж

байна хэмнэх гамнах талаар. Тэгвэл монголчуудын хамгийн их илүүдэл хэрэгцээ хаана байна вэ?

-Өнөөдөр хамгийн их илүү байгаа анхаарал хандуулах ёстой хэрэглээ бол түлш, эрчим, усны хэрэглээ байна. Хямд төсөр байгаа болоод ч тэр үү, эрчим хүчний хэмнэлт гэдгийг мэдэхгүй байна. Маш их үрэлгэн загнадаг. Энэ тал дээр анхаарах нь туйлын чухал. Дараагийн чухал зүйл бол ус. Өнөөдөр ус хямдхан байна. Энэ байдлаараа удаан үргэлжлэх юм бол цэвэр ус алтнаас үнэтэй болох вий. Нөөц дуусна. Одоо бол яах вэ байгаль өөрөө зохицуулаад үйлдвэрлэж байгаа. Энэ зохилдолгоо алдагдах магадлал тун өндөр байна. Алдагдаж ч эхэллээ. Туйлын мөс хайлж байна, дэлхийн дулаарал хурдасч байгаа гээд л экологийн тэнцвэр алдагдаж байгаа баримт олон бий.

-Мэдлэгийн эдийн засаг, ногоон эдийн засаг юугаараа ижил төстэй болоод ялгаатай вэ?

-Нэг зоосны хоёр тал гэж хэлж болох юм. Сүүлийн үед мэдлэг шингэсэн, хүний тархи оюуныг хөгжүүлсэн тийм бүтээгдэхүүн, эдийн засаг руу явж, энэ зүгт уриалж байгаа. Оюуны чадамжаар бий болсон үйлдвэрлэл, санаа санаачлагыг дэмжиж байна. Энэ бол чухал салбар. Тухайн салбарыг хөгжүүлэхийн тулд мэдээллийн технологи ихээхэн үүрэг гүйцэтгэж байгаа. Энэ нь өөрөө ногоон эдийн засгийг дэмжиж байгаа хэрэг юм. Тухайлбал, сүүлийн үеийн техник, хэрэгсэл цахилгааны хэмнэлттэй болсон. Мөн бага зардлаар өндөр чанартай бүтээгдэхүүн хийхийг дэлхий

нийт зорьж байна. Эрдэмтэд энэ талаар судалдаг болчихож. Хамгийн чухал нь байгальд ээлтэй үйл ажиллагаа. Байгалиа хэрхэн сахин хамгаалж, арчилж тордох вэ гэдэг дээр тархиа ажиллуулдаг болсон. Энэ хоёр ойлголт нь хоёулаа тархиа ажиллуулж мэдлэг бий болгоод түүнээсээ баялаг бүтээж байна. Ер нь бид үр ашиг зардлын тооцоог алхам тутамдаа хийж байх ёстой юм. Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хэр алдагдал, хаягдал гарч байгаа, түүнийг яаж мөнгө болгож болох вэ гэдэг арга замыг олох хэрэгтэй. Энэ нь менежментийг сайжруулж ашигтай, байгальд ээлтэй ажиллах бололцоог буй болгож байдаг. Эдгээртэй холбоотой өнөөдөр гурван “Э” гэх ойлголт гарч ирсэн. Энэ нь Эрс багасгах, эдэлгээг уртасгах, эргүүлж ашиглах гэж буй юм. Дэлхий нийт өдгөө хогийг шууд булж устгадаг арга барилаас татгалзаж дахин боловсруулж түүнийгээ эргүүлэн ашиглаж эхлээд удаж байгаа. Энэ бүгд ногоон эдийн засаг, мөн мэдлэг шингэсэн эдийн засаг юм.

-Дэлхийн хэмжээнд ногоон хөгжлөөр тэргүүлж, үлгэр дууриал болж байгаа ямар орон байна вэ?

-Бид евро стандарт гэж ярьдаг. Ер нь бол Европын орнууд энэ тал дээр стандарт бий болгочихсон гэж хэлж болно. Энэ нь хүний амьдрах таатай орчинг бүрдүүлэх тал дээр ихээхэн анхаардаг бодлоготой уялдаатай. Азийн орнуудаас БНСУ, Япон байна. Ногоон хөгжил дэлхий нийтэд ихээхэн хурдтай хөгжиж байна. Тиймээс монголчууд энэ тал дээр анхаарч үзэх нь чухал.



► Огт ярихгүй биш ярьж байна л даа. Гэхдээ илүү өргөн фронтоор давших хэрэгтэй. Тэр дундаа уул уурхай ингэж хурдтай хөгжиж байгаа өнөө үед ногоон хөгжлийг үүнтэй яг адил хөл нийлүүлэн хөгжүүлэх нь чухал. Монгол Улс ногоон хөгжлөөс хоцорвол хохироод л дуусна. Хуучны хомхой сэтгэлээр хандаж огт болохгүй.

-Таны бодлоор хамтад нь хөгжүүлэх ямар боломж байна вэ?

-Түрүүний хэлдгээр хууль эрх зүйн орчин нь бүрдээд, сэтгэлгээ нь суугаад, хамгийн гол нь уул уурхай ярьж байгаа учраас технологийн хөгжил чухал. Байгальд ээлтэй дэвшилт технологийг нэвтрүүлэх тал дээр анхаарч ажиллах нь зүй ёсны хэрэг. Түүнчлэн ил тод байдал гол хөшүүрэг юм. Ямар ашиг олж байна, хэр зэрэг татвар төлсөн, түүний хэдэн хувийг нийгэмд зориулсан гэдэг ч юм уу. Ингэж чадвал хариуцлагатай уул уурхай бий болно. Мөн монгол хүний байгалиа дээдэлсэн зан заншил, сэтгэхүй дээр тулгуурлах хэрэгтэй.

-Монгол зан заншил гэлээ. Олон хүний хэлж байгаагаар монгол уламжлалаа сэргээж чадвал ногоон өсөлт тэр бололтой. Энэ талаар

бодлоо хуваалцахгүй юу?

-Ер нь бол тийм. Монгол хүний олон мянган жил амьдарч ирсэн дадал заншил нь байгальтайгаа илүү ойр, хамгийн бага хэрэглээтэй, байгаль орчноо тогтвортой ашигладаг тийм л ард түмэн байсаар ирсэн. Энд яриад байгаа ногоон хөгжил тэнд агуулагдсан байгаа юм. Тухайлбал, монгол хүн өөрийн гэсэн аяга, халбагатай явдаг байсан. Энэ нь нөгөө эдэлгээ уртасгах арга хэмжээ. Малаа мориор хариулж ирсэн. Гэхдээ сүүлийн үед мотоциклиор малдаа явдаг болж. Гэхдээ мориороо хариулж яагаад болохгүй гэж. Хэдийгээр шууд утгаараа мотоцикль байгальд үзүүлэх хор нөлөө бага ч ажиллуулах бензинийг гаргаж авахаас эхлээд байгаль хортой үйл ажиллагааг дэмжиж байна гэсэн үг л дээ. Тиймээс эрдэмтэн судлаачид монгол зан заншлын талаар судалж, орчин үеийн нийгэмд нутагшуулах ажлыг хийх нь чухал болоод байна. Энгийн амьдралын хэвшлээс гадна компаниудын менежментэд нэвтрүүлэх шаардлагатай.

-Саяхан “Тогтвортой хөгжил”-ийн талаар хурал болж өнгөрсөн. Тэгвэл манай улс тогтвортой хөгжиж чадсан

болов уу?

-Миний хувьд чадаагүй гэж хэлнэ. Бүх талаараа зөв тогтвортой хөгжих хэрэгтэй. Тогтвортой гэдэг чинь бүх талаараа тодорхой баланстай. Эрсдэл даах чадвартай байх нь чухал. Харин ингэж чадахгүй байгаа учраас л бид өнөөдөр хүрэн эдийн засгаас ногоон эдийн засагт шилжих зайлшгүй шаардлагатай. Ногоон төрийн бодлого, үзэл бодлын талаар яриад зарим нь үйл ажиллагаандаа тусгаад байгаа юм. Хамгийн наад зах нь бид байгаль эхдээ хоргүй үйл ажиллагаа явуулах учиртай.

-Ногоон хөгжилд “Ногоон эдийн засгийн өсөлт” ТББ-ын оролцоо үүрэг юу байх вэ?

-Төрийн бус байгууллагын хувьд нэн түрүүнд хийх ёстой ажил бол олон нийтэд ногоон хөгжлийн талаар сурталчлах явдал юм. Энэ тал дээр “Mongolian Economy” сэтгүүлийн хамт олон ихээхэн үүрэг хүлээн ажиллана. Иргэний нийгмийн зүгээс энэ төрлийн төрийн бус байгууллага байгуулж байгаа нь ихээхэн сайшаалтай. Тиймээс бид өөрсдөө бусдад үлгэр дууриал болох учиртай юм. ■



Rio+20+Монгол

Тогтвортой хөгжье

Хүн төрөлхтөн цаг ямагт хөгжилд тэмүүлсээр ирсэн. Эрх мэдэл, эд мөнгийг хөшүүрэг болгон эдийн засгийн хувьд хүчирхэгжиж ирэхийн хэрээр нөгөө талаас байгаль орчны асуудал хурцаар тавигдах болсон.

Ногоон хөгжил, ногоон эдийн засгийг түлхүү анхаарч хөгжихийг улс орнууд чиг баримжаагаа болгох болсон билээ. Тэгвэл манай улс ч гэсэн сүүлийн 20 гаруй жилийн дотор энэ чиглэлд анхаарч ирснийг салбарынхан

онцолдог. Тэгвэл энэ сарын 14-15-нд Төрийн ордонд “Тогтвортой хөгжил-Байгаль орчны засаглал” үндэсний чуулган, Байгаль орчны ажилтны улсын зөвлөлгөөн болсон. Бүх аймгийн Засаг дарга, БОАЖГ-ын дарга нар, байгаль хамгаалагч, улсын байцаагч зэрэг холбогдох 800 орчим төлөөлөгч уг хуралд оролцсон билээ. “Улс орны цаашдын хөгжлийн тухай асуудал, ялангуяа байгаль хамгаалал, эдийн засгийн хөгжил, нийгмийн дэвшлийн асуудлыг цогцоор нь авч үзсэн тогтвортой хөгжлийн тухай ярих нь эдийн засгийн огцом өсөлтийн үедээ ирээд байгаа Монгол Улсын хувьд нэн чухал, зайлшгүй анхаарал хандуулж ярих ёстой асуудлын нэг болоод байна” хэмээн БОАЖ-ын сайд Л.Гансүх чуулганы нээлтийн үеэр онцолсон.

Улс орны өнцөг булан бүрээс цугларсан байгаль орчны төлөөлөгчид өөрсдийн нутаг оронд тулгамдаж буй байгаль орчны асуудал, түүнээс гарах арга зам, зохицуулалт хэрэгтэй байгаа талаараа санал бодлоо солилцож, Ерөнхий сайдад хүртэл дуу хоолойгоо хүргэсэн. Түүнчлэн хурлын үр дүн буюу гарсан шийдлээ УИХ, Засгийн газар, төрийн албан хаагчид, орон нутгийн

▸ өөрөө удирдах ёсны төлөөлөгчид, бүх шатны Засаг дарга, иргэний нийгмийн болон бизнесийн байгууллага, ард иргэдэд хандсан долоон зүйл бүхий уриалгыг гаргасан юм. “Бид та бүхний дуу хоолой, ухаан бодол шингэсэн хурлын үр дүнд гарсан уриалгаа бүх шатанд ажил хэрэг болгон хэрэгжүүлэхийн төлөө ажиллана. Үүнд хүн бүрийн оролцоо хамгаас чухал” хэмээн энэ үеэр БОАЖ-ын сайд Л.Гансүх тэмдэглэлээ.

Бид тогтвортой хөгжиж чадаж байна уу?

Дэлхийн эдийн засаг, техник технологийн үсрэнгүй хөгжил, хүнд үйлдвэрлэл, хүн амын хязгааргүй хэрэглээнээс үүдэж эх дэлхийтэйгээ бодлогогүй, тооцоогүй харьцаж байсны балаг өдгөө тодрон гарч ирж буй. Ингэхдээ дулаарал, уур амьсгалын өөрчлөлт, байгалийн нөөцийн хомсдол, орчны бохирдол, доройтол нь бодит аюул болон цэнхэр гаригийн хүн ам, улс үндэстэн бүрт хамаатай асуудал болжээ. Манай улсын хувьд сүүлийн жилүүдэд байгаль орчны чиглэлээр тодорхой бодлогоо чиглүүлж, төсөл хөтөлбөр, арга хэмжээ авч байгаа ч усны хомсдол, цөлжилт, хөрсний доройтол, агаарын бохирдол зэрэг асуудал байсаар байгааг салбарын сайд Л.Гансүх илтгэлдээ дурдсан юм. Ялангуяа нийслэл болон томоохон хотуудын агаарын бохирдол нэмэгдсэн, эрдэс баялгийн олборлолтын явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт хангалтгүй хийгдсэн, ойн нийт сангийн талбай багассан, усны бохирдол зарим газарт ихэссэн зэрэг сөрөг өөрчлөлтүүд гарсаар байгаад салбарын эрдэмтэн судлаачид санаа зовниж буйгаа хурлын үеэр илэрхийлж байсан. Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлт, хүний зохисгүй үйл ажиллагаанаас өдөөгдсөн цөлжилт нь экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулж, ядууралд нөлөөлөхүйц тулгамдсан асуудал болоод байгаа аж.

Уул уурхайд сөрөг нөлөө нь их байна

Энэ үеэр хөдөө, орон нутгийн БОАЖГ-ын дарга, мэргэжилтнүүд болон байгаль хамгаалагчид нь уул уурхайгаас үүдэлтэй хөрсний доройтол, эвдрэл болон тоосжилт, амьсгалын замын өвчлөлт их байгаа, гол горхи татарч, бохирдсоноос цэвэр усны хомсдол үүсч, хүн амын эрүүл мэндэд ч хортой нөлөө үзүүлэх хэмжээнд хүрч байгаа зэрэг тулгарч буй бэрхшээлтэй

асуудал бишгүй байгааг ярьж байлаа.

“Манай аймгийн хувьд газрын тос, уул уурхайн компаниудын үйл ажиллагаанаас үүдэлтэй хөрсний элэгдэл доройтол, тоосжилтын асуудал хүнд байна. “Петро Чайна Дачин Тамсаг” компани олборлосон тосоо Бичигтийн боомт, Баянхошуугаар тээвэрлэж гаргадаг. Тэд сайжруулсан зам тавьсан боловч шаардлага хангахгүй учраас хажуу талаар нь өдөрт дунджаар 60-70 машин явдгаас үүдэж их хэмжээний тоосжилт үүсэж иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөхийн зэрэгцээ малын бэлчээрийг талхалж байна” хэмээн Дорнод аймгийн Матад сумын байгаль хамгаалагч И.Батмөнх ярьсан юм. Мөн үүний нэгэн адил нөхцөл байдал Өмнөговь аймгийн Цогтцэций суманд 10 гаруй км газарт үүсээд буй зовлонг тус сумын байгаль хамгаалагч Т.Соёлмаа ч сануулж байсан.

Түүнчлэн иргэний нийгмийн байгууллагууд ч уул уурхай хөгжиж байгаа орон нутагт дэд бүтцийг нь шийдсэний дараа олборлох, тээвэрлэх үйл ажиллагааг явуулах нь зүйтэй гэдэгтэй санал нэгдсэн юм. Төрөөс уул уурхайтай холбоотойгоор ашиглалтын болон хайгуулын лиценз нэмж олгохгүй байх хэрэгтэй гэдэг саналыг цөөнгүй хүн хэлж байсан. Учир нь, одоо байгаа уурхайнуудын нөхөн сэргээлт хангалтгүй байгаа тул экологи, эдийн засгийн үнэлгээг хийж хариуцлага тооцох, уул уурхай орон нутгийн иргэдэд өгөөжөө өгөхөөсөө илүү сөрөг нөлөө үүсгэх нь их байгаа тул орон нутгийн харьяанд шилжүүлэх нь зүйтэй гэж олон хүн хэлж байлаа. Тухайлбал, Говь-Алтай аймгийн хувьд нутаг дэвсгэрийнх нь 60 орчим хувьд нь цөлжилт явагдаж, элсгүй газарт хүртэл элсээр шуурах болсныг аймгийн БОАЖГ-ын дарга Л.Түвд ярьсан. Тус аймгийн 14 сумын 30 гаруй нутаг дэвсгэр “нинжа” нарын гарт өртөж, 1000 орчим га талбай эвдрэлд оржээ. Бичил уурхай эрхлэгчдийн хууль ч хэрэгжихгүй байгаа аж. Тиймээс энэ тал дээр анхаарах нь зүйтэй гэдгийг ч тэрбээр онцлов.

Харин Өмнөговь аймгийн БОАЖГ-ын дарга О.Бадарч энэ талаар ярихдаа “Уул уурхайн нөхөн сэргээлтийн хувьд хаалтын төлөвлөлтийн асуудал чухал байна. Нөхөн сэргээлтийг өнөөдөр 30-40 жилийн дараа ямар байх вэ гэж алсыг харсан биш, нүд хуурсан байдлаар хийж байна” хэмээн онцолсон. Уул уурхайтай холбоотойгоор сүүлийн жилүүдэд байгаль орчин хэрхэн

сүйдэж байгаа талаар баримт дурдвал, Өмнөговь аймагт 2005 оноос хойш Тавантолгойгоос Гашуун сухайт хүртэл 250 орчим км газар үндсэндээ сүйдэж, 10 гаруй км-т айл амьдрах нөхцөлгүй болж, тоосжилтод өртөн, газрын хөрс, малын бэлчээр сүйджээ. Уг нь энэ газарт өнгөрсөн жил Ерөнхий сайдын захирамжаар экологи, эдийн засгийн үнэлгээ хийсэн боловч үр дүн нь огт харагдахгүй байгаа тухай ярьж байлаа. Тэгэхээр энэ асуудлыг нэн тэргүүнд шийдэх хэрэгтэй гэдгийг сум орон нутгийн төлөөллүүд хатуу шүүмжилсэн юм. Байгаль орчны экологи, эдийн засгийн үнэлгээг ном журмын дагуу хийж эхэлсэн тохиолдолд ихээхэн хэмжээний хохирол гарах нь тодорхой. Тиймээс энд эрх ашгийн томоохон сонирхол байгаа болохоор энэ тухай хууль нь батлагдаж, дорвитой арга хэмжээ авагдахгүй байх талтай” хэмээн О.Бадарч хатуухан хэлж байсан.

Хөгжлийн үндэс нь байгаль орчин

Ийнхүү уул уурхайн үйлдвэрлэлтэй холбоотойгоор байгаль орчин сүйдэж, тоосжилтоос үүдэлтэйгээр эрүүл мэндэд халтай байдал газар аваад байгаад олон хүн бухимдаж буйг байгаль хамгаалагчид, сум, орон нутгийн холбогдох албан тушаалтнууд хатуухан хэлж, дорвитой хариу авахыг хүслээ. Ямар ч атугай улс орон тогтвортой хөгжихөд байгаль орчны асуудал нэн тэргүүнд орно гэдэгтэй төрийн тэргүүнээсээ эхлээд салбарын бодлого барьж, чиглүүлж буй болон хэрэгжүүлж буй хүмүүс эрдэмтэн, судлаачид дуу нэгтэйгээр зөвшөөрч, сэтгэл шулуудан ажиллахаар болов. Уг хурлаас УИХ, Засгийн газар, иргэний нийгмийн болон бизнесийн байгууллага, ард иргэдэд зориулсан уриалга гаргасан юм. Уриалгад хурлаас гарсан шийдвэрээ шат шатандаа хэрэгжүүлж, мөрдөх нь чухал гэдгийг онцолсон. Түүнчлэн “Бид эх дэлхийгээ хойч үедээ өвлүүлэх биш тэднээс зээлж авсан” гэдгээ санах хэрэгтэй гэсэн мэргэн үг бий. Тиймээс цэнгэг сайхан устай, анхилам цэцэгс алагласан, цээждүүрэн амьсгалах цэвэр агаартай эрүүл ирээдүйг үр хойчдоо бэлэглэх үү, элсээр шуурсан, мод бут нь хатаж гандсан, ангаж цангасан гашуун ирээдүйг бэлэглэх үү гэдэг нэг талаараа иргэн хүн бүрийн гарт байгааг сануулья. ■

Уриалга

УТААНЫ ГОЛОМТОД УИХ-ЫН П

“Mongolian Economy” сэтгүүл, “Ногоон эдийн засгийн өсөлт” төрийн бус байгууллагаас Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ, НЗДТГ болоод холбогдох төр, засгийн байгууллагынханд хандан дараах уриалгыг гаргаж байна.



Нийслэлийн СХД-ийн Орбитийн тойрог. 2012.01.25-ны 08.38 цаг

ГИШҮҮДТЭЙ ХАМТ

Нийслэлчүүд бохир агаараар амьсгалж, утаа гамшгийн түвшинд очсоныг төр, засгийнхан харж мэдэж байгаа ч гэр хорооллын иргэд уушиг сэвтүүлсэн хорт утаан дунд өвлийн урт улирлыг хэрхэн өнгөрөөж байгааг тэр бүр мэдэхгүй. Өөрөөр хэлбэл, утаа гэр хороололд ямаршуухан

гамшиг дагуулж буйг төрийн түшээдэд мэдрүүлэх нь энэхүү арга хэмжээний гол зорилго билээ. Бид уг арга хэмжээндээ бусад хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг татан оролцуулж хамтран ажиллах болно.



Фотог Б.Бямба-Очир



Агаарын бохирдол

Хамгийн ойрын тэргүүн туршлага өмнө нь байхад яагаад...

Өвлийн улиралд Улаанбаатарт газардах мөчид хамгийн түрүүнд юу харагдаж байна вэ? Уул давсан гэр хороолол уу. Эсвэл барьж дуусаагүй өндөр барилгуудын дунд өргөгдсөн кран ёрдойн үзэгдэх юм уу. “Дэлхийн өвлийн хотуудын Дарга нарын холбоо”-ны 15 дугаар хурлын төлөөлөгчдийн заримаас энэ талаар сонирхоход “Онгоцны цонхоор сааралтсан утаа л харагдсан” хэмээн хэлж байлаа. Ийн товчхон хариулт өгсөн тэдний зарим нь гадагшаа гарах үеэрээ амны хаалт зүүхээ мартаагүй байсан.

Нэгэн үе “Азийн цагаан дагина” хэмээх нэрээр нь Монголын нийслэл Улаанбаатар хотыг гаднынхан анддаггүй байсан байж болох. Ялангуяа Өвлийн хотуудын Дарга нар Улаанбаатарыг дээрх тодотголоор нь сайн мэддэг байсан биз. Харин Азийн цагаан дагина гэдэг сайхан нэрээ утаатай Улаанбаатар гэдэг нэрээр солиод удаж байгаа Монголын нийслэлийн утаа жилээс жилд улам бүр өтгөрч байгаа учраас сүүлийн жилүүдэд монголчуудын зарим бололцоотой хэсэг нь өвлийн улирлыг гадаадад өнгөрөөдөг болсон. Монголд албан ажлын шугамаар ажиллаж амьдардаг гадаад хүмүүсийн хувьд хүнд нөхцөлд ажиллаж байгаа учраас чалингийн нэмэгдэл ахиу авдаг байна.

Гэхдээ тэдний олонх нь болж өгвөл Туулын хөвөө, Зайсан, Нүхт гээд Улаанбаатарын хамгийн утаа багатай хэсэгт амьдрахыг бодно. Сүүлийн үед дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай томоохон компанийн захирлууд ч Улаанбаатарын утаанаас зүрхшээгээд Бээжин, Хөх хот, Хонконгоос үйл ажиллагаагаа явуулж, өдөр тутмын ажлаа зохицуулдаг болсон гэж дуулдсан. Зарим нь шаардлагатай үед өглөө ирээд оройдоо нислэгээ тааруулж буцдаг гэсэн. Утаа, Улаанбаатарын хөгжил ингэж л дэлхийн жишигтэй нийцэж байна. Эрүүл мэндээ дээд зэрэгт тавьж буй нь тэдний зөв өө.

Арван тав дахь удаагаа болж буй Дэлхийн өвлийн хотуудын Дарга нарын чуулга уулзалт Улаанбаатарт анх удаа болж байгаа бөгөөд Японы Саппоро, АНУ-ын Анкорейж, БНХАУ-ын Харбин, Шэньян, Эстон улсын Маарду, Виймши, БНСУ-ын Таебэк, Хванчеон, ОХУ-ын Улаан-Үүд хотын дарга нар хүрэлцсэн ирсэн юм. Тус холбоонд Улаанбаатар хот 1998 онд элсжээ. Чуулга уулзалт “Өвлийн хотуудын эрчим хүч, дулааны түгээлт ба зохистой хэрэглээ” гэсэн сэдвээр өрнөсөн юм. Тэгсэн хэдий ч ярилцах сэдэв нь агаарын бохирдол, утаа руу хэлтийг орчихоод байв.

Улаанбаатар хотын хэмжээнд

инженерийн иж бүрэн хангамжтай орон сууцанд 120 мянган айл, уламжлалт галлагаатай гэр хороололд 200 мянган өрх амьдарч буй. Хурлын үеэр Улаанбаатарыг яаж амьдрахад таатай, эрүүл орчинтой болгох вэ гэдэг талаар гаднын төлөөлөгчдийн заримаас сонирхлоо.

Улаанбаатар ногоон байгууламжаа нэмэгдүүлэх шаардлагатай

Уеда Фумио /Саппоро хотын дарга/:

-Дан ганц өвөл болдог гэлтгүй дэлхийн бусад хот ч гэсэн агаарын бохирдол, утааны асуудалтай тулгарч байдаг. Саппоро хотын хувьд 1980-аад оны дундуур утаатай, саарал хот байлаа. Харин энэ асуудлаа бүрэн шийдвэрлэж чадсан. Улаанбаатар хотын хувьд утаагүй зуух тараасан нь утааг бууруулах нэг арга. Мөн дулааны асуудлаа нэн даруй шийдээсэй гэж хүсэж байна. Утааг бууруулахаас гадна байгаль орчинд ээлтэй гэдэг үүднээс ногоон байгууламжаа нэмэгдүүлэх шаардлагатай. Улаанбаатар хотыг 20-25 жилийн дараа байгаль, экологид ээлтэй дэлхийн шилдэг хотын нэг болно гэдэгт итгэж байна.

Өвлийн улиралд модоо дулаалдаг

Халдо Оравас /Эстонийн Маарду хотын төлөөлөгч/:

-Маарду хоттой жишихэд Улаанбаатар харьцангуй хүйтэн байна. Манай хот ихэвчлэн богино настай ургамал тарьдаг. Зуны дулаан цагт л гэхэд нэг зун л цэцэглээд, хотод маань өнгө үзэмж нэмэх ургамал тарина. Харин ихэнх модоо өвөл дулаалдаг. Зориулалтын дулаан хучлагаар ороодог. Мөн гацуур зэрэг байнга ногооноороо байдаг мод тарьдаг.

Манайх агаарын бохирдол ихтэй дэлхийн 10 орны нэг

Жан Жунь /Шэньян хотын байгаль хамгаалах газрын мэргэжилтэн/:

-Манайх Хятадын аж үйлдвэрийн хот учраас дэлхийн агаарын бохирдол ихтэй арван хотын нэг. Тиймээс экологийн хот болохоор “Хөх тэнгэр, ногоон газар, тунгалаг ус” тэмээн уриалан, агаарын бохирдолтой тэмцэж байна. Агаар бохирдуулж буй эрчим хүчний эх үүсвэрт хяналт тавьж, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж буй үйлдвэрүүдэд хариуцлага тооцсон. Хотын иргэдээс 500 гаруй хүнийг байгаль хамгаалагчаар ажиллуулж байна. Агаар ихээр бохирдуулж буй ▶

хүнд үйлдвэрийг хотоосоо нүүлгэж, хоцрогдсон тоног төхөөрөмжийг нь сайжруулах, байгальд ээлтэй технологийг ашиглахад анхаарал тавьсан нь үр дүнгээ өгч байна.

Саппоро хотын дарга Уеда Фүмио “Амьдралд хор хөнөөлгүй дахин ашиглаж болох энергийн үүсвэрийг олох ажил чухлаар тавигдаж байна” хэмээн онцолсон бол Японы нэгэн судлаач Улаанбаатарын утааг хараад “...ийм байхад монгол хүн яаж эрүүл, урт удаан насалж, ажлын бүтээмж дээшлэх юм бэ” хэмээн сэтгэл зовнин өгүүлсэн билээ. Энэ чигээрээ байвал Улаанбаатар хэзээ ч “моодонд” орохгүй гэдгийг тэрбээр нэмж хэлсэн юм. Нэг үгээр хэлбэл, Улаанбаатарыг дэлхийн “vip” хот болгоход иргэдийн оролцоо, төрийн зангидсан тогтвортой бодлого хэрэгтэй болохыг арал дээр амьдрах Японы судлаач хуурай газрын монголчуудад хандан хэлэв.

Эрс тэс уур амьсгалтай Төв Азийн цээжинд буй Монгол Улс сул талаа яагаад боломж болгоод ашиглаж болохгүй гэж. Үүнийг л газар газрын

хотын дарга нар ярьж байв. Тэнгис далайг гаталж ирсэн стандарт бус автомашин, ямар ч боловсруулалтгүй түүхий нүүрсийг хэрэглэж байгаа нь агаар бохирдох анхны шинж тэмдэг гэнэ. Түүнчлэн нүүрс боловсруулах үйлдвэр барих дэд бүтэц, эрчим хүчний хамгийн ойрын тэргүүн туршлага өмнө нь байхад монголчуудад өөрсдөд нь учир хийгээд асуудал байгааг тэд онцлон хэлж байна билээ. Жишээлбэл, “Түүхий нүүрсийг шатаахгүй байх, томоохон аж үйлдвэрийг хотоос алсад шилжүүлэх, гэр хорооллын иргэд түүхий нүүрснээс татгалзах, нүүрс боловсруулах төв байгуулах, төвлөрсөн дулаан хангамжийн систем бий болгох, автомашины хорт утааг бууруулах, хуучин автомашиныг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байхад анхаарахыг Хятадын Чичихар хотын даргын туслах Гуо Шү Рэн зөвлөлөө. Чичихар хотын хувьд агаарын бохирдлын хяналтыг чангатгаж, хууль дүрмээ ягштал баримталдаг аж. “Өвлийн хотуудын Дарга нарын холбоо” нь өөр хоорондоо тохиолдож буй хөгжлийн эмзэг асууд-

луудаа хэрхэн засаж, сайжруулах талаар хэлэлцдэг байна.

1981 онд Япон улсын Саппоро хотынхон энэхүү холбоог санаачилж дэмжлэг аван, үйл ажиллагаагаа явуулж ирсэн бөгөөд 15 дахь чуулга уулзалтаа Монголд хийсэн нь энэ. Холбоонд 10 орны 20 гаруй хот элссэн байна. Харин Улаанбаатарын талаар ярих зүйл чамгүй их байсан. Нэг уулзаад шийдчих асуудал биш гэдгийг мэдэх учраас л тэд энэ удаагийн чуулга уулзалтаа угааны голомт болсон Улаанбаатарт гурван өдрийг зориуллаа. “Улаанбаатар хотын хүн амын тоо 2020 он гэхэд одоогийнхоос 40-60 хувиар өсөх төлөвтэй байна” хэмээн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Г.Мөнхбаяр тэмдэглэсэн.

Эстонийн хойд эргийн хотууд нь аж үйлдвэржсэн аж. Тиймээс тэнд агаарын бохирдол бас л том асуудал гэнэ. Зөвхөн Улаанбаатар агаарын бохирдолтой тэмцээд байгаа бус энэ асуудал нь дэлхийн цөөнгүй орны толгойны өвчин болжээ. ■

KHATAN TUUL
Pure Water

Packaging quantity of Pure water:
 0.35 L /bottled/
 0.6 L /bottled/
 1 L /bottled/
 19 L /ballon/

Маркетинг: 99071655
Захиалга авах утас: 70173386
Факс: 976-11-70174494

Produced and bottled by "Welmon Trade" Co., Ltd of Mongolia

Технологи

2011 оны хамгийн ирээдүйтэй ногоон технологийн үйл явц, шийдлүүд

С.Жавхлан



Замын түгжрэлгүй хот

Замын түгжрэлээс болж ажилдаа хоцрохгүй, машинаа тавих газар хайж энэ тэрүүгээр явахгүй гээд бодоод үз дээ. Дуу дуугаа авалцсан машины дуут дохио, утааны оронд унадаг дугуй, нийтийн тээвэр, явган хүний зам байгуулах ажил зарим хотод өрнөжээ. Өнгөрөгч онд Богота, Монтрейл, Цюрих зэрэг хотод автомашингүй бүсийг байгуулжээ. Хот төлөвлөлтийн өвөрмөц, оновчтой шийдэл болсон энэ бүсэд хүүхдийн сургууль, цэцэрлэг гэх мэт байгууламжууд багтдаг бөгөөд нийтийн унадаг дугуйгаар эдгээр бүсээр аялах боломжтой юм. Харин энэ жил Нью-Йоркоос эхлэн Хятадын Ганжоу хот хүртэл энэ төрлийн бүсүүд байгуулагдаж байгаа аж.

Барилгын үр ашгийн тэсрэлт

2011 онд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд барилгын эрчим хүчний үр ашигт байдалд анхаарлаа хандуулах болжээ. Тухайлбал, АНУ-ын Засгийн газраас төрийн өмчит болон хувийн өмчит барилгуудын эрчим хүчний үр ашигтай байдлыг дээшлүүлэх зорилгоор хэдэн их наяд ам.доллар зарцуулжээ. Бизнесийн байгуулагууд ч тэр эрчим хүчийг үр ашиггүй зарцуулахгүй байх талаар олон оролдлого хийж байгаа аж. Тухайлбал, өнгөрсөн жил Энержи-Стар “Energy star” шагналыг өөрсдийн Нью-Жерси дахь мэдээллийн төвөө нарны энергийг ашиглан цахилгаанаар тэжээж буй KPMG байгууллага хүртжээ. Ингэснээр жилдээ 4.4 сая ам.доллар хэмнэдэг хэмээн мэдэгдэв. Мөн нийт цахилгааны 30 орчим хувь нь барилгын салбарт зарцуулагддаг Хятад улс энэхүү тоог ирэх зургаан жилд 50 орчим хувиар багасгах төлөвлөгөө гаргаад байгаа юм.



“Ногоон” олон нийтийн байгууллагууд

Тэр болгон хүний санаанд “ногоон” байдлаар ороод байхгүй олон нийтийн газрууд цэнгэлдэх хүрээлэн, цанын бааз зэрэг газар энэ салбарт хүч түрэн оржээ. Дээр дурдсан Нью-Йоркийн автомашингүй бүс нь эдний нэг юм. Үүнээс гадна Англид хамгийн анхны цахилгааны хэрэглээгээ 100 хувь салхины эрчим хүчээр хангадаг цанын бааз нээгдсэн байна. ■



Шинэ санаа ба бизнес

Эрэлт ба нийлүүлэлтийн тавцан

Х.Хулан

Штефан А.Фишер нь Германы Мюнхен хот дахь “FV Messe” нэртэй үзэсгэлэн худалдаа зохион байгуулдаг агентлагийн гүйцэтгэх захирал юм. Тэрбээр Швейцарийн Женев хотноо төрсөн бөгөөд Технологийн их сургуулийн инженерийн ангийг төгссөн байна. Фишер зөвлөх компани ажиллуулж, олон улсын бизнесийн байгууллагуудтай хамтарч ажиллаж байсан туршлагатай нэгэн. Тэрбээр хожуу Швейцарийн үзэсгэлэн зохион байгуулах салбараас гарч өөрийн гэсэн бизнес эрхэлсэн байна. “FV Messe” нь дэлхий дахинд алдартай Германы үндэсний павилионыг зохион байгуулагч албан ёсны байгууллага юм. “Фьючюр Монголиа- 2012” үзэсгэлэн нь энэ оны тавдугаар сарын 16-19-нд Германы инженерийн холбоо (VDMA), “VF Messe” компани, дотоодын түнш Аммак МГЛ болон “Интеркансалтинг” ХХК-тай хамтарч Буянт Ухаа дахь “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын дэргэдэх Спортын цогцолборт зохион байгуулагдана.

-Та өргөжин тэлж чадсан энэхүү бизнесийн санаагаа анх яаж олсон бэ?

“FV Messe” агентлаг нь 2000 онд Германд байгуулагдсан. Уг бизнесийг эрхлэх санаа анх Германд үзэсгэлэнд оролцохоор ирж буй компаниудад үйлчилгээ үзүүлэхээс эхэлсэн ба удалгүй хамтран ажиллаж эхэлсэн байгууллагууд ч сэтгэл хангалуун манай үйлчилгээг авах болсон юм. Хэрвээ би зах зээл дээр өөрийн авахыг хүссэн барааг олохгүй бол өөрөө түүнийг бий болгодог. Энэ бол миний зарчмын философи. Үйлчлүүлэгчдийн төлөө бид өөр агентлагаас түр ажилтан авах хэрэгцээ гардаг байсан. Гэвч чанарын хувьд миний санасан шиг байгаагүй. Тиймээс өөрийн агентлагийг нээсэн. Энэ нь удалгүй Мюнхен хотод үзэсгэлэн худалдааны гэрээт үйлчилгээ үзүүлдэг томоохон байгууллагуудын нэг болж чадсан.

Бид Германы үзэсгэлэнг гадаадад албан ёсны байдлаар зохион байгуулагч болох зөвшөөрлийг холбогдох байгууллагаас өргөдөл гаргаж авсан.

Ингэж бид Германы Эдийн засгийн яамны даалгавраар Германы аж үйлдвэрийн салбарыг олон улсын үзэсгэлэн худалдаанд төлөөлөн оролцох болсон билээ. Өдгөө Хятадаас Бразил хүртэл олон улсад үйл ажиллагаагаа явуулж байна.

“Фьючюр Монголиа -2012” үзэсгэлэнг яагаад зохион байгуулах болсон, онцлог, ач холбогдлынх нь талаар ярихгүй юу?

-2010 оны есдүгээр сард Германы инженерийн холбоо, архитекторч Йюрген Фогел болон манай компани нь Германы талын үзэсгэлэн худалдааг “Дисковер Монголиа” дээр төлөөлөн зохион байгуулсан. Бид Германы Засгийн газартай хийсэн гэрээт ажлаа тун амжилттай гүйцэтгэсэн. Ер нь Монголын энэ их нөөц бололцоог харахгүй өнгөрөх нь харалган явдал болно. Мэдээж ганц уул уурхай биш, уул уурхайг дагалдан орж ирэх бусад салбар нь маш чухал. Тиймээс үүнийг хэрхэн хийх вэ гэдэг агуулгыг би боловсруулсан. Ингээд тусгайлан олон улсын үзэсгэлэн худалдааг зохион ▶

► байгуулдаг дагнасан байгууллагын архитектор Фогелтэй хамтран байгуулсан. Өнөөгийн FV үзэсгэлэн худалдаа агентлаг гэдэг нь өөрсдийн овог Фогел, Фишерээр нэрлэн байгуулсан түүхтэй юм.

-Хамгийн сүүлд хаана ямар үзэсгэлэн зохион байгуулсан бэ?

-Майамид аялал жуулчлалын компаниудыг сурталчлах үзэсгэлэн зохион байгуулсан. Герман улсаас 30 гаруй байгууллага тус арга хэмжээнд оролцсон. Тэрний өмнө Миннеаполист төмөр замын үзүүлбэр гаргасан. Өнгөрсөн жил Туркт барилгын үзэсгэлэн гаргасан. Ер нь үзэсгэлэн худалдаа гэдэг нь аливаа бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэгчид болон худалдаж авах боломжит үйлчлүүлэгчид нарын уулзах тавцан гэж энгийнээр тодорхойлж болно. Бидний ажил бол энэхүү хоёр талын харилцааг аль болох ямар ч асуудалгүй явуулахын тулд газар дээр нь зохион байгуулах явдал юм. Эртний үгэнд “Та морио усны дэргэд авчирч болно гэхдээ морь өөрөө ундлах ёстой” гэдэг сайхан үг байдаг.

-Монголд хийх үзэсгэлэнд бусад газраас тусламж дэмжлэг авсан уу?

-Бид эхнээсээ л Улаанбаатар дахь Германы Элчин сайдын яам болон Монголын Засгийн газраас маш их дэмжлэг авсаар ирсэн. Ер нь хаана ч үзэсгэлэн гаргасан тухайн оронд буй Элчин сайдын яамнаас жишээлбэл Москва, Лондоны Элчин сайдын яамд гээд үргэлж хамтран ажиллаж зөвлөгөө өгсөөр ирсэн. Үүний дараа бид түнш хайх эрэлд гарч, Аммак МГЛ гэдэг Монголд нэлээд өргөн сүлжээтэй ажилладаг Герман компанитай холбоо тогтоосон. Өнгөрсөн оны тавдугаар сард бид Монголд ирж нийгэм, эдийн засгийн томоохон төлөөлөгчидтэй уулзаж, зөв санаачлага гаргаж байгаагаа баталгаажуулсан юм.

Энэ үед бүгд л ийм үзэсгэлэн үнэхээр хэрэгтэй гэдэгт санал нэгтэй байсан. Гол асуудал бол хэрхэн үүнийг хийх вэ гэдэгт оршиж байв. Тиймээс дан ганц уул уурхай барилгын салбар биш харин дагалдан ирэх олон салбарыг татан оролцуулах хэрэгтэй гэсэн санааг бидний зүгээс гаргасан. Үзэсгэлэнд улс орны тогтвортой хөгжилд хувь нэмэр болох бүх зүйлийг оролцуулах хэрэгтэй гэж үзсэн. Тогтвортой хөгжил гэдэг нь улс орны хөгжлийн хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг мөн.

Хэрвээ хөдөө нутаг сүйрвэл

нүүдэлчин ард түмэн хэрхэн аж төрөх вэ? Тогтвортой байдал нь хөгжил болоод аж үйлдвэрийн эсрэг зүйл биш ээ, харин шинэ ажлын байр, гарц, хөгжлийг л авчрах ёстой.

-Олон улсын үзэсгэлэн зохион байгуулагчийн хувьд биелүүлэх ёстой хамгийн гол журам юу вэ?

-Тэгэхээр үзэсгэлэн зохион байгуулагч нь эрэлт ба нийлүүлэлтэд үзүүлэх өөрийн үйлчилгээ үзүүлэгчийнхээ үүргийг нэн түрүүн ухамсарласан байх хэрэгтэй. Бид тавцанг үүсгэж байгаа бөгөөд тэдэнд үйлчлэх ёстой. Хамгийн түрүүнд зохион байгуулагч нь тухайн мэргэжлийн салбарын туршлага мэдлэггүй бол тухайн асуудлаар хэзээ ч бүү зөвлөгөө өгч, мэтгэлц. Үзэсгэлэн бол маш чухал учир үндэсний эдийн засагт нөлөөлөхийг оролдсон ямар нэг улс төрийн зэвсэг болох ёсгүй. Тэгээд ч тухайн үзэсгэлэн нь Засгийн газар ба орон нутагт үр өгөөжөө өгч тэднийг оролцуулах учраас бид бол зөвхөн үйлчилгээ үзүүлэх ёстой гэдгийг маш сайн анхаарч, үүнийгээ мартаж болохгүй. Дунджаар арван үзэсгэлэнгээс гурав нь ирээдүйд ашиг олдог. Үүнээс долоо нь хэдэн жилийн дараа ор сураггүй алга болно. Үүний нэг шалтгаан нь зохион байгуулагчийн зүгээс гаргасан алдаа байдаг. Хэрэв зохион байгуулагч яг багш шиг зааж эхэлбэл үзэсгэлэн урт удаан наслахгүй. Энэ бол угаасаа бидний үүрэг биш харин бид зөвхөн тусалж дэмжих л ёстой гэдгийг санах ёстой.

-Таны бодлоор энэхүү үзэсгэлэн Монголд юу авчрах вэ?

-Монголд өндөр технологи, мэргэжилтнүүд хэрэгтэй. Учир нь, нийлүүлэлт нь эрэлтийг хангах нөхцөл тавигдаж, бизнесийн харилцааг хөнгөвчилнэ гэсэн үг. Үүгээр дамжуулан бид зах зээл дээр юу бэлэн байна мөн ямар шийдэл болон технологи нь тухайн улсын асуудлыг шийдэхэд хэрэгтэй гэдгийг харуулна. Тиймээс ийм төрлийн үзэсгэлэн байхгүй байсан бол шийдвэр гаргагчид зөв шийдвэр гаргахын тулд дэлхий даяар аялж, хэрэгцээтэй мэдээллээ олж авахын тулд маш их цаг хугацаа зарцуулах юм. Эрэлт ба нийлүүлэлтийг нэг дор авчрах гэдэг нь шийдлийг үйлдвэрлэж, нийлүүлдэг аж үйлдвэрийн салбартай нүүр тулан уулзахыг хэлж байна. Энэ нь Монголд ашигтай.

-Дэлхийн стандартад нийцсэн үзэсгэлэн хийхэд Монголд байр савны асуудал тун хүнд байдаг. Үүнийг яаж шийдэж байгаа вэ?

-Мэдээж нийслэл хотод өөрийн гэсэн зориулалтын үзэсгэлэн гаргах талбай хэрэгтэй. Үүнийг хэн нэгэн нь дараа нь чанарын өндөр түвшинд байгуулна гэдэгт итгэж байна. Гэхдээ эн түрүүнд хөгжлийн зүтгүүр болсон уул уурхайн үйлдвэрлэлийг өндөр технологиор хангах ёстой. Зах зээлийн нөөц бололцоо ихтэй учраас Улаанбаатар нь худалдааны үзэсгэлэн гаргаж байх хэрэгтэй. Ингэснээр Монгол Улс нь өндөр технологи худалдан авах бүрэн боломжтой болно. Энэ бол хэрэгцээ.

-Үзэсгэлэн зохион байгуулах төрлүүдийн талаар бидэнд мэдээлэл өгөхгүй юу?

-Жишээ нь Америк болон Европт үзэсгэлэн гаргахад өөр өөр байдаг. Америкт үзэсгэлэнд оролцож талбай авч байгаа хүн тутамд есөн ам метр талбай олгодог. Европын хувьд бидний зүгээс үзүүлэх үйлчилгээнд тохируулан нэлээд уян хатан байдлаар ханддаг. Америкийн хувьд эрэлттэй хэсэг нь үзэсгэлэнг зохион байгуулж нийлүүлэлт талаа урьдаг. Харин Европт бол нийлүүлэлт талуудыг нэг дор цуглуулж, эрэлтийг дууддаг.

-Манай улсын хувьд та ямар төрлийн тоног төхөөрөмжийг санал болгох вэ?

-Танай орны усны хомсдол нь усны судалгаа хийх болон ашиглалтад хамгийн шилдэг технологийг шаардаж байна. Та бүхэн усаа дахин ашиглах хэрэгтэй. Ийм төрлийн технологи нь туйлын чухал. Үзэсгэлэнд оролцогчид ийм төрлийн технологи оруулж ирнэ гэдэгт найдаж байна. Хэрэв энэ удаа биш юм гэхэд дараагийн удаа болох юм. Бид “Фьючюр Монголиа” үзэсгэлэнг уламжлал болгон зохион байгуулна гэж төлөвлөж байгаа. Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчлүүлэгчийнхээ хэрэгцээг олж харах ёстой.

-Танд нэмж хэлэх зүйл байна уу?

-“Фьючюр Монголиа-2012” үзэсгэлэн нь үнэгүй байхаас гадна хотын төвөөс үзэсгэлэн болж байгаа газар луу автобусаар үйлчилнэ. Үүнээс гадна инженерийн чиглэлээр сурч байгаа монгол оюутнуудыг урьж оролцуулна. Ингэснээр тэд бодит байдалд улам илүү ойртон салбарын мэргэжилтнүүдтэй нүүр тулж уулзан бизнес гэж юу болохыг илүү сайн ойлгоно. Сурч байгаа хугацаанд онол илүү сурдаг боловч ажлын талбар дээр бизнес хийхэд ямар байдаг талаар өөрийн биеэр үзэх нь туйлын чухал. Тиймээс тэдэнд аж үйлдвэрийн үнэрийг үнэртүүлж, мэдрүүлэх хэрэгтэй байна. ■

Ажлын багийг хэрхэн зөв бүрдүүлэх вэ?

Ажлын багийг хэрхэн зөв бүрдүүлэх вэ?

Амжилтын 70 хувь нь тухайн ажил, төслийг хэрэгжүүлэгч хамт олноос шууд хамаардаг. Кампанит ажил санасанд хүртэл хийгдээгүй гэдэг нь багаа буруу бүрдүүлсэнтэй холбоотой аж. Гарааны бизнесийг нураадаг зүйл бол үл итгэлцэл, зорилгоо буруу зөрүү ойлгох явдал юм. "Мөрөөдлийн баг"-ийг харин хэрхэн бүрдүүлэх вэ?

"Ингрия" бизнес инкубаторын зөвлөх Сергей Подузов дараах зөвлөгөөг өгч байна.

Гарааны бизнесийн багийг бүрдүүлэхэд юуны өмнө итгэлцэл хамгийн чухал үүрэгтэй. Хамт олон нэг баг болж, гишүүд бие биедээ дээд зэргээр итгэж, үүнийг юу ч эвдэж чадахгүйгээр уусаж нэг болохыг хэлнэ. Тэгсэн тохиолдолд л жинхэнэ ажил эхлэнэ.

Итгэлцлийг хэрхэн бий болгох вэ?

Гарааны бизнес эрхлэгчид өөрийн гэсэн ажилтантай байх хэрэгтэй. Гэрээт ажилчид, хамтран зүтгэгчид байх нь сайн хэрэг ч багийн цөм хэсэг байнгын байх шаардлагатай. Хоёрт, ажлын төсөөлөл тод оновчтой, багийн бүх гишүүдийн байр суурь ойлгомжтой байх ёстой. Төсөөлөл гэдэг нь компанийг амжилтад хүргэх хүчин зүйлс бөгөөд энэ нь багийн нийт гишүүдэд зориулсан нэгдсэн чанартай байна. Үүнийг боловсруулна уу гэхээс өөрөө бүрэлдээд ирдэг зүйл биш.

Хамт олны хоорондын харилцаа эв найртай байх нь мөн туйлын чухал. Ийм харилцаа нь сард нэг удаа скайпаар харилцах хэлбэрээс илүү долоо хоногт дор хаяж нэгээс хоёр удаа хуралдан шийдвэрлэх асуудлаа ярилцаж байх хэрэгтэй. Хэдий хэр ойр ойрхон уулзаж ярилцана, төдий чинээ харилцаа дотно болж, багийн гишүүдийн итгэлцэл бэхжинэ. Энэ бол мөрдөх анхны дүрэм.

Гуравт, хамтран зүтгэгчид ба компанийн алсын хараа, зорилгоо сайтар ухамсарласан байх явдал. Багийн гишүүн бүр өөрийн гэсэн хувийн зорилго мөрөөдөлтэй ч бүх ажилтныг холбосон нийтийн зорилгууд байх ёстой. Иймээс гишүүн бүрийн хүсэл эрмэлзлэлийг сайтар ойлгож, энэ нь компанийн ерөнхий зорилгод хэрхэн нийцэхийг ойлговол зохистой.

Дөрөвт, ерөнхий захирал, маркетингийн захирал хоёрын ажил үүргийн хуваарь, эрх мэдэл хил хязгаартай байх хэрэгтэй ч бусад гишүүд юу хийж байгааг заавал мэдэж байх шаардлагатай. Миний ажлын хүрээ зөвхөн маркетинг, бусад юм надад хамаагүй гэсэн хандлага байж болохгүй.

Юуг анхаарлын төвд байлгах вэ?

Ихэнх тохиолдолд хамтран ажиллагсад компанийн зорилго, зорилтоо мартаж, хаашаа явж байгаагаа, 3-5 жилийн дараа байдал ямар болсон байх талаар төсөөлөлгүй

явдаг. Жобс, Возняк хоёр Apple брэндийн бүтээгдэхүүнээ бүтээж байхдаа маш тодорхой зорилготой байсан. Тэр нь хамгийн сайн дизайнтай, хамгийн сайн хэрэглээний компьютер хийх. Компани үүний л төлөө ажиллаж, хамт олноороо зорилгоо мэддэг байсан. Зорилго байхгүй газар ажилчид муу ажилладаг. Учир нь, компанийн алсын хараа бол цалин, материаллаг урамшууллаас илүү чухал юм.

Анхнаасаа сайн баг бүрдүүлнэ гэж бараг байдаггүй. Миний хувьд эхлүүлсэн төслүүд дуусан дуустал багийн бүрэлдэхүүнээс ганц нь ч үлдэж байгаагүй. Нэг хэсэг хүмүүстэй эхлээд л нөгөө хэсэгтэй ажлын эцсээ дуусгах явдал нэг бус удаа тохиолдож байсан. ОХУ-ын хэмжээнд мэдээлэл технологийн багууд сайн хамтран ажиллаж чадаж байна. Өндөр технологийн салбарынхан ихэнхдээ хоорондоо ижил төстэй зорилготой, ангийнхантайгаа хамтарч бизнес хийсэн төгсөгчид байдаг.

Ихэнх технологийн компанийн багт их, дээд сургуулийн настай профессор, бусад нь харин тэдний оюутнууд юмуу аспирантууд байх тохиолдол ОХУ-д олонтаа тохиолддог. Үүний үр дүнд профессор багт шахалт дарамт үзүүлж, бүх юмыг өөр дээрээ төвлөрүүлэхийг хүсдэг. Мөн тэрбээр бизнес эрхлэхээсээ илүүтэйгээр туршилт судалгаа явуулахыг зорьдог. Багийн залуу гишүүдийн хувьд судалгааг арилжаанд хүргэж, бүтээгдэхүүн гарган борлуулах. Шинжлэн ухааны салбарынхны цалин ч тэр бүр боломжийн байж чаддаггүй. Үүний үр дүнд технологийн төслийн багийг цуглуулах хамгийн хүнд болдог бөгөөд залуу хамтран зүтгэгчид хэсэг хугацаанд ажиллаж байгаад дараа нь өөрийн замаа хөөдөг тохиолдол бий. ■

Эх сурвалж: <http://www.unova.ru>



Бизнесийн завсарлага

Таны амьдрал, үзэл бодолд өөрчлөлт авчирсан номоо нэрлэнэ үү?


Алишер Али

/“Еврази Капитал” хөрөнгө оруулалтын банкны захирал/:

Өрнө Дорныг хоёр мянга гаруй жилийн турш холбож байсан, маш эртний түүхтэй Торгоны замын тухай би олон жил сонирхож судалсан. Тийм ч учраас “Торгоны зам: хуврагууд, цэргүүд ба худалдаачид” номыг шимтэн уншсан. Эл номыг зохиогч Льюс Булноу /Lucy Boulnois/ нь Францын Торгоны зам болон Транс-Хималайн нурууны худалдааны талаарх нэрт судлаач болно.

Номын үйл явдал нь дэлхийд алдартай эзэнт гүрнүүд, домогт баатрууд ба хотууд, өндөр өртөг бүхий сонин содон бараа таваар нь Торгоны зам дагуух худалдааг үүсгэн бий болгосныг бодитоор дүрсэлсэн байдаг. Зохиогч нь Өрнө Дорнын маш өргөн хүрээ бүхий харилцааг өгүүлж, архелогийн болон

судалгааны олдвор дээр үндэслэн гаргасан баримтад тулгуурлан тэдгээрийн хоорондын бие биедээ үзүүлсэн нөлөөг дүрслэн бичсэн аж. Үүнээс гадна Монголын эзэнт гүрний үүсэл болоод түүний өргөжин тэлж буй худалдаанд улс төрийн байдлаар нөлөөлөл тогтоож байгааг дүрсэлсэн Pax Mongolica (Латинаар Монголын энх тайван гэсэн үг)-ийн тухай хүүрнэсэн байна. Торгоны зам дагуух бараа таваар, хүмүүс болон оюуны солилцоо нь эргээд дэлхийн хамгийн том иргэншлүүд болох Хятад, Энэтхэг, Перс, Араб, Эртний Ром болон бусдад ач холбогдол бүхий нөлөө үзүүлсэн. Үүний үр дүнд хэдэн зуун жил дамнасан соёл иргэншлүүдийн өөр хоорондын солилцоо нь орчин үеийн ертөнцийн суурийг тавьсан байна.



Н.Алгаа

/Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал/:

-Америкийн индиануудын тухай цуврал номнууд миний үзэл бодол, төлөвшилд их нөлөөлсөн. Тухайлбал, Джэймс Фенимор Куперын бичсэн “Сүүлчийн Могикан”. Тэр ном надад аливаад сэтгэлээсээ үнэнч, туйлбартай байх зан чанартай болоход их түлхэц өгсөн. Энэ номын баатруудтай адил байхыг хүсдэг

байсан. Индианчуудтай адилхан болсон нэг англи анчин байгаа. Шударга хүн гэж байдаг бол улаан цагаан хамаагүй байдаг. Цагаан арьстай анчин, индианы омгийн толгойлогч нь шударга зан, эрх чөлөө, байгальд хайртай тийм дүүрд гардаг. Тэр нь миний төлөвшилд их нөлөөлсөн.



Б.Аюуш

/UGS ХХК-ийн хөрөнгө оруулалт, санхүүгийн зөвлөх/:

-Эдийн засагч, судлаач орчуулагч Х.Болорболдын орчуулсан “Урхи: бидний эрх чөлөөний мөрөөдөл юу болчихов оо” /Англи хэл дээр The Trap: What happened to Our Dream of Freedom/ номыг нэрлэнэ. Энэхүү номын зохиолч нь Английн баримтат кино бүтээгч Адам Кёртис. Тэрбээр нийгэмд тулгамдаж байгаа том асуудлыг судлаад, телевизийн баримтат кино хийдэг. Олон улсын хэмжээнд нэр хүнд бүхий шагналуудыг хүртсэн уран бүтээлч. Энэ ном юугаараа анхаарал татсан бэ гэвэл бид нар барууны, америк маягийн ардчилсан амьдралыг сонгоод 20 гаруй жил болж байна. Энэ хугацаанд Монгол Улс илүү хөгжив үү, бидний амьдралд яаж туссан бэ гээд харахад сайн гэдэг дүн тавих аргагүй байна. Нийгэмд баян, ядуугийн ялгарал маш хүчтэй боллоо. Монгол хүн малынхаа буянаар өлсөж, хог идэж үзээгүй гэж

ярьдаг. Гэтэл өнөөдөр өлсөж байгаа, хог түүдэг эмгэнэлтэй дүр зураг хаа сайгүй харагдаж байна. Зарим талаар бол монголчууд дэлхий ертөнцөд нээлттэй болсон, хүссэн мэдээллээ авч, бодож санаж байгаагаа илэрхийлэх эрхтэй болсон гээд ололттой гэж хэлж болох талууд цөөнгүй бий. Монгол хүн дэлхийн аль ч их, дээд сургуульд очиж өндөр боловсрол эзэмших боломжтой болсон. Эдгээр сайн, муу гэж хэлж болох үр дагаврыг харьцуулах юм бол муу нь хавьгүй илүү. Яагаад гэвэл ядуурал газар авч, дээрээс нь оюуны хоцрогдолд орсон. Хүчирхийлэл, гэмт хэрэг, архидалт, авлига цэцэглэхчээд байна. Энэ бол яг ийм асуудлыг хөндсөн баримтат кино. Чөлөөт зах зээлийн энэ замаар явж байгаа замыг эргэж харах болсон гэдэг тухай орчуулагч бичиж дүгнэлт гаргасан байгаа. Энэ ном олон зүйлийг эргэцүүлж бодоход хүргэсэн. ■



www.mongolianeconomy.mn

